



**"МОН ГАЗАР ЭКОЛОГИ" ХХК**

Байгаль орчны нөхөнх байдлын нарийвчилсан үнэлгээ,  
зөвлөгөөний мэргэжлийн байгууллага

## **БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН**

**“Эм Си Пи Си жр” ХХК**

**“Өмнөдэлгэр-Биндэр-115 км хатуу хучилттай автозам” төсөл**



**УЛААНБААТАР ХОТ  
2021 ОН**



**"МОН ГАЗАР ЭКОЛОГИ" ХХК**

Байгаль орчны нийөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ,  
зөвлөгөөний мэргжлийн байгууллага

## **БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН**

*"Эм Си Пи Си жр" ХХК*

*"Өмнөдэлгэр-Бийдэр-115 км хатуу хучилттай автозам" төсөл*

**Батлав:**

**“Эм Си Пи Си жр” ХХК-ийн захирал**



**Б.Ананда**

**“Мон Газар Экологи” ХХК-ийн захирал**

**Г. Болдбаяр**

**Боловсруулсан:**

**“Мон Газар Экологи” ХХК-ийн мэргжилтэн**

Б.Баярцэцэг  
Б.Нямдаваа  
Б.Даваажаргал  
Д.Идэрбат  
Д.Зүмбэрэлмаа

## ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

<b>ОРШИЛ</b>	<b>5</b>
<b>БҮЛЭГ 1. ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b>	<b>9</b>
1.1. Төлөв байдлын үнэлгээний гол зорилго	9
1.2. Төлөв байдлын үнэлгээний хүрээнд хийсэн ажлууд	9
1.2.1. Мэдээлэл цуглуулах бэлтгэл ажил	9
1.2.2. Хээрийн судалгаа шинжилгээний ажил	10
1.2.3. Суурин боловсруулалт	10
1.3. Судалгааны ажлын гол үр дүн	11
<b>БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b>	<b>12</b>
2.1. Төслийн нэр	12
2.2. Төслийн зорилго	12
2.3. Төслийн туслан гүйцэтгэч	12
2.4. Төслийн талбайн байршил	12
<b>БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ</b>	<b>13</b>
3.1. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, талбайн байршил	13
3.2. Төслийн талбай орчмын физик газарзүйн тодорхойолт	13
<b>БҮЛЭГ 4. УУР АМЬСТАЛ</b>	<b>17</b>
4.1. Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсталин үндсэн үзүүлэлтүүд	17
4.2. Төлөвлөж буй авто замын уур амьстал, геотехникийн нөхцөл	19
<b>БҮЛЭГ 5. АГААР ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ</b>	<b>23</b>
5.1. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд	23
5.1.1. Чингис хотын агаарын чанарын төлөв байдал	23
5.2. Төслийн талбай орчмын агаар орчны хяналт шинжилгээ	25
5.3. Агаар орчны төлөв байдал нөлөөлөх хүчин зүйл	30
5.4. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийзэх, бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж	31
<b>БҮЛЭГ 6. ФИЗИК БОХИРДОЛ, ХОГ ХАЯГДАЛ</b>	<b>32</b>
6.1. Төсөл хэрэгжих талбайн дуу шуутианы хэмжилгээний үр дүн	32
6.2. Хог хаягдал	33
6.3. Хог хаягдлын менежментийн зөвлөмж	34
<b>БҮЛЭГ 7. ГЕОЛОГИЙН ТОГТОЦ, ГЕОМОРФОЛОГИ</b>	<b>37</b>
7.1. Геологийн тогтоц, геоморфологи	37
7.2. Төсөл хэрэгжих бүсийн ашигт малтмал, тэдгээрийн байршил	38
7.3. Физик-геологийн үзэгдэл, үйл явц	39
7.4. Цэвдэг	40
7.5. Газрын гадаргын налуужилт	41
<b>БҮЛЭГ 8. ГАДАРГЫН УС БА ГАЗРЫН ДООРХИ УС</b>	<b>42</b>
8.1. Гадаргын усны служээ, урсац, нөөц	42
8.2. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний орчмын томоохон гол, мөрөн, нуурын мэдээлэл	47
8.3. Судалгааны талбай орчмын гадаргын усны лабораторийн шинжилгээний үр дүн	49
8.4. Төслийн талбайн орчмын газрын доорх ус	51
<b>БҮЛЭГ 9. ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>	<b>54</b>
9.1. Төслийн талбай орчмын хөрсөн бүрхэвчийн шинж чанар, онцлог, төлөв байдал	54
9.2. Төлөвлөж буй замын трассын дагуу хийсэн хөрсний судалгаа	55
9.2.1. Судалгааны үр дүн	59
9.3. Хөрсний элэгдэл эвдрэл	64
<b>БҮЛЭГ 10. УРГАМЛАН НӨМРӨГ</b>	<b>67</b>
10.1. Ургамлан нөмрөгийн хэв шинж, зүйлийн бүрдэл, ангилал	67
10.1.1. Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг, түүний онцлог	69
10.1.2. Ургамлын зүйлийн бүлэгдлийн олон янз байдал	70
10.2. Ой	71

<b>БҮЛЭГ 11. АМЬТНЫ АЙМАГ</b>	<b>73</b>
11.1. Төслийн талбай орчмын амьтны аймгийн онцлог	73
11.1.1. Амьтдын тархац, неөц	75
11.1.2. Шувууд	82
<b>БҮЛЭГ 12. ТҮҮХ СОЁЛЫН ӨВ БОЛОН ТУСГАЙ ХАМГААЛАЛГТАЙ ГАЗАР НУТАГ</b>	<b>84</b>
12.1. Улс, аймгийн хамгаалалтанд байх түүх, соёлын дурсгал, археологи, палеонтологийн олдвор	84
12.1.1. Төслийн талбайн археологи, палеонтологийн судалгааны ажил	85
12.1.2. Дурсгалын тодорхойлолт	88
<b>БҮЛЭГ 13. ТУСГАЙ ХАМГААЛАЛГТАЙ ГАЗАР НУТАГ</b>	<b>104</b>
13.1. Төслийн талбай орчмын тусгай хамгаалалгтай газар нутаг	104
<b>БҮЛЭГ 14. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ</b>	<b>112</b>
14.1. Тасол хэрэгжих нутгийн нийгэм, эдийн засгийн төвч таницуулга	112
14.2. Хэнтий аймгийн нийгэм-эдийн засгийн төлөв байдал	112
14.3. Өмнөдэлгэр сумын нийгэм-эдийн засгийн төлөв байдал	114
14.4. Биндэр сумын нийгэм-эдийн засгийн төлөв байдал	117
<b>БҮЛЭГ 15. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ АРГА ЗАМ</b>	<b>121</b>
15.1. Байгаль орчны болзошгүй нөлөөлөл	121
15.2. Хог хаягдлын менежментийн зөвлөмж	123
15.2.1. Хог хаягдлын тухай хуулийн зөвлөмж	125
15.2.2. Хатуу хог хаягдлыг түр хадгалах сав байгуулж, ангилан ялгах менежментийг ўшигшилаанд хэрэгжүүлж ажилшах зөвлөмж	126
15.2.3. Ажигчдын кабинтай зөөврийн био ариун цэврийн байгууламж сууринуулах зөвлөмж	127
15.3. Агаарын чанарт үзүүлж болзошгүй серөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, ариглах арга хэмжээний зөвлөмж	128
15.4. Зам талбайн тоосжилтыг бууруулах зөвлөмжүүд	129
15.5. Газрын доорх усанд үзүүлж болзошгүй серөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, ариглах арга хэмжээний төвч зөвлөмж	131
15.6. Ургамлан нэмрөгт үзүүлэх серөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төвч зөвлөмж	132
<b>БҮЛЭГ 16. Байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө</b>	<b>134</b>
16.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний ажил (урьдчилсан байдлаар тоодов.)	135
<b>ЕРӨНХИЙ ДУГНЭЛТ</b>	<b>138</b>
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ</b>	<b>141</b>

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбай орчмын байрзүйн зураг .....	12
Зураг 2. Төслийн талбайн байршлын зураг .....	13
Зураг 3. Монгол орны физик газарзүйн мужлалтын зураг.....	14
Зураг 4. Төслийн талбай орчмын өндөршийн зураг .....	14
Зураг 5. Төслийн талбай орчмын өндөршийн зураг .....	15
Зураг 6. Төловлөж буй замын трассын эхэллийн цэг, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум. ....	15
Зураг 7. Төловлөж буй замын трассын дагуух орчны фото зураг .....	16
Зураг 8. Төловлөж буй замын трассын төгсгөлийн цэг, Хэнтий аймгийн Биндэр сум. ....	16
Зураг 9. Төсөл хэрэгжих орчны нарны радиац/жилийн дунджаар/.....	17
Зураг 10. Агаарын температурын олон жишийн динамик үзүүлэлт .....	18
Зураг 11. Төсөл хэрэгжих талбай орчмын хур тунадасны олон жишийн динамик үзүүлэлт .....	18
Зураг 12. Монгол орны авто замын уур амьсталын бүсчилэл.....	19
Зураг 13. Хэмжилт хийсэн цэгүүдийн байрлал .....	26
Зураг 14. Temtop air quality 1000, С.Е.М DT-8820 багаж .....	26
Зураг 15. АЧХЦ-01- агаар орчны хэмжилтын дун мэдээ, Эхэллийн цэг.....	27
Зураг 16. АЧХЦ-02- агаар орчны хэмжилтын дун мэдээ, трассын 20 дахь км-т.....	27
Зураг 17. АЧХЦ-03- агаар орчны хэмжилтын дун мэдээ, трассын 50 дахь км-т.....	27
Зураг 18. АЧХЦ-04- агаар орчны хэмжилтын дун мэдээ, трассын 70 дахь км-т.....	27
Зураг 19. АЧХЦ-05- агаар орчны хэмжилтын дун мэдээ, трассын 97 дахь км-т.....	27
Зураг 20. АЧХЦ-06- агаар орчны хэмжилтын дун мэдээ, Биндэр сум замын трассын 115 дахь км-т .....	28
Зураг 21. Орчны дуу шуугианы хэмжилтийн тооны үзүүлэлт .....	32
Зураг 22. Замын трассын дагуу дайралдах томоохон ус, нам гархаг газар, Хурхын их хөндий .....	40
Зураг 23. Монгол орны цэвдэгийн зураг .....	40
Зураг 24. Төловлөж буй трассын дагуу орчмын гадаргын налуужилт .....	41
Зураг 25. Замын трассын дагуу дайралдсан нуурууд .....	42
Зураг 26. Замын трассын дагуух худгууд .....	43
Зураг 27. Замын трассын дагуух голууд .....	43
Зураг 28. Төслийн талбайн гадаргын усны зураг .....	44
Зураг 29. Замын трассын төгсгөл хэсэг, Биндэр сум, 115 дахь км .....	44
Зураг 30. Замын трассын эхний 95-110 км орчмын байрзүйн зураг .....	45
Зураг 31. Замын трассын эхний 75-95 км орчмын байрзүйн зураг .....	45
Зураг 32. Замын трассын эхний 50-75 км орчмын байрзүйн зураг .....	45
Зураг 33. Замын трассын эхний 40-50 км орчмын байрзүйн зураг .....	46
Зураг 34. Замын трассын эхний 20-40 км орчмын байрзүйн зураг .....	46
Зураг 35. Замын трассын эхний 20 км орчмын байрзүйн зураг .....	46
Зураг 36. Замын трассын эхний 10 км-ийн байрзүйн зураг .....	47
Зураг 37. Усны дээж авсан цэгийн байршил .....	49
Зураг 38. Уст цэг -01. Өмнөговь аймгийн сумын төвийн худаг .....	50
Зураг 39. Уст цэг-02. Хурхын гол .....	50
Зураг 40. Уст цэг-03. Баян гол .....	50
Зураг 41. Хөрс газарзүйн мужлалтын зураг .....	54
Зураг 42. Төслийн талбайн хөрсний зураг .....	55
Зураг 43. Хөрсний дээж авсан цэгүүдийн байршил .....	59
Зураг 44. Хөрсний 1-р зусалтийн гадаргын зураг, цэгийн байршил .....	60
Зураг 45. Хөрсний 2-р зусалтийн гадаргын зураг, цэгийн байршил .....	60
Зураг 46. Хөрсний 3-р зусалтийн гадаргын зураг, цэгийн байршил .....	60
Зураг 47. Хөрсний 4-р зусалтийн гадаргын зураг, цэгийн байршил .....	61
Зураг 48. Хөрсний 5-р зусалтийн гадаргын зураг, цэгийн байршил .....	61
Зураг 49. Хөрсний 6-р зусалтийн гадаргын зураг, цэгийн байршил .....	61
Зураг 50. Замын трассын дагуух орчны харагдар байдал .....	66
Зураг 51. Монгол орны ургамал-газарзүйн мужлал (Грубов) .....	67

Зураг 52. Төсөл хэрэгжих замын трассын дагуу тархсан ургамлын анги, Монгол орчны болжсер ба хадлангийн ангилалаар .....	68
Зураг 53. Төлөвлөж буй замын трасс, түүний орчмын ойн зураг .....	72
Зураг 54. Монгол орны баданга хүдрийн тархац, байршилын судалгааны мэдээ (Биологийн хурээлэн 2010) .....	78
Зураг 55. Монгол орны халиун бугын тархац, байршилын судалгааны мэдээ (Биологийн хурээлэн 2010) .....	79
Зураг 56. Монгол орны бор гөрөөсний тархац, байршилын судалгааны мэдээ .....	80
Зураг 57. Монгол орны бор гөрөөсний тархац, байршилын судалгааны мэдээ .....	80
Зураг 58. Монгол орны бор гөрөөсний тархац, байршилын судалгааны мэдээ .....	81
Зураг 59. Хайгуулаар илрүүлсэн дурсгалын төвч мэдээлэл .....	86
Зураг 60. Хан Хэнтийн ДЦГ .....	105
Зураг 61. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг .....	106
Зураг 62. Аймаг, сумын тусгай хамгаалтад авсан газар нутгууд .....	107
Зураг 63. Онон-Балжийн БЦГ .....	108
Зураг 64. Биндэрьяа овоо .....	109
Зураг 65. Төслийн талбайн засаг захиргааны зураг .....	112
Зураг 66. Өмнөдэлгэр сум руу орох хэсэг, алсаас харагдах байдал .....	115
Зураг 67. Өмнөдэлгэр сумын малгын тоо /2015-2020/ .....	117
Зураг 68. Өмнөдэлгэр сумын малын тоо /2015-2020/ .....	117
Зураг 69. Биндэр сум, алсаас харагдах байдал .....	118
Зураг 70. Биндэр сумын малгын тоо /2015-2020/ .....	120
Зураг 71. Биндэр сумын малын тоо /2015-2020/ .....	120
Зураг 72. Гадаа талбайд байрлуулах хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах хогийн сав, байрны загвар .....	127
Зураг 73. “Евростандарт” био зөөврийн ариун цэврийн байгууламжийн харагдах байдал .....	127
Зураг 74. 16 тн-ны багтаамжтай тоосжилт дарах усалгааны автоцистерн .....	130
Зураг 75. Дастмагыг ашиглах төрлүүд .....	131

## ХУСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Салхины чиглэлийн давтагдал	19
Хүснэгт 2. Бүсийн үндсэн тодорхойлолт	20
Хүснэгт 3. Улирлын үргэлжлэх хугацаа	20
Хүснэгт 4. Хөрс, агаарын температурын (°C) үзүүлэлт	20
Хүснэгт 5. Хөрсний хөдөлгөөн-гэсэлтийн уур амьсгалын хугацаа	20
Хүснэгт 6. Авто замын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой болон тохиромжтүй улирлын үсүүд	20
Хүснэгт 7. Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил	21
Хүснэгт 8. Авто замын уур амьсгалын бусууд дах хур тунадасны хэмжээ, мм	21
Хүснэгт 9. Аянга, дуу пахилгаан	21
Хүснэгт 10. Нойтон цас, хялмаа, местнөг	21
Хүснэгт 11. Газрын гадрага дээрх цасны ачаалал	21
Хүснэгт 12. Хээр гадаа ажиллах авто замын ажилчдын хөдөлмөрийн био уур амьсгалын нөхцөл	21
Хүснэгт 13. Автозамын үйлдвэрлэл, замчдын хөдөлмөрт уур амьсгалын налөөллийг үзүүлэх итгэлшүүр	21
Хүснэгт 14. Автозамын уур амьсгалын бусуудэд халуун асфальт бетон холыц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа	21
Хүснэгт 15. Автозамын уур амьсгалын бусуудэд хүйтэн, булээн асфальт бетон хучилт хийхэд тохиромжтой хугацаа	22
Хүснэгт 16. Агаар бохирдуулагч бодисын шинж чанар, үүсэх эх үүсвэр	23
Хүснэгт 17. Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгүүдийн газарзүйн солбижцол	25
Хүснэгт 18. I Цэг- агаар орчны хэмжилтын дун мэдээ, Эхэлжийн цэг	28
Хүснэгт 19. Төсөл хэрэгжих талбайд хийсэн дуу чимээний хэмжилт	32
Хүснэгт 20. Монгол орны усны сав газрууд, тэдгээрийн усны нөөц	44
Хүснэгт 21. Онон голын зарим цутгал голын олон жилийн дундаж урсац	47
Хүснэгт 22. Дээж авсан цэгүүдийн газарзүйн солбижцол	49
Хүснэгт 23. Усны химийн задлан шинжилгээний дун	50
Хүснэгт 24. Усны химийн задлан шинжилгээний дун	51
Хүснэгт 25. Усны химийн задлан шинжилгээний дун	51
Хүснэгт 26. Хур тунадасны нэвчилгээний хувь	53
Хүснэгт 27. Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгүүдийн газарзүйн солбижцол	60
Хүснэгт 28. Хөрсний үргэлж шимт чанар	61
Хүснэгт 29. Хөрсний механик шинж чанар	63
Хүснэгт 30. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж	64
Хүснэгт 31. Ойн төрөл, талбайн хэмжээ	72
Хүснэгт 32. Төсөл хэрэгжих бус нутгийн онцлох статустай зүйлийн олон янз байдал	74
Хүснэгт 33. Цагаан зээрийн нөөцийн үзэлгээ	75
Хүснэгт 34. Халиун бугын нөөцийн үзэлгээ	75
Хүснэгт 35. Бор гореесний нөөцийн үзэлгээ	76
Хүснэгт 36. Зэрлэг тахайн нөөцийн үзэлгээ	76
Хүснэгт 37. Монгол тарваганы нөөцийн үзэлгээ	76
Хүснэгт 38. Саарал чонын нөөцийн үзэлгээ	76
Хүснэгт 39. Шар үнэгний нөөцийн үзэлгээ	76
Хүснэгт 40. Хэрс үнэгний нөөцийн үзэлгээ	77
Хүснэгт 41. Хэрс үнэгийн нөөцийн үзэлгээ	77
Хүснэгт 42. Төсөл хэрэгжих талбай орчмын шувуудын зүйлийн бүрдэл, тоо толгой, экологи, хоол тэжээл	82
Хүснэгт 43. Замын трассын дагуу илэрсэн дурсгалуудын зайн хэмжээ	88
Хүснэгт 44. Хайгуулаар илрүүлсэн дурсгалын товч мэдээлэл	101
Хүснэгт 45. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээлэл	104
Хүснэгт 46. Хэнтий аймгийн хүн амын тоо	113
Хүснэгт 47. Өмнөдэлгэр сумын хүн амын тоо	115

Хүснэгт 48. Биндэр сумын хүн амын тоо .....	118
Хүснэгт 49. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх .....	125
Хүснэгт 50. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг .....	125
Хүснэгт 51. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хориглох үйл ажиллагаа .....	126
Хүснэгт 52. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал .....	135
Хүснэгт 53. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал .....	135
Хүснэгт 54. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал .....	136
Хүснэгт 55. Ургамлан нэмрэгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал .....	136
Хүснэгт 56. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал .....	136
Хүснэгт 57. Байгаль орчин хамгаалах ажлын зардлын задаргаа .....	137

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Чингис хотын хүхэрлэг хийн агууламж, 2010-2020 .....	24
График 2. Чингис хотын азотын давхар ислийн агууламж, 2010-2020 .....	24
График 3. Чингис хотын том ширхэглэгт тоосонцрын агууламж, 2015-2019 .....	25
График 4. PM2.5, PM10 үзүүлэлтүүдийн хэмжилтийн цэгүүдийн тоон үзүүлэлт .....	29
График 5. Хэнтий аймгийн хүн амын тоо /2016-2020/ .....	113
График 6. Өмнөдэшгэр сумын хүн амын тоо /2016-2020/ .....	116
График 7. Биндэр сумын хүн амын тоо /2016-2020/ .....	119

## ОРИШИЛ

Тус “Мон газар экологи” ХХК нь Зам, тээвэр хөгжлийн яамны захиалгаар “Эм Си Пи Си жи ар” ХХК-ийн хүснэгтийн дагуу тус компанийт байгуулсан 2021.11.15-ны өдрийн БОУ-03/21 тоот ажлын тэрээг үндэслэн Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт сумдын нутгийг хэсэгчлэн дайран өнгөрөх “Өмнөдэлгэр-Биндэр чиглэлийн 115км хатуу хучилттай автозам барих” төслийн талбайн Байгаль орчны төлөв байдлын үзэлгээний ажлыг хийж гүйцэтгэв. Бид “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үзэлгээний тухай хууль”, БОАЖЯ-ны сайдын тушаалиар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үзэлгээ хийх аргачлал” зэргийг баримтлан дараах үе шаттайгаар тус байгаль орчны төлөв байдлын үзэлгээ судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Байгаль орчны төлөв байдлын үзэлгээний гол зорилго, шаардлага, үзэлгээний цар хүрээг тодорхойлох;
- Өмнөх судалгааны мэдээ, мэдээллийг цуглуулах, боловсруулах, байгаль орчны төлөв байдлыг тодорхойлоход шаардлагатай нэмэлт судалгааг хийх;
- Судалгааны мэдээллийг эмхээтгэн байгаль орчны төлөв байдлын үзэлгээний тайланг боловсруулах зэрэг болно.

Тус төслийн Байгаль орчны төлөв байдлын үзэлгээ судалгааны ажлыг гүйцэтгэхэд “Мон Газар Экологи” ХХК-ийн мэргэжилтэн Б.Баярцэцэг, Н. Оюун-Эрдэнэ шинжээч Б.Нямдаваа, Б.Даваажаргал, Д.Идэрбат, Л. Зүмбэрэлмаа нар оролцов. Замын трассын дагуу авсан хөрс, усны дээжүүдийг “Грийн шаб” ХХК-ийн Хөрс судлалын лаборатори болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хосол судлал, шим тэжээлийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж, суурин боловсруулалтын ажлын орон зайн боловсруулалтыг Google Earth программ, хиймэл дагуулын мэдээ болон 1:100 000 масштаб бүхий байрзүйн зураг зэргийг ашиглан газарзүйн мэдээллийн системийн ArcGIS 10.8 программ хангамжийг ашиглан гүйцэтгэсэн болно. Байгаль орчны төлөв байдлын үзэлгээ судалгааны ажилд ШУА-ийн Газарзүйн хүрээлэн, Ус цаг уурын хүрээлэн, Биологийн хүрээлэнгийн судалгаа шинжилгээний материалууд, төслийн хэрэгжих орчинд өмнө хийгдсэн судалгааны мэдээ болон тус “Мон Газар Экологи” ХХК-ийн мэдээллийн санд хуримтлагдсан судалгаа, мэдээлэл зэргийг ашиглав.

Тус байгаль орчны төлөв байдлын судалгааны ажлын тайлан нь 141 хуудас, 16 бүлэг, 75 зураг, 57 хүснэгт, 7 графикаас бүрдсэн болно.

## БҮЛЭГ 1. ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төлөв байдлын үнэлгээний гол зорилго

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт сумдын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн дайран өнгөрөх “Өмнөдэлгэр-Биндэр чиглэлийн 115 км хатуу хучилттай автозам барих” төслийн талбай орчмын байгаль орчны төлөв байдлын үнэлгээний гол зорилго нь эзхүү төсөл хэрэгжих эхний шатанд нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдал тухайлбал, газарзүйн нөхцөл, геологийн тогтоц, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, мөн түүнчлэн нутгийн иргэд, оршин суугчид, тэдний нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, эрүүл мэнд, түүх соёлын өвийн өнөөгийн төлөв байдлыг тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, судлаачид, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор, шинжлэх ухааны судалгааны аргазүйг ашиглан тодорхойлох нь тус ажлын зорилго оршино.

### 1.2. Төлөв байдлын үнэлгээний хүрээнд хийсэн ажлууд

Бид “Байгаль орчинд иолоөлөх байдлын үнэлгээний тухай хууль”, БОАЖЯ-ны сайдын тушаалаар батлагдсан “Байгаль орчны иолоөлшийн үнэлгээ хийх аргачлаа” зэргийг баримтлан төслийн талбайн байгаль орчны төлөв байдал, нийгэм, эдийн засгийн судалгааг хийж гүйцэтгэсэн. Тус байгаль орчны төлөв байдлын үнэлгээ судалгааны ажил нь дараах агуулгатай байна. Үүнд:

- Төслийн талбайн байрзүйн нөхцөл
- Уур амьстгалын нөхцөл
- Газрын гадарга, геологийн тогтоц, онцлог
- Агаар орчны төлөв байдал
- Хөрсөн бүрхэвч, түүний онцлог
- Гадаргын болон газрын доорх усны нөөц, горим, чанар
- Ургамлан бүрхэвчийн төлөв байдал
- Амьтны аймгийн төлөв байдал
- Нийгэм, эдийн засгийн өнөөгийн нөхцөл

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ судалгааны ажлыг гүйцэтгэхд “Мон Газар Экологи” ХХК-ийн мэргэжилтэн Б.Баярцэцэг, Н.Оюун-Эрдэнэ шинжээч Б.Нямдаваа, Б.Даваажаргал, Д.Идэрбат, Л.Зүмбэрэлмаа нар оролцов. Төслийн тайлангийн суурин боловсруулалтын ажлын орон зайн боловсруулалтыг Google Earth программ, хиймэл дагуулын мэдээ болон 1:100 000 масштаб бүхий байрзүйн зураг зэргийг ашиглан газарзүйн мэдээллийн системийн ArcGIS 10.8 программ хангамжийг ашиглан гүйцэтгэсэн болно.

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт сумдын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн дайран өнгөрөх “Өмнөдэлгэр-Биндэр чиглэлийн 115 км хатуу хучилттай автозам барих” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээг дараах үе шаттайгаар хийж гүйцэтгэв. Үүнд:

#### 1.2.1. Мэдрэлтийг цуглуулах бэлтгэл ажил

Энэ үе шатанд судалгааны талбай тодорхойлох, судалгааны талбай, түүний орчмын байгаль орчин, нийгэм-эдийн засгийн мэдээллийг цуглуулах, төслийн техник эдийн засгийн үзүүлэлттэй холбоотой мэдээллийг цуглуулах зэрэг ажлууд гүйцэтгэгдсэн болно. Судалгааны талбайг Landsat, SPOT хиймэл дагуулын мэдээ, 1:100 000 байрзүйн зураг зэргийг газарзүйн мэдээллийн системд оруулан боловсруулалт хийж тодорхойлов. Мөн хээрийн судалгааны ажлын өмнө хөрсний бичиглэл хийх цэгүүдийг төслийн

төлөвлөлтийн зураг, урьдчилсан хөрсний суурь зурагтай давхцуулан нөлөөлелд өртөгдхөх байдлаар нь сонгов. Төсөл хэрэгжих талбайн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн мэдээллийг Монгол улсын үндэсний атлас /2009 он/, байгалийн хам бүрдлийн суурин судалгааны ажлын үр дүнгүүд /ШУА-ын Газарзүйн хүрээлэн, Биологийн хүрээлэн, Гео экологийн хүрээлэн, Геологийн фонд/, хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, Өмнөдэлгэр, Биндэр сумдын нийгэм-эдийн засгийн мэдээллийг Монгол улсын статистикийн эмхтгэл, сумын албан ёсны вэб хуудас, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан болох [www.1212.mn](http://www.1212.mn) сайт зэргээс хүлээн авав.

### 1.2.2. Хээрийн судалгаа шинжилгээний ажлы

Хээрийн судалгааны ажлыг 2021 оны 11 сарын 20-ны өдөр хийж гүйцэтгэсэн бөгөөд хээрийн судалгааны үеэр төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн онцлог, хэвшинжийг тодорхойж болохуйц 6 цагт хөрсний бичиглэл хийж холбогдох аргачилалын дагуу авч, морфологийн хээрийн бичиглэл, хөрсний дээжийг “Грийн Лаб” ХХК-ийн Хөрс судлалын лабораторид шинжилгээ хийшгэв. Замын трассын дагуу байрлах хүн амын унд-ахуйн зориулалттай 1 шүүний худаг, голын ус (гадаргын урсац)-наас дээж авч Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлал, шим тэжээлийн итгэмжлэгдсэн лабораторид шинжилгүүлэв. Гадаад орчны агаар дахь тоос, тоосонцрын хэмжилтийг нарийн ширхэглэгт тоосонцор ( $PM_{2.5}$ ), том ширхэглэгт тоосонцор ( $PM_{10}$ ), агаарын чийгшил, температур гэсэн үзүүлэлтээр Хятад улсад үйлдвэрлэсэн Temtop air quality 1000 багажаар 10 минут хэмжилт хийж тодорхойлов. Гадаад орчны дуу чимээг С.Е.М. DT- 8820 Америк улсад үйлдвэрсэн багажаар 10 минутын турш хэмжилт хийж Монгол улсын MNS 4585:2016 стандартад заасны дагуу хэмжилт хийв. Хээрийн судалгааны үеэр замын трассын дагуу тааралдах малчдын өвөлжөө, намаржаа, түүх сёйлын дурсгалт газар, гол, горхи, булаг шанд, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг зэрэг онцлох газруудын газарзүйн солбощол, байршилыг бүртгэж, фото зургаар баримтжуулсан болно.

### 1.2.3. Суурин боловсруулалт

Суурин боловсруулалтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг УЦУХ-ийн мэдээллийн сангаас авч уур амьсгалын үндсэн онцлог, агаарын температурын сар, улирал, жилийн дундаж, хамгийн их, бага температурын дундаж утга, нарны цацраг, үзүүлэхүй ба харьцаангуй чийг, хур тунадас, цасан бүрхүүл, түүний жил, улирлын хуваарь, салхилалт, салхины эрчим, зонхилох чиглэл, хурд зэрэг үндсэн үзүүлэлтийг тодорхойлов.
- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний орчмын судалгаанд хамрагдсан талбайн хөрсний хэв шинжийг хээрийн судалгааны ажлын үр дүн, лабораторийн задлан шинжилгээний үр дүн зэргийг үндэслэн тодорхойж, түүний тархалт, морфологи хэв шинж, үржил шим, ялзмагийн агууламжийг судалж, хөрсөн бүрхэвчийн 1:10 000 масштабын зураглал үйлдэв. Хээрийн судалгааны үед тухайн талбайд тархсан хөрсний морфологи шинж чанарыг тодорхойлох болон хөрсний сорыц авах зорилгоор хагас зүсэлт (50-80 см)-ийг тухайн хөрсний шийтгэг хэв шинжийг бүрэн төлөөлж чадах газар болон нөлөөлөд хамгийн хүчтэй өртөх талбайд сонгон хийсэн болно.
- Тухайн төсөл хэрэгжих талбайн агаарын чанарын төлөв байдлыг тодорхойлоход тодорхой хугацааны давтамжтай олон удаагийн хэмжилт судалгааны үр дүн шаардлагатай байдаг бөгөөд тус төслийн байгаль орчны төлөв байдлын үзэлгээний ажлын хээрийн судалгааны хүрээнд 2021.11.20 өдрийн 11:30-16:30 минутын үед цэг тус бүрт 1 удаагийн 10 минутын хугацаатай тоос, тоосонцор, дуу шуугианы хэмжилтийг хийсэн. Агаарын чанарын хэмжилтийг хийхдээ агаарын чанарын хяналт

шишгүүлгээний хугацаат ажиглалтын горимоор хэмжийт хийн холбогдох стандартуудтай харьцуулах, агаарын чанарын индексээр үнэлэх зэрэг ашиглагв.

- Хээрийн судалгааг 11 сард хийсэн ба хээрийн судалгааны үеэр газрын гадарга цасан бурхуулд дарагдсан, ургамлын бичиглэл хийж зүйлийн бурдэл, бүрхэвч зэрэг үндсэн үзүүлэлтийг тодорхойлох нөхцөлгүй байсан тул Монгол орны нутаг дэвсгэрт өргөн ашиглаж байгаа зайнаас тандан судалалын аргийг ашиглан ургамлан бүрхэвчийн төлөв байдлыг тодорхойлсон болно.
- Төслийн талбай орчмын амьтны аймгийн талаар тусгайлсан судалгааны бүтээл ховор. БОЯ, ШУА-ийн Биологийн Хурээлэнгийн судлаачидын хамтарсан Хан Хэntийн ДЦГ-т явуулсан амьтны судалгаа болон өмнөх эрдэмтдийн судалгааны ажлын үр дүнг ашигласан болно.

### 1.3. Судалгааны ажлын гол үр дүн

Хатуу хучилттай автозам нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт сумдын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн дайран өнгөрнө. Тус “Өмнөдэлгэр-Биндэр чиглэлийн 115 км хатуу хучилттай зам”-ын зам барилгын ажлын үс шатанд байгалийн хам бурдэлд тодорхой хэмжээнд налөөлюх хандлага ажиглагдаж байгаа тул байгаль орчин доройтоход хүргэж болзошгүй серог налөөллийг илрүүлж, түүнээс урьдчилан сэргийшэх, бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай. Төслийн хувьд төсөл хэрэгжих үед байгалийн баялагийг зүй зохицой ашиглаж, зам барилгын ажлын дараах нөхөн сэргээлтийг стандарт шаардлагын дагуу хийж хууль тогтоомжийг тогтмол мөрдеж ажилласнаар болзошгүй серег налөөлүүд багасаж, зэрэг налөөлөл нэмэгдэнэ. Тус зам нь ашиглалтанд орсноор хүн амын шийгмийн-эдийн застгийн байдал дээшлэх, одоо ашиглаж буй олон салaa замыг ашиглахгүй болсноор байгалийн жамаар нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх, амьтдын тархац нутаг нэмэгдэх, дуу чимээ, агаарын тоосжилт багасах зэрэг зэрэг налөө үзүүлнэ.

## БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1. Төслийн нэр

“Өмнөдэлгэр-Биндэр чиглэлийн 115 км хатуу хучилттай автозам” төсөл

### 2.2. Төслийн зорилго

МУ-ын нутаг дэвсгэр дээр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу чанар стандартыг баримтлан ажилшаж, байгаль орчинд серөг налөөлөл баатайгаар үйл ажиллагаа явуудах нь төслийн эрхэм зорилго оршино. Тус хатуу хучилттай зам барих төсөл нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр сум зэрэг суурин газруудыг хатуу хучилттай замтай холбосон хүн амын нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой төсөл юм.


### 2.3. Төслийн туслан гүйцэтгэгч

Зураг төсөл боловсруулагч “MSPCgr” ХХК

Байгаль орчны налөөлөх байдлын үзэлгээ - “Мон Газар Экологи” ХХК

### 2.4. Төслийн талбайн байршил

Төсөл нь Монгол улсын байгалийн бүс, бүслүүрийн онцлоогоор ойт хээрийн болон хээрийн (нугат хээр) бүсэд багтдаг ба Засаг захиргааны хуваариар Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт сумдын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн дайран өнгөрнө. Байр зүйн хувьд M-48-04, L-49-126, L-49-137 хавтгайд байрлана.




Зураг 1. Төслийн талбай орчмын байрзүйн зураг

## БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

### 3.1. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, талбайн байршил


Тус “Өмнөдэлгэр-Биндэр-115 км хатуу хучилттай автозам” нь Монгол улсын байгалийн бус, бүслүүрийн онцлогоор ойт хээрийн болон хээрийн бусэд орших ба Засаг захиргааны хуваариар Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт сумдын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн дайран өнгөрнө. Замын трассын эхлэл цэг буюу Өмнөдэлгэр сум нь Улаанбаатар хотоос зүүн тийш 268 км, Чингисхаан хотоос баруун хойш 195 км зайд байрлана.




Зураг 2. Төслийн талбайн байршилын зураг

### 3.2. Төслийн талбай орчмын физик газарзүйн тодорхойлолт


Төсөл хэрэгжих талбай буюу “Өмнөдэлгэр-Биндэр-115 км хатуу хучилттай автозам” баригдах зурvas газар нь Хэнтийн уулархаг бүсийн зүүн урд төгсгөлд, Дорнод Монголын хуурай хээрэрхэг тал нутгийн намхан уул, дов толгод бүхий ойт хээр, хээрийн бүсийн зааг газарт энэхүү орд оршино. Гадаргуугийн өндөржилт нь 963- 2453м. Энэ бус нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын жилийн дундаж температур 0.1-0.4°C, хамгийн их дулаан 7-р сард +40.8°C, их хүйтэн 1-р сард -41.6°C байна. Жилд дунджаар 246 мм тунадас унах ба ихэнх нь зуны улиралд ноогдоно. Салхи ихтэй бөгөөд ихэвчлэн 1.5-4.5 м/с хурдтай салхи зонхишино. Хавар салхины хурд 15 м/с хурэх нь элбэг 9-р сарын сүүлээс хүйтгэрч, цас орно. Төлөвлөж буй авто замын зурvas талбай нь голын хөндий, бэсрэг уулс хоорондын хөндий, бэсрэг уулс толгодын хажуу, хотөл хэв шинжит гадаргуут дамжин өнгөрнө. Геоморфологийн мужалтаар Хэнтийн мужийн Эрээний нурууны дэд мужид тэгширмэл газар, уулс хоорондын хотос, уулан дундах хотгор дахь элэгдлийн гаралтай өргөгдмэл эх гадаргийн үлдмэл дундаж өндөр ба нам уулсын бусэд оршино.



Зураг 3. Монгол орны физик газарзүйн мужлалтын зураг



Зураг 4. Төслийн талбай орчмын өндөршилийн зураг



Зураг 5. Төслийн талбай орчмын өндөршийн зураг

Төсөл хэрэгжих зурvas газар нь 0.42-8.82 градусын налуутай байгаа бол өндөршийн далааны түвшнээс дээш 1033-1376 м байрлах байна.



Зураг 6. Төлевлэж буй замын трассын эхлэлийн төг, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум.





Зураг 7. Төлөвлөж буй замын трассын дагуух орчны фото зураг




Зураг 8. Төлөвлөж буй замын трассын төгсгөлийн цэг, Хэнтий аймгийн Биндэр сум.

## БҮЛЭГ 4. УУР АМЬСГАЛ

### 4.1. Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд

Төлөвлөж буй замын трасс нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт сумдын нутаг дэвсгэрийг дайран өнгөрөх бөгөөд тус бус нутаг нь цаг уур, уур амьсгалын мужалтаар чийглэгдүү хүйтэвтэр зуитай бүсийн, хахир өвөлтэй мужид хамаарна.

**Нарны шилбэр цацраг:** Газрын гадаргад ирж буй дулааны үндсэн эх булаг нь нийлмэл цацраг юм. Цацрагийн эрчимшиг ихтэй хэсэгт агаар илүү хурдан халах учир энэ халсан агаар бага халсан хэсэгтэй шилжинэ. Иймээс энэ дулааны хөдөлгөөний дагуу агаарын масс шилжинэ гэсэн зүй тогтолтыг баримтлан агаарын урсгалын ерөнхий төлөвийг тодорхойлох болно. Дэлхий дахини цацрагийн балансын тэгшигтэлээр тооцоолсон үр дунг зураг 31 үзүүлсэн бөгөөд нийлмэл цацраг их тохиолдолд улаан өнгөөс цайвар шир, бага тохиолдолд цэнхэр өнгөөс хөх өнгийг тус тус харгалзуулав. Нийлмэл цацрагийн хэмжээ олон жилийн дунджаар авч үзвэл 1200-1300 кВт ц/м<sup>2</sup> байна. Үүнийг улирлаар авч үзвэл өвлийн улиралд бага, зуний улиралд харьцангуй их байна.




Зураг 9. Төсөл хэрэгжих орчны нарны радиац /жилийн дунджаар/


Төсөл хэрэгжих бүсэд нар гийгүүлэх хугацаа бусад нутуудтай харьцуулбал харьцангуй бага буюу жилд 2700-3000 цаг байна. Нар гийгүүлэх хугацаа улирлын байдлаар харьцангуй өөр байдаг бөгөөд өвлийн улиралд өдөрт 5 цаг орчим, зуны улиралд 9 цаг орчим байна.

**Агаарын температур:** Агаарын температур нь тухайн орон нутгийн уул нуруу, хотгор гүдгэр, хөрсний байдал (өнгө, бүтэц, ургамлын өндөр нам, тархац, цасан бүрхүүл зэрэг)-аас ихээхэн хамаарна. Агаарын температур нь агаар мандлын төлөв байдлыг тодорхойлогч гол үзүүлэлт буюу уур амьсгалын өөрчлөлтийг илэрхийлэгч чухал үзүүлэлт болдог. Тухайн төслийн төсөл хэрэгжих бүс нутаг нь далайн төвшнөөс дээш 1500-2000 метрт өргөгдсөн бөгөөд жилийн дундаж агаарын температур 0- (-2)°C байгаа боловч агаарын температурыг улирлын байдлаар авч үзвэл температурын хэлбэлзэл харьцангуй эрс тэс байдалтай буюу өвөлдөө -43°C хүртэл хүйтэрч, зундаа +40°C хүртэл халдаг байна. Энэ бүс нутагт өвлийн улиралд иэн хүйтэн өдөр буюу -30°C-ээс хүйтэн өдөр 30-40 өдөр, зуны улиралд иэн халуун өдөр буюу +30°C -ээс халуун өдөр 20-30 өдөр

тохиолддог байна. Харин агаарын температурын хоногийн дундаж температур +10°C буюу түүнээс халуун байх өдөр 120-130 өдөр тохиолддог байна.



**Хур тунадас:** Энэ бүсэд хур тунадас жижд 250-300 мм ордог. Нийт хур тунадасны 70-80% нь дулааны улирал буюу зуны 3 сард ордог байна. Энд өвөлдөө 11.20-03.20 хүртэл цасан бүрхүүлтэй, жилийн 1-5 өдөрт нойтон цас, 2-3 цагаар, цан 1-5 өдөрт 6-14 цагаар, месжилт 1-3 өдөрт 9-10 цаг үргэмжилдэг. Хур тунадасны олон жилийн динамик өөрчлөлтийг доор зургаар үзүүлэв.




**Салхины гори:** Төсөл хэрэгжих бүсэд салхи хурд, хүч, дараалт харьцангуй ёөр ёөр үзүүлэлттэй байdag бөгөөд энэ нь улирлын байдлаар ихээхэн ажиглагдана. Энэ бүсэд зонхилох салхи нь баруун болон баруун урд зүгээс салхилах бөгөөд бусад зүгээс харилцан адилгүй бага хүчээр салхилдаг байна. Энд хүчтэй буюу 15м/с-ээс илүү хурдтай салхитай өдөр 10 өдөр байdag байна. Мөн энэ бүсэд шороон шуурга жилийн 10-30 өдөрт, цасан шуурга 3-5 өдөрт салхилдаг байна.

**Хүснэгт 1. Салхины чиглэлийн давтагдал**

	Салхины хурд	Салхины чиглэл							
		X	3X	3	3У	У	БУ	Б	БХ
<b>Өвөл</b> <b>(1 дүгээр сар)</b>	2-4	4	8			8			8
	4-6						56	10	
<b>Хавар</b> <b>(4 дүгээр сар)</b>	4-6					4	24	8	12
	6-8	10	8						
<b>Зун</b> <b>(7 дугаар сар)</b>	2-4				8	10			
	4-6	12	20	8			12	8	6
<b>Намар</b> <b>(10 дугаар сар)</b>	2-4					6			
	4-6	12	8				44	12	8

#### 4.2. Төлөвлөж буй авто замын уур амьсгал, геотехникийн нохцол

Судалгааны талбайн уур амьсгалын үзүүлэлтийг ЗТАЖ-ын сайдын 2004.11.15-ны өдрийн 22-р тушаалаар батлагдсан “Авто замын уур амьсгал, геотехникийн нохцөл” (АЗУАГН 2.01.01-2004)-ийн үзүүлэлттээр өглөө.



**Зураг 12. Монгол орны авто замын уур амьсгалын бүсчилэл**

Судалгазны зурvas нутаг дэвсгэр нь байрлалаар дэлхийн бөмбөрцөгийн хойт хагасын дундад өргөрөгт багтдаг учир эх газрын эрс тэс тэс уур амьсгалтай байdag.

Судалгааны талбай нь Монгол орны авто замын уур амьсгалын бүсчилэлээр Ойт хээр (IIA)-ийн бүсийн Орхон-Сэлэнгийн ойт хээрийн хахир дэд бүсэд хамаарах бөгөөд олон жилийн цэвдэг чулуулаг ховор алаг цоог тархсан бүслүүрт байх ба улирлын хөлдөлтгэсэнтэй, хүйтний овойлттой болон суумтгай, лёсс маягийн хурdas элбэг тохиолдох

онцлогтой. Ойт хэртээ цасархаг, цас борооноос намаг шавар их үүсдэг, хахир хүйтэн жаварлаг хөрс чулуулаг нь түн хөлддөг бүс юм.

#### Хүснэгт 2. Бүсийн үндсэн тодорхойлолт

Бүсийн дугаар, изр	Дэд бүсийн индекс	Бүсийн төрч тодорхойлолт	Авто замын гео уур амьсгал, гео физикийн онцлог
			1
II хээрийн авто замын уур амьсгалын бүс	IIА. Уулын ба талын ойт хээрийн дэд бүс	Хангайн уул тайга ба ойт хээр талын авто замын уур амьсгалын чийгээдүү-хүйтэн хахир, нэн хүйтэн, хахир дэд бүс	Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархсан, авто замын уур амьсгалын улиралын хөлдөлт-гэсэлттэй. Уулархаг хэртээ цасархаг, цас борооноос намаг шавар ихтэй, бороорхог, аянгалаг, хээр талдаа цас нимгэн няятархаг, салхитай, хахир хүйтэн жаварлаг.

#### Хүснэгт 3. Улирлын үргэлжлэх хугацаа

Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
	Эхэлх Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Үргэлжлэх хоног	
IIА	25.X- 9.XI 2.XI	22.III- 27.IV 11.IV	167-191 /175/	10.Y- 11.YI 25.YI	49-65 /57/	6- 16.IX 11.IX	110-141 /126/	43-53 /48/

Тайлбар: \*Өвлийн дуусах хугацаа хаврын эхлэл, хаврын зуны эхлэл, зуных намрын эхлэл, өвлийн  
эхлэл намрын дуусах хугацаа болно.

#### Хүснэгт 4. Хөрс, агаарын температурын (°C) үзүүлэлт

Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °C				Агаар орчны дундаж температур		
	Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0° ижвичих гун, см*	Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн
IIА	-+0...-3	55-60	-45...-55	300-400	-3...+8	-23...-33	15...17

Тайлбар: \*-0°C ижвичих гун уг хөрсний ширгээс хамраахаа тул дээд, доод хязгаарыг авав.

#### Хүснэгт 5. Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
	Эхэлх Дуусах	Хоног	Эхэлх Дуусах	Хоног		
IIА	10-20.X 15.X	1.Y-10.YI 20.Y	195-200 197	01-20.IY 10.IY	1.YI-1.YII 15.YI	51-80 65

#### Хөрсний хөлдөлт-гэсэлтийн норматив гун

IIА дэд бүсэд: 2.6 м, 3.1 м, 3.3 м, 3.5 м

1 дэх тоо нь шавар, шавранцар, 2 дахь тоо нь элсэнцэр тоосорхог, 3 дахь тоо нь том болон дунд зэрэг элс, хайргархаг, 4 дэх тоо нь том хэмхдэст хөрсний цэвдэгтэй нутагт ул хөрсний гэсэлтийн цэвдэгтүй нутагт ул хөрсний улирлын хөлдөлтийн норматив гун, м-ээр болно.

#### Хүснэгт 6. Авто замын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой болон тохиромжтүй улирлын үсүүд

Дэд бүс	Дулааны улирал*			Хүйтний улирал
	Эхэлх	Дуусах	Хоног	
IIА	20.IY	5.X	168	197

**Хүснэгт 7. Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцаангуй чийгшил**

Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Hg баганын ондреер	Харьцаангуй чийгшил, %
	Өвөл	Хавар	Зүйн	Намар		
IIА	0.7-2.5	2-4	1-2	1-2	550-650	60-70

**Хүснэгт 8. Авто замын уур амьсгалын бусууд дах хур тунадасны хэмжээ, мм**

Бүс	Дэд бүс	Хур тунадасны нийлбэр, мм							
		Өвөл	Хавар	Зүйн	Намар	Жил	1 хоногт орох борооны хангамж, мм	Борооны хамгийн их орох эрчим, мм/мин	
							2%		
II	IIА	10-15	20-70	200-250	25-40	250-350	85	120	1-1.5

**Хүснэгт 9. Аянга, дуу цахилгаан**

Бүс	Дэд бүс	Нийт аянгын үзүүлэлт		Нэг аянгын	
		Өдрийн төс	Үргэлжлэл, цаг	Үргэлжлэл, минут	1 км <sup>2</sup> талбайд ниргэх төс
II	IIА	30-35	40-50	100-120	6-7

**Хүснэгт 10. Нойтон цас, хялмаа, мөстлэг**

Дэд бүс	Нойтон цастай		Хялмаатай		Мөстлэгтэй		
	Өдрийн төс	Үргэлжлэх, цаг	Өдрийн төс	Үргэлжлэх, цаг	Өдрийн төс	Зузаан, мм	10 жилд
IIА	5-10	4-5	8-10	13-15	1-2	15	10

**Хүснэгт 11. Газрын гадрага дээрх цасны ачаалал**

Дэд бүс	Цасны ачаалал, кг/м <sup>2</sup>	
	IIА	60-70

**Хүснэгт 12. Хээр гадаа ажиллах авто замын ажилчдын хөдөлмөрийн био уур амьсгалын нехцөл**

Дэд бүс	О <sub>2</sub> -ийн нэгт, г/см <sup>3</sup>	Хувцас хуварын дулаан чанар, КЛО (хүндэтгэр ажлыг нехцүүр тооцөв)			Уур амьсгал хүний биед, хоног		
		Өвлийн	Хавар, намрын	Зүйн	Таятай	Цочроох	Хурц
IIА	250-270	4.5-5.5	3.0-3.5	1.5-1.8	170-180	105-110	80-85

**Хүснэгт 13. Автозамын үйлдвэрлэл, замчдын хөдөлмөрт уур амьсгалын нэлэөллийг  
үзэлжих итгэлцүүр**

Дэд бүс	Нэлэөл үйлчилгэлийн итгэлцүүр				
	Хүйтний	Хахирлын	Халууны	Хур тунадасны	Чийгшилийн
IIА	1.14	0.84	0.88	1.28	1.10

**Хүснэгт 14. Автозамын уур амьсгалын бусууд дэд халуун асфальт бетон холыц бэлтгэж  
дэвсэхэд тохиромжтой хугацаа**

Дэд бүс	Асфальт болои замын хучилт		
	Эхлэх	Дуусах	Хоног
IIА	23.IV-17.V (10.V)	10.VIII-04.IX (18.VIII)	75-125 (100)

**Хүснэгт 15. Автозамын уур амьстгалын бүсүүдэд хүйтэн, бүлээн асфальт бетон хучилт  
хийхэд тохиromжтой хугацаа**

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусах	Хоног
IIА	15.III-01.IV (19.III)	24.X-22.XI (07.XI)	206-262 (234)

Эх сурвалж: <https://www.legalinfo.mn/> “Авто замын уур амьстгал, геотехникийн нөхцөл”  
(АЗУАГН 2.01.01-2004)

## БҮЛЭГ 5. АГААР ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

### 5.1. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд

Агаар бохирдуулах үндсэн эх үүсвэрийг байгалийн гаралтай, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гэж 2 сронхий хэсэгт хувааж үздэг. Галт уулын дэлбэрэлт, шороо, тоос, шуурга, ой, хээрийн түймэр, хөрсний элэгддийн буюу ургамал, амьтан, микробиологийн гаралтай төрөл бүрийн бодис, үер, манан зэрэг нь байгалийн эх үүсвэрт хамаарна. Байгалийн гаралтай бохирдлын эх үүсвэр бол түр зуурын болон гамшгийн байдалтай тохиолдох тул бохирдлын ерөнхий түвшинд мен тийм байдлаар нөлөөлөх бөгөөд удаан хугацаагаар хадгалаагдахгүй. Агаарын бохирдлын нэлээд аюултай эх үүсвэрт хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хэсэг ордог.

Хүснэгт 16. Агаар бохирдуулагч бодисын шинж чанар, үүсэх эх үүсвэр

Бохирдуулагч бодис	Шинж чанар	Эх үүсвэр
Хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ )	Өнгөгүй, хурц үнэр, амттай, урвалд идэвхтэй ордог хий	Нүүрс, газрын тос зэрэг хүхэр агуулсан түүшний шаталт, металийн боловсруулах үйл ажиллагаанаас үүсдэг.
Азотын давхар исэл ( $\text{NO}_2$ )	Өнгөгүй, бага зэрэг таагүй үнэртэй хий. Агаар мандалд их агууламжтай байх үед бор шаргал, улаан хүрэн өнгөтэй болж, урвалд идэвхтэй ордог. Агаарын бохирдлын эх үүсвэрээс ялгарсан азотын исэл ( $\text{NO}$ ) агаар дахь хүчинлөрөгчтэй нэгдэхэд үүснэ.	Түлш ондер температурт шатах үед үүсдэг ба авто тээврийн хэрэгслийн дотоод шаталт, цахилгаан халаагуур, цахилгаан станц, химийн үйлдвэр, хог шатаах зуух зэрэг агаар бохирдуулах эх үүсвэрээс ялгардаг.
Нүүрстөрөгчийн дутуу исэл ( $\text{CO}$ )	Үнэргүй, енгөгүй хий	Ихэвчлэн түлш, шатахууны дутуу шаталт мөн ой хээрийн түймрийн шаталт, үйлдвэрийн үйл ажиллагааны дунд үүснэ.
$\text{PM}_{2.5}$ , $\text{PM}_{10}$ тоосонцор	Агаар дахь нарийн ширхэгтэй тоос, шингэний жижиг дуслуудаас бүрдэнэ. Байгалийн болон хүний үйл ажиллагааны явцад тоосонцор агаарт шууд хаягдахаас гадна өөр бусад хийн бохирдуулагчид агаарт хоорондоо нэгдэн кувирч тоосонцрыг үүсгэнэ.	Автомашин, төрөл бүрийн зуух, ой хээрийн түймэр, замын тоос шороо, бүтэн байгуулалтын ажил, хөдөө яж ахуйн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас икзээн ялгардаг.

Үүнд:  $\text{PM}_{2.5}$  - 2.5 микронметр / $\mu\text{m}$ /-ээс бага диаметр бүхий тоосонцрыг “нарийн ширхэглээт тоосонцор буюу  $\text{PM}_{2.5}$ ” гэдэг.  $\text{PM}_{10}$  - 2.5-10 микронметр хэмжээтэй тоосонцрыг “том ширхэглээт тоосонцор буюу  $\text{PM}_{10}$ ” гэдэг.

#### 5.1.1. Чингис хотын агаарын чанарын төлөв байдал

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь бүхэлдээ эзгүй хээр талд байрлах тул төслийн талбайн агаарын чанарын өнөөгийн төлөв байдлыг үнэлэхдээ түүнтэй хамгийн ойр орших томоохон суурин болох Чингис хотын агаарын чанарын төлөв байдлыг авч үзсэн болно. Хэнтиййн аймгийн төв Чингис хот нь газарзүйн байршилын хувьд авч үзэхэд, овлийн улиралд салхины чиглэл баруун өмнөөсөө байдаг учраас Чингис хотын агаарын чанарыг аймгийн УЦУОШГ-ын байгаль орчны шинжилгээний лабораториид жилийн турш шинжилгээний дунгэрээр нисэх орчимд агаарын чанар цэвэр, хотын төв буюу ясли, эмнэлэг, “Хан Хэнтий” чуулга, гэр хороолол буюу “Баянмөнх” баг, “Хан Хэнтий” цогцолбор сургуулийн орчимд агаарын бохирдол сөрдийнхөөс 5-6 дахин их буюу зарим үед 10 дахин их бохирдолтой байдаг гэсэн дүгнэлт гарчээ. Энэ нь агаарын “бага бохирдолтой” гэсэн ангилалд ордог байна. Хэнтиййн аймгийн БОАЖТ-аас гаргасан

судалгаагаар аймгийн төвд срдийн галлагатай тэр болон байшингийн нийт 4039 зуух жилд 10454 тонн нүүрс, усан халаалтын зуух 39, жилд 32600 тонн нүүрс хэрэглэж, 7393 автомашин зорчиж байна гэсэн судалгаа гарсан байна. Энэ нь Улаанбаатар хотынхой харьцуулахад харьцангуй бага тоо хэдий ч агаарын бохирдол хэвийн хэмжээнээсээ хэтэрч байгааг хүчин зүйл болж өгдөг байна.

Хүхэрлэг хий, Чингис хотын агаар дахь хүхрийн давхар ислийн 10 жилийн дундаж үзүүлэлтийг зураг 1-т харуулсан байна. Үүнээс үзэхэд хүхрийн давхар ислийн агууламж 2010-2016 онуудад MNS 4585:2016 стандарт буюу 20 мкг/м<sup>3</sup>-ээс 2-3 дахин их давсан үзүүлэлттэй байсан бол 2017 оноос буурч 2019-2020 онуудад 1 дахин багассан үзүүлэлттэй байна.




График 1. Чингис хотын хүхэрлэг хийн агууламж, 2010-2020

*Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*

Азотын давхар исэл. 2010-2020 оны агаар дахь азотын давхар ислийн агууламжийг график 2-т харуулсан байна. Үүнээс үзэхэд Чингис хотын агаар дахь азотын давхар исэл нь Монгол улсын агаарын чанарын стандартыг давсан үзүүлэлттүй байна.



График 2. Чингис хотын азотын давхар ислийн агууламж, 2010-2020

*Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*

Агаар дахь том ширхэглэгт тоосонцор. Чингис хотын УЦУОШГ-аас агаар дахь том ширхэглэгт тоосонцрын агууламжийг 2015-2019 оны хоорондох мэдээг харуулсан байна. 2020 онд тоосонцор хэмжигч багаж нь ажиллаагүй тул 2020 онд хэмжилт хийгдээгүй

байна. График 3-ас харахад 2015-2017 оны хооронд агаар дахь том ширхэглэгт тоосонцрын агууламж MNS 4585:2016 стандартыг давсан үзүүлэлттэй байсан бол 2018 оноос эхлэн тоосонцрын агууламж буурсан байна.



График 3. Чингис хотын том ширхэглэгт тоосонцорын агууламж, 2015-2019


Эх сургалж: Статистикийн мэдээллийн изгдсэн сан

## 5.2. Төслийн талбай орчмын агаар орчны хяналт шинжилгээ

Төсөл хэрэгжих талбайд хийсэн агаарын чанарын хэмжилтийг “Мон Газар Экологи” ХХК-ийн мэргэжилтийн 2021 оны 11-р сарын 20 өдөр хийж гүйцэтгэв. Төлөвлөж буй замын трассын дагуу төсөл хэрэгжихээс өмнөх агаарын чанарын хэмжилт, судалгааг нийт 6 цэгт хийж, үр дүнг боловсруулав. Тухайн төслийн талбайн агаарын чанарын төлөв байдлыг тодорхойлоход тодорхой хугацааны давтамжтай олон удаагийн хэмжилт судалгааны үр дүн шаардлагатай байдаг бөгөөд тус төслийн байгаль орчны төлөв байдлын үзэлгээний ажлын хээрийн судалгааны хурээнд 2021.11.20 өдрийн 12:30-16:30 минутын үед цэг тус бүр дээр 1 удаагийн 10 минутын хугацаатай тоос, тоосонцор, дуу шуугизны хэмжилтийг хийв. Агаарын чанарын цэгүүдийн орчны нөхцөл нь ээр хоорондоо ойролцоо, ойр орчмын хөрс ургамал бүрхэвчгүй халцгайг эс тооцвол цэгүүдийн орчим ямар нэг агаар бохирдуулах эх үүсвэр байхгүй. Хээрийн судалгааны үеэр агаарын температур  $-11^{\circ}\text{C}$ - $(-16^{\circ}\text{C})$  хүйтэн, салхи  $5\text{-}7 \text{ м/с}$  ны хурдтай, цас орсон, цаг агаар тогтуун байсан тул шороон зам дагуу тоосжилт үүсэх нөхцөлгүй байсан. Агаар орчны чанарын хэмжилт хийж, үр дүнг боловсруулахдаа Монгол улсад мердэгдэж байгаа стандартад, аргачлал болон багажит шинжилгээний аргыг ашиглан агаар бохирдуулагчийг тодорхойлсон. Агаарын чанарын хэмжилтийг хийхдээ агаарын чанарын хяналт шинжилгээний хугацаат ажиглалтын горимоор хэмжилт хийн холбогдох стандартуудтай харьцуулах, агаарын чанарын индексээр үзэлж зэрэг аргыг ашиглав.

### Хүснэгт 17. Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгүүдийн газарзүйн солбилицол

Дээжний нэр	Хэмжилт хийсэн байрлал	Хөрсний дээж авсан цэгийн солбилицол	
		ЗУ	ХӨ
АЧХЦ-1	Хэнтий, Өмнөдэлгэр сумын төв, замын трассын эхлэл	$109^{\circ}48'59.56''$	$47^{\circ}53'31.63''$
АЧХЦ-2	Хэнтий, Өмнөдэлгэр сум, трассын 20 дахь км-т	$109^{\circ}50'16.07''$	$48^{\circ}02'22.36''$
АЧХЦ-3	Хэнтий, Өмнөдэлгэр сум, замын трассын 50 дахь км-т	$110^{\circ}03'22.09''$	$48^{\circ}13'28.72''$
АЧХЦ-4	Хэнтий, Батширээт сум, замын трассын 70 дахь км-т	$110^{\circ}17'32.55''$	$48^{\circ}22'28.58''$
АЧХЦ-5	Хэнтий, Биндэр сум, замын трассын 97 дахь км-т	$110^{\circ}32'04.01''$	$48^{\circ}32'45.09''$



Зураг 13. Хэмжилт хийсэн цэгүүдийн байрлал

Гадаад орчны агаар дахь тоос, тоосонцрын хэмжигтийг нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5), том ширхэглэгт тоосонцор (PM10), агаарын чийгшиг, температур гэсэн үзүүлэлтээр Хятад улсад үйлдвэрлэсэн Temtop air quality 1000 багажаар 10 минут хэмжилт хийж тодорхойлов. Гадаад орчны дуу чимээг С.Е.М. DT- 8820 Америк улсад үйлдвэрсэн багажаар 10 минутын турш хэмжилт хийж Монгол улсын MNS 4585:2016 стандартад заасны дагуу хэмжилт хийсэн.



Зураг 14. Temtop air quality 1000, С.Е.М DT-8820 багаж



Зураг 15. АЧХЦ-01- агаар орчны хэмжилтийн дүн мэдээ, Эхлэлийн цэг.



Зураг 16. АЧХЦ-02- агаар орчны хэмжилтийн дүн мэдээ, трассын 20 дахь км-т



Зураг 17. АЧХЦ-03- агаар орчны хэмжилтийн дүн мэдээ, трассын 50 дахь км-т



Зураг 18. АЧХЦ-04- агаар орчны хэмжилтийн дүн мэдээ, трассын 70 дахь км-т



Зураг 19. АЧХЦ-05- агаар орчны хэмжилтийн дүн мэдээ, трассын 97 дахь км-т



**Зураг 20. АЧХЦ-06- агаар орчны хэмжилтийн дун мэдээ, Бинцэр сум замын трассын 115  
дахь км-т**

**Хэмжилтийн үр дүн:**

Судалгааны талбайд хийсэн хэмжилтийн үр дүнг боловсруулахдаа БОАЖ-ны сайдын 2018 оны 10 сарын 10 өдрийн А/387 тоот тушаалаар батлагдсан “Агаарын чанарын индексээр агаарын чанарыг үзэлх, мэдээлх журам”-ын хавсралтын 1.4-д заасан агаар бохирдуулах бодис тус бүрээр дараах томъёог ашиглан тооцоолно.

$$A\text{ЧИ}_i = \frac{A\text{ЧИ} \text{ дээд} - A\text{ЧИ} \text{ доод}}{T\text{ХА} \text{ дээд} - T\text{ХА} \text{ доод}} (C_i\text{-TХА} \text{ доод}) + A\text{ЧИ} \text{ доод}$$

- Энд, **AЧИ<sub>i</sub>- i бохирдуулах бодисын агаарын чанар индекс**  
**C<sub>i</sub>- агаар дахь i бохирдуулах бодисын агууламж**  
**TХА дээд – i бохирдуулах бодисын агууламжид хамаарах хязгаарын дээд утга**  
**TХА доод – i бохирдуулах бодисын агууламжид хамаарах хязгаарын доод утга**  
**AЧИ дээд – ТХА дээд-д харагдах агаарын чанарын индекс**  
**AЧИ доод – ТХА доод-д харагдах агаарын чанарын индекс**

Агаарын чанарыг агаарын чанарын индексээр 6 түвшин ангилах бөгөөд түвшин тус бүрт харгалзах индексийн тоон үзүүлэлт, өнгөт тэмдэглэгээ хүний эруул мэндэд үзүүлэх нөлөөллийг харуулав. Агаарын чанарын индекс нь 100 ба түүнээс бага байвал агаарын чанар стандартын шаардлага хангаж байна гэж 101-ээс их байвал агаар бохирдож стандартын шаардлага хангахгүй байна гэж үзүүлэх.


**Хүснэгт 18. 1 Цэг- агаар орчны хэмжилтийн дун мэдээ, Эхлэлийн цэг**

Хэмжилтийн цэгийн байршил	Үзүүлэлт	Хэмжилт хийсэн хугацаа	Хэмжих цэгж	Стандарт утга	Хэмжилтийн дундаж утга	AЧИ-ийн тоон үзүүлэлт ( $I_m/I_s * 100$ )	Агаарын чанар болон онгийн тэмдэглэгээ
АЧХЦ-01	pM <sub>10</sub>	10	мкг/м <sup>3</sup>	0-50	5.6	5.6	Цэвэр
	pM <sub>2.5</sub>	10	мкг/м <sup>3</sup>	0-35	4.1	5.85	Цэвэр
	Дуу чимээ	10	дБ	44.6	38.6		
АЧХЦ-02	pM <sub>10</sub>	10	мкг/м <sup>3</sup>	0-50	4.5	4.5	Цэвэр
	pM <sub>2.5</sub>	10	мкг/м <sup>3</sup>	0-35	3.3	4.71	Цэвэр
	Дуу чимээ	10	дБ	44.6	39.7		
АЧХЦ-03	pM <sub>10</sub>	10	мкг/м <sup>3</sup>	0-50	4.0	4.0	Цэвэр
	pM <sub>2.5</sub>	10	мкг/м <sup>3</sup>	0-35	2.9	4.14	Цэвэр
	Дуу чимээ	10	дБ	44.6	36.0		
АЧХЦ-04	pM <sub>10</sub>	10	мкг/м <sup>3</sup>	0-50	5.7	5.7	Цэвэр
	pM <sub>2.5</sub>	10	мкг/м <sup>3</sup>	0-35	4.1	5.85	Цэвэр
	Дуу чимээ	10	дБ	44.6	32.1		
АЧХЦ-05	pM <sub>10</sub>	10	мкг/м <sup>3</sup>	0-50	4.0	4.0	Цэвэр
	pM <sub>2.5</sub>	10	мкг/м <sup>3</sup>	0-35	2.9	4.14	Цэвэр
	Дуу чимээ	10	дБ	44.6	26.6		
АЧХЦ-06	pM <sub>10</sub>	10	мкг/м <sup>3</sup>	101-250	114.1	114.1	БЗБ
	pM <sub>2.5</sub>	10	мкг/м <sup>3</sup>	51-100	76.8	76.8	БЗБ
	Дуу чимээ	10	дБ	44.6	36.9		

Тайлбар: Агаар дахь тоос, тоосонцырын хэмжилтийг нарийн ширхэглэгт тоосонцор (PM<sub>2.5</sub>), том ширхэглэгт тоосонцор (PM<sub>10</sub>), агаарын чийгшил, температур гэсэн үзүүлэлтээр Хятад улсад үйлдвэрлэсэн Temitor air quality 1000 багажаар, дуу чимээг С.Е.М. DT- 8820 Америк улсад үйлдвэрлэсэн багажаар 10 минутын турш хэмжилт хийж үр дүнг “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585:2016” стандартын утгатай харьцуулж агаарын чанарын индекс (АЧИ)-ээр үзэлзв.

### Дүгнэлт:

Төсөл хэрэгжих талбайд хийсэн агаарын чанарын хэмжилтийг “Мон Газар Экологи” ХХК-ийн мэргэжилтнүүд 2021 оны 11-р сарын 20 өдөр хийж гүйцэтгэв. Төлөвлөж буй замын трассын дагуу төсөл хэрэгжихээс өмнөх агаарын чанарын хэмжилт, судалгааг нийт 6 цэгт хийж, үр дүнг боловсруулав. Тухайн төслийн талбайн агаарын чанарын талов байдлыг тодорхойлоход тодорхой хугацааны давтамжтай олон удаагийн хэмжилт судалгааны үр дүн шаардлагатай байдал бөгөөд тус төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажлын хээрийн судалгааны хүрээнд 2021.11.20 өдрийн 12:30-16:30 минутын үед цэг тус бүр дээр 1 удаагийн 10 минутын хугацаатай тоос, тоосонцор, дуу шуугианы хэмжилтийг хийв. Агаарын чанарын цэгүүдийн орчны нөхцөл нь өөр хоорондоо ойролцоо, ойр орчмын хөрс ургамал бүрхэвчгүй халигтай эс тооцвол цэгүүдийн орчим ямар нэг агаар бохирдуулах эх үүсвэр байхгүй. Хээрийн судалгааны үеэр агаарын температур  $-11^{\circ}\text{C}$ - $(-16^{\circ}\text{C})$  хүйтэн, салхи 5-7 м/с ны хурдтай, цас орсон, цаг агаар тогтуун байсан тул шороон зам дагуу тоосжилт үүсэх нөхцөлгүй байсан. Агаар орчны чанарын хэмжилт хийж, үр дүнг боловсруулахаа Монгол улсад мөрдөгдөж байгаа стандартад, аргачлал болон багажит шинжилгээний аргыг ашиглан агаар бохирдуулагчийг тодорхойлсон. Агаарын чанарын хэмжилтийг хийхдээ агаарын чанарын хяналт шинжилгээний хугацаат ажиглалтын горимоор хэмжилт хийн холбогдох стандартуудтай харьцуулах, агаарын чанарын индексээр үнэлэх зэрэг аргыг ашиглав.



Замын трассын дагуу хийсэн агаарын чанарын хэмжилтийн дүнгээр төслийн талбайд Монгол улсын агаарын чанарын стандарт болох MNS 4585:2016 стандартыг давсан агаар дахь бохирдуулагч бодис байхгүй, төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага гэж үзэж байна. Хэмжилтийн үр дүнгээс хараад агаар дахь том ширхэглэгт тоосонцор  $4.0\text{--}5.7 \text{ мкг}/\text{м}^3$ -ийн хооронд, нарийн ширхэглэгт тоосонцор  $2.9\text{--}4.1 \text{ мкг}/\text{м}^3$ -ийн хооронд буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс хэд дахин бага үзүүлэлтэй байна. Замын трассын төгсгөл цэг буюу Хэнтий аймгийн Биндэр сумын төвд хийсэн хэмжилтийг широон зам дээр хийсэн бөгөөд автомашины хөдөлгөөн ихтэй үед том ширхэглэгт тоосонцор  $89.0\text{--}114.1 \text{ мкг}/\text{м}^3$ -ийн хооронд, нарийн ширхэглэгт тоосонцор  $60.5\text{--}76.8 \text{ мкг}/\text{м}^3$ -ийн хооронд буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан, бага бохирдолтой байсан. Шороон замаас бусад цэйт хэвийн байна. Хэмжилт хийсэн бүх цэгүүдэд орчны дуу шуугчаны төвшин хэвийн байна.

“Мон Газар Экологи” ХХК-д бэлтгэв.

### 5.3. Агаар орчны төлөв байдалд нөлөөлөх хүчин зүйл

Агаарын бохирдол үүсэх үндсэн нөхцөл нь зам барилга байгууламжийн барих ажлын үед гарах тоос, ашиглаж буй машин механизм, техник хэрэгслээс гарах химийн хорт бодис бүхий хий, утга, тортоог болно.

Хатуу хучилттай авто зам байгуулах үйл ажиллагааны явцад төслийн талбай руу элс, дайрга, цемент болон бусад орц бүтээгдэхүүн, тоног техеөрөмж, сэлбэг материалыг тээвэрлэж буй широон замууд, элс, дайрганы нунтаг тоосонцор, төслийн талбайд ашиглаж буй машин, техникиээс үүдэлтэй тоос широо, түүшний дутуу шатаалтаас ялгарах хорт утгаа хийнүүд тухайн орчны агаарыг бохирдуулна. Агаарын бохирдол нь зам барилга байгууламжийн талбайд ашиглаж байгаа ажиллагсад, орон нутгийн иргэдийн эрүүл мэндээс гадна ойр орчмын амьтан, ургамал, газар нутгат нөлөө үзүүлнэ.

Замын барилга байгууламж барих талбайн гадаргууг тэгшилж бэлтгэх, замд ашиглах элс хайрганы орд нээх, ухаж ашиглах, широон замаар зөөж тээвэрлэх, овоошго хийх, зам талбайд элс хайрган хучилт хийх, цемент бетоны хольц zuурmag хийх зэрэг олон төрлийн газар широоны ажлаас ихээхэн хэмжээний тоос гарах нөхцөл үүсдэг. Мөн зам барилгын ажлын үед бульдозер, экскаватор, ачигч, хүнд даацын тээврийн хэрэгсэл зэрэг хүнд механизмууд ашиглаж түүш шатаан нүүрстөрөгчийн дутуу исэл ( $\text{CO}$ ), азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ), хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ ), утга хөө тортоог гэх мэт бохирдуулагчид болон хөрс хуулалт, түр зам ашиглалтаас төслийн талбайн хөрс талхлагдаж тоос агаарт хаягдаж агаар орчин тодорхой хугацаанд бохирдож болзошгүй байна.

Төсөл хэрэгжих талбай нь хур тунадас бага, хуурай уур амьсгалтай бүсэд хэрэгжих тул цаг агаарын нөхцөл тааламжгүй байх, уур амьсгалын үзүүлэлтүүдийн өөрчлөлттэй давхардах зэрэг тохиолддолд зам барилгын үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилтын хэмжээ харьцангуй өндөр байх магадлалтай.

Хатуу хучилттай зам барьснаар өмнөх олон салаа широон зам болон хучилтгүй замаас үүсдэг тоосжилт багасах боловч зам барилгын ажлын үед бүтээн байгуулалт, газар широоны ажил, тээвэрлэлтээс үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээг төлөвлөн авч хэрэгжүүлж нь зүйтэй юм. Төслийн үед “MNS 4585:2016. Агаарын чанар. Техникийн срохийн шаардлага стандарт”-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан агаар бохирдуулагч, тоос тоосонцор үүсэхээс сэргийш, тоосжилтыг бууруулах талаар ихээхэн анхаарах шаардлагатай.

#### 5.4. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж

Хатуу хучилттай зам барьж байгуулах ажлын үед үүсэх тоос, бохирдуулагч хийн ялгаралыг багасгах, орчныг бохирдуулахгүйн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Зам тавих үед түүний ойр орчмоор олон машин явж олон салаа зам гаргуулахгүйн тулд нэгдсэн нэг замаар явах нөхцөлийг хангах. /Тогтоосон маршрутын дагуу түр зам хэрэглэх эсвэл хуучин замаар явах, хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдлыг хязгаарлах, тэмдэг тэмдэгжүүлэлтийг хийх гэх мэт/.
- Замын барилга байгууламжийн ажлын үед газар шорооны ажлыг сайтар төлөвлөн, газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн өртөх байдлыг бууруулах, шаардлагагүй газрыг эвдрэлд оруулахаас аль болох зайлсхийж, агаарт тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэх.
- Түүхий эд, хөрс шороог ачиж буулгах, тээвэрлэх ажлыг аль болох агаар тогтуун, салхи багатай үед гүйцэтгэж, тоосны тархалтыг багасгах.
- Тоос ихээр үүсгэдэг түүхий эд, материалыг тээвэрлэхдээ бүтээлгэх хэрэглэх, олон салхи зам гаргахгүй байх, нэгдсэн нэг замаар тээвэрлэлт хийх нөхцөлийг бурдуулэх.
- Барилгын материал, ялангуяа нарийн ширхэгтэй материалыг далд, бүхээгтэй ачааны машинаар зөөверлөх, тоос үүсэх, асгарахаас сэргийлэх.
- Шороон далангийн шороон материалыг аль болох түргэн хугацаанд тэгшилж хайрга, буталсан чулуун үсэр хучилт хийх.
- Ажилчдын түр суурин, суурышлын бус орчимд болон зам барилгын ажлын талбайд тоосжилтын эх үүсвэрүүдийг бууруулах, замыг услах.
- Хайрга олборлох явцад үүсэх тоосжилтын шууд нөлөөлөлд өртөх талбайд ус шүрүүнчээр тоос дараах арга хэмжээ авах, тоосжилгоос хамгаалах өөр бусад арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Усалгаа шаардлагатай зам талбайн усалгаанд аль болох технологийн бохир усыг цэвэршилжүүлэн дахин ашиглах, усны нөөцийн хэмнэлттэй ашиглах бодлогыг баримтлах.
- Машин механизмын, техник хэрэгслийэс гарах бохирдуулагч бодис бүхий хий, утзаг багасгах үүднээс зам барилгын талбайд ажилд хэрэглээгүй үедээ техник хэрэгслийг унтрааж байх.
- Замын барилга байгууламжийн ажилд хэрэглэж байгаа техник хэрэгслүүдийн угаа Монгол улсын болон олон улсын холбогдох стандартад нийцсэн байна. /MNS.5013:2009. Бензин хөдөлгүүртэй авто машины угааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдхөх дээд хэмжээ стандарт; MNS 5014:2009. Дизель хөдөлгүүртэй авто машины угааны тортогжилтын зөвшөөрөгдхөх дээд хэмжээ стандарт/.
- Техникийн үзлэг оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж, бохирдуулагч бодис, хий их хэмжээгээр яшгарахаас урьдчилан сэргийлэх. Замын машин техникийн үйлчилгээг хийх үед тэжээл, шатаах, хий хуваарилах механизмын системийн хяналтын болон тохиргооны ажилд онцгой анхаарах шаардлагатай. Эдгээр арга хэмжээ нь шатахууны бүрэн шатах нөхцөлийг ханган, шатахуун зарцуулалтыг багасгаж, байгальд хаягдах бохирдуулагч бодисын хэмжээг эрс багасгана.

## БҮЛЭГ 6. ФИЗИК БОХИРДОЛ, ХОГ ХАЯГДАЛ

### 6.1. Төсөл хэрэгжих талбайн дуу шуугианы хэмжилтийн үр дүн

Төсөл хэрэгжих талбайд хээрийн судалгааны хэмжилтийг “Мон Газар Экологи” ХХК-ийн мэргэжилтийн 2021 оны 11-р сарын 20 өдөр хийж гүйцэтгэв.

Энэ ажлын хүрээнд төслийн нөлөөлөлтөр өртөж болзошгүй газруудад дуу шуугианы хэмжилтийг нийт 6 цэгт хийсэн. Гадаад орчны дуу чимээг С.Е.М. DT- 8820 Америк улсад үйлдвэрсэн багажаар 10 минутын турш хэмжилт хийж Монгол улсын MNS 4585:2016 стандартад заасны дагуу хэмжилт хийсэн. Хэмжилтийн үр дүнг тооцоолохдоо дараах томьёог ашигласан.

$$Leq=L_{50}+(L_{10}-L_{90})^2/T$$

Энд: Leq- дууны эквивалент түвшин, дБА

T- хэмжилтийн хугацаа, мин

L<sub>10</sub> -Туршилтын хугацааны 10 хувийн турш уг түвшинээс давсан шуугианы түвшин, дБА

L<sub>50</sub> -Туршилтын хугацааны 50 хувийн турш уг түвшинээс давсан шуугианы түвшин, дБА


L<sub>90</sub>- Туршилтын хугацааны 90 хувийн турш уг түвшинээс давсан шуугианы түвшин, дБА



Хүснэгт 19. Төсөл хэрэгжих талбайд хийсэн дуу чимээний хэмжилт

Хэмжилт хийсэн цэг	Үзүүлэлтийн иэр	Хугацаа /мин/	Хэмжих нэгж	Хэмжилтийн дундаж утга	Стандарт утга
Цэг-1	Дуу чимээ	10	дБ	38.6	44.6
Цэг-2	Дуу чимээ	10	дБ	39.7	44.6
Цэг-3	Дуу чимээ	10	дБ	36.0	44.6
Цэг-4	Дуу чимээ	10	дБ	32.1	44.6
Цэг-5	Дуу чимээ	10	дБ	26.6	44.6
Цэг-6	Дуу чимээ	10	дБ	36.9	44.6

Төсөл хэрэгжих талбай нь бүхэлдээ эзгүй хээр талд байрлах тул дуу чимээний нелөөнөн бага байх төлөвтэй байна. Монгол улсын “MNS 4585:2016. “Агаарын чанаарын стандарт. Техникийн шаардлагын стандартад зааснаар дуу шуугианы хэмжээ өдрийн цагаар (07-22 цаг) 50 дБа, шöнийн цагт (22-07 цаг) 45 дБа-аас илүүгүй байх ёстой байдал. Орчны дуу шуугианы төвшин хэмжилт хийсэн бүх цэгүүдэд хэвийн байна.



Зураг 21. Орчны дуу шуугианы хэмжилтийн тоон үзүүлэлт

Зам барилгын ажлын үед дуу чимээ ихтэй бүсэд ажиллагсад хувийн дуу чимээнээс хамгаалах хэрэгсэлтэй байх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг хатуу баримталж, ажилчдыг хамгаалах хувцас, хэрэгслээр хангаж ажиллах шаардлагатай. Машин, механизмын дуу чимээний зөвшөөрөгдөх түвшинг зориулалтын дууны хүч хэмжигч багажаар тогтмол хэмжиж дуу чимээний түвшиний хянаж байх шаардлагатай. Төслийн талбай, түр суурин, суурышлын бүс орчинд шуугианы түвшин зөвшөөрөгдөх хэм хэмжээнээс өндөр байгаа тохиолдолд шуугианы түвшинг нэмэгдүүлж байгаа үндсэн шалтгаан нөхцөлийг тухай бүр тодорхойлж, шаардлагатай бол тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийж, шуугианыг бууруулах арга хэмжээг авч байх нь зүйтэй. Зарим шуугиан ихтэй машин тоног төхөөрөмжүүдийг бүхэлд нь буюу дуу чимээтэй хэсэгт дуу шингээх (тусгаарлах) материалыар хийгдсэн хаалт гэр хийж тусгаарлах арга хэмжээ авч болно. Дуу шуугианы түвшиний бууруулахын түнд гүүрэн байгууламжийн ажил гүйцэтгэхдэд дуу чимээ бага гаргадаг машин тоног төхөөрөмжийг сонгох, машин механизмын, тоног төхөөрөмжид тогтмол засвар үйлчилгээ хийх, тэдгээрт дуу намсгагч хэрэглэх, дуу чимээ ялгаруулалт багатай технологийн ажилбарыг ашигласнаар дуу чимээний нөлөөллиөс сэргийлэх боломжтой.

## 6.2. Хог хаягдал

Хатуу хог хаягдал

*Ахуйн хатуу хог хаягдал*

Төслийн явцад гарах ахуйн хог хаягдын эх үүсвэр нь ажилчдын хэрэглээ, хоол бэлтгэлийн явц болно. Төслийн талбайд инженер техник ажилчид, машин механизмын жолооч, туслах ажилчид зэрэг ажилчид ажилана.

Хатуу хог хаягдлыг зайлцуулах: Ажилчдын түр суурин, гал тогооноос гарах ахуйн хатуу хог хаягдыг төслийн талбайд таглаатай, зориулалтын саванд цуглуволж, дахин боловсруулах боломжтой хэсгийг дахин боловсруулах, үлдсэн хог хаягдлыг орон нутгийн захираганы шийдвэр, холбогдох гэрээ, журмын дагуу тогтмол хугацаанд хогийн нэгдсэн цэг дээр тээвэрлэн зайлцуулах шаардлагатай.

*Замын бүтээн байгуулалтын үед үүсэх хатуу хог хаягдал*

Замын бүтээн байгуулалтын ажлын явцад гарах хог хаягдыг хуримтлуулах, түр хадгалах төвлөрсөн хогийн цэгийн менежментийг төлөвлөн зохион байгуулах шаардлагатай. Учир нь, зам тавихад их хэмжээний барилгын материал бэлтгэн, нутгийн хөрсний шинж чанар, төлөв байдал өөрчлөгдөн, улмаар ургамлын нөмрөг доройтон, биологийн төрөл зүйлийн тоо, хэмжээ, тархалт өөрчлөгдөх зэрэг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нөхцөл үүснэ. Замын барилгын технологийн онцлогоос шалтгаалан замын барилгын байгуулалтын ажлаас битум, цемент зэргийн үлдэгдэл, техникийн шаардлагад тэнцэхгүй ухманы материалиуд, шатах тослох материалын хаягдал гарна. Техник технологийн зааварчилгаа, журмыг баримтлан ажилласан нөхцөлд битум, цементний үлдэгдэл зэрэг хог хаягдал гарахгүй байх нөхцөлтэй.

Зам тавихад хэрэглэх элс хайрга нь бат бөх зэрэг шаардлагдах чанарын хувьд стандартад тохирох эсэхийг зохих газарт шинжлүүлсний дараа шаардлага хангасан материалыг хэрэглэх тул карьер болон ухмалаас гарах техникийн шаардлагад тэнцэхгүй материалын хэмжээг урьдчилан тооцох боломжгүй юм.

Замын хатуу хучилт хийх битумэн зуурмагийг бэлтгэх технологи ажиллагааг хатуу баримтлах шаардлагатай байдаг бөгөөд технологийн горим алдагдан техникийн шаардлага хангахгүй болсон зуурмагийг ил задгай, замбараагүй хаясан нөхцөлд тухайн талбайн хөрс, ургамлан бүрхэвчийг бохирдуулах, улмаар устгах аюултай. Санамсаргүй

байдлаар ийм төрлийн хаягдал гарсан нөхцөлд уг зуурмагийг орон нутгийн хатуу хог хаягдын цэгт гэрээ, зөвшөөрлийн дагуу зөөверлон зайлцуулах шаардлагатай.

#### Шингэн хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас гарах шингэн хаягдын эх үүсвэр нь хоол бэлтгэлийн явцад гарсан бохир ус, цэвэрлэгээнд хэрэглэсэн бохир ус болно. Ахуйн хэрэгцээнээс гарч буй шингэн хаягдыг хөрс, ус бохирдуулахгүй байхаар зайлцуулах шаардлагатай.

#### Хийн хаягдал

Төслийн хувьд хийн хаягдал үүсэх эх үүсвэр нь хөдөлгөөнт эх үүсвэр болох тээврийн хэрэгсэл, машин механизмын утаа юм. Иймд төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд узуулэх нөлөөлөл нь тээврийн хэрэгсэл, машин механизмын угааны найрлагаар агаар орчин бохирдуулагч бодис ялгарах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр агаар тоосжих зэрээр агаар бохирдох нөхцөлтэй байна.

#### 6.3. Хог хаягдын менежментийн зөвлөмж

Төслийн үйл ажиллагаанаас буюу зам барилгын үе шатанд ажилчдын ахуйн болон зам барилгын үйл ажиллагаанаас хатуу хог хаягдал, шингэн хаягдал, хийг хаягдал гарна.

**Ахуйн хатуу хог хаягдыг зайлцуулах:** Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдыг төслийн талбай дахь хог хаягдын цэгт цуглуулж, харьяа орон нутгийн холбоогдох байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр цаг тухай бурд нь хогийн нэгдсэн цэг дээр тээвэрлэн зайлцуулах шаардлагатай. Цаашид хог хаягдын менежментийг хэрэгжүүлж, хатуу хог хаягдаар орчны хөрс, агаар бохирдооос сэргийлж, ахуйн хатуу хог хаягдыг ангилан ялгаж дахин боловсруулах цэгт тушаах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

**Зам барилгын ажлын үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдыг зайлцуулах:** Техник технологийн зааварчилгаа, журмыг баримтлан ажилласан нөхцөлд битум, цементний үлдэгдэл зэрэг хог хаягдал гарахгүй байх нөхцөлтэй. Зам барихад хэрэглэх элс хайрга нь баг бөх зэрэг шаардлагдах чанарын хувьд стандартад тохирох эсэхийг зохих газарт шинжлүүлсний дараа шаардлага хангасан материалыг хэрэглэх тул карьер болон ухмалаас гарах техникийн шаардлагад тэнцрхүүгий материалын хэмжээг урьдчилан тооцох боломжтүй юм. Замын хатуу хучилт хийх битумэн зуурмагийг бэлтгэх технологи ажиллагааг хатуу баримтлах шаардлагатай байдаг бөгөөд технологийн горим алдагдан техникийн шаардлага хангахгүй болсон зуурмагийг ил задгай, замбараагүй хаясан нөхцөлд тухайн талбайн хөрс, ургамлан бүрхэвчийг бохирдуулах, улмаар устгах аюултай. Санамсаргүй байдлаар ийм төрлийн хаягдал гарсан нөхцөлд уг зуурмагийг орон нутгийн хатуу хог хаягдын цэгт гэрээ, зөвшөөрлийн дагуу зөөверлон зайлцуулах шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нь серөг нэлэөллийг бууруулах, урьдчилан сэргийлж, арилгах хог хаягдын менежментийн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үндэс:

- \* Ажилчдын байр, сууринг барихдаа ариун цэврийн нэгдсэн цэг, бие засах газар, шингэн хог хаягдыг хаях, хатуу хучилт хийж доторлосон тусгай нух цооногт хийх эсэл зөөврийн био жоронг ашиглах. Эндээс гарах хог хаягдыг зөвшөөрөгдсөн цэгт анхан шатны ариутгал хийж зориулалтын машинаар зөөж зайлцуулна. Төсөл хэрэгжүүлэгч нь техник технологийн зааварчилгаа, журмыг баримтлан ажилласан нөхцөлд битум, цементний үлдэгдэл зэрэг хог хаягдал гарахгүй байх нөхцөлтэй гэдгийг сайгар анхаарах.
- \* Тус замын барилгын ажлын үе шатанд хог хаягдын менежментийг хэрэгжүүлж, хатуу хог хаягдаар орчны хөрс, агаар бохирдооос сэргийлж битүү зориулалтын

- саванд хуримтлуулж, ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж орон нутгийн холбогдох байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлэн зөөверлөх.
- Зам барилгын үед ашиглах талбайг үнэн зөв тогтоох, шатах тослох материал хадгалах, засвар хийх талбайг үер, галын аюулд өртөхөөргүй газарт сонгон байрлуулж, санамсаргүй тохиолдлоор асгарахаас сэргийлэх.
  - Ахуйн бохир усыг бохир усны цооногт цуглуулах бөгөөд бохир ус хадгалах цооног нь “Ахуйн бохир усны цооногийг доторлож ашиглах журам”-ын (БО-ны, ЭМ-ийн сайдын 1995 оны 169/171 дүгээр тушаалын хавсралт) шаардлагыг хангасан байх шаардлагатай.
  - Хог хаягдлыг цуглуулах зориулалтын сав, хогийн цэгийн орчмыг цэвэрлэх, цуглуулах сав байгуулах.
  - Хатуу хог хаягдал нь удаан задарч, бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учир байгаль орчинд хамгийн их хор хөнөөлтэй. Иймд төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаандaa байгальд шууд хаяхаас илүүтэй хог хаягдлын менежментийн 3R /Reduce- хаягдлыг дахин ашиглах, Recycle - хог хаягдлыг дахин боловсруулах, Reuse - хог хаягдлыг дахин ашиглах/ санаачлагыг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй.
  - Дахин ашиглагдах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж хоёрдогч түүхий эд хүлээн авах газарт нийлүүлэх нь хэрэгтэй. /Жишээ нь түүхий эдийн сав баглаа боодол/.
  - Гал тогооноос гарах хатуу хог хаягдлыг болон ажилчдын өдөр тутмын хэрэгжүүлэс гарах ахуйн гаралтай хог хатуу хаягдлыг нэг цэгт төвлөрүүлж, ангилан ялгаж, битүүмжлэл сайтай зориулалтын төмөр саванд цуглуулж зөвшөөрөгдсөн цэгт булж орон нутгийн засаг захираганаас заасан цэгт зайлцуулна.
  - Хог хаягдлын зориулалтын цэгээс нэгдсэн хогийн цэгт тээвэрлүүлэхэд “MNS 5344:2011 “Ахуйн хог хаягдал тээвэрлэхт, ангилал. Ерөнхий шаардлага” стандартыг баримтална.
  - Хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах буюу хог хаягдал бага үүсгэдэг, үр ашигтай, удаан хугацаанд ашиглах боломжтой, байгаль орчинд хор хөнөөл багатай түүхий эд, бүтээгдэхүүн хэрэглэх.

Тус төслийн хэрэгжүүлгийн хугацаанд аль болох хог хаягдлыг бага таргах боломжит нехштийг бүрдүүлж ажиллах ба хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тавигдсан эрх, үүргийг хүлээж, хориглосон үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх тал дээр анхаарч ажиллах.

Төсөл хэрэгжүүлэгч нь дараах **Үргийг** хүлээнэ. Үүнд:

- Энгийн хог хаягдаа ангилан ялгах / Хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, цуглуулах төрөлжүүлэн ялгах/;
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх
- Эзэмшилийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;
- Нийтийн здэлэбэр газрын хог хаягдал, пас, месийг цэвэрлэх;
- Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, успах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;

Эдгээр үйл ажиллагааг **хориглоно**. Үүнд:

- Хог хаягдлыг дэд бүтцийн шугам, хоолой руу хаях
- Хог хаягдлыг ил задгай шатаах

- **Хог хаягдлыг тогтоосон цэгээс бусад газарт хаях**
- **Хөрс бохирдуулагч жорюн байгуулах**
- Зууханд нийлэг материалтай хог хаягдал шатаах
- Нийтийн эзэмшилийн хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх

## БҮЛЭГ 7. ГЕОЛОГИЙН ТӨГТОЦ, ГЕОМОРФОЛОГИ

Энэхүү төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, судалгааны хээрийн ажлыг “Мон Газар Экологи” ХХК-ийн баг бүрэлдэхүүн 2021 оны 11 сарын 20 өдөр хийж гүйцэтгэсэн болно. Төслийн талбайн орчимд тархалттай геологийн формациудыг гадаргуугийн хайгуулаар ялгаж тодохойлох боломжгүй тул төсөл хэрэгжих орчмын геологийн өмнө нь хийгдсэн судалгааны тайланг энэхүү бүлэгт ашигласан болно.

### 7.1. Геологийн тогтоц, геоморфологи

Төсөл хэрэгжих талбайн орчим нь Бэрхийн хүдрийн районд 1925-1956 онд эхний үе шатны ажлуудаар геологийн маршрутын судалгаа, зарим талбайд эрэл үнэлгээний ажлууд хийгдсэн бөгөөд Бэрх, Дэлгэрхаан, Хөлний холбоо, Чимидийн зэрэг ордыг шингэр иżeg 1956 онд Бэрхийн ордод хайгуулын ажил явуулжээ.

1:50000 масштабын геологийн зураглал, 1988-1990 онд явуулсан хээрийн судалгааны ажил, фондод буй өмнөх судлаачдын болон нийтлэгдсэн материал дээр тулгуурлан тухайн талбайн геологийн бүтэц тогтоцыг томъёолсон.

Төслийн талбайн орчмын геологийн бүтцэд тунамал, болон тунамал галт уулын ба дээд шерми, дунд юра, дээд-доод цэрэл, доод цэрэл ба дөрөвдөгчийн Дунд дэд давхаргадас цагаан саарал, ягаавтар, улаан ба шар цахиурлаг порфир, дацит ба тэдгээрийн туфо-элсэн чулуу, туфо-гравелитийн үешилтгэй туфээс тогтоно. Үсийн интрузив үүсэл тохиолдоно. Дээд дэд давхаргадас нь трахилитарит, трахиандезитын порфир ба туфээс бүрдэн. Үнд:

1. **Шермийн систем. Дээд хэсэг.** Гадзорын давхаргадас. Бэрх ба Малийн хүдрийн зангилааны баруун хойд хэсэгт энэхүү давхаргадасны үүслүүд 50 км<sup>2</sup> талбай эзлэн оршино. Литокристалт хэмхдэслэг бөсөл, галт уулын брекчийн зузаан багцтай холилдсон риолитийн лаваас бүрдэнэ. Дацит ба дацит-андезитын лав бүхий түвшингүүд багавтар хэмжээгээр тохиолдоно. Палеозойн боржин, девона хурдас дээр галт уулын үүсэлтэй чулуулаг орших ба тэдгээр нь Юрьын боржинногоор хэрчигдсэн байна.

2. **Улзын давхаргадас.** Малийн ордоос урагш ба баруун хойшоо багавтар 2 км<sup>2</sup> хэртэй талбайд элсэн чулуу, гравелит, алевролит, хөрзөн чулууны хэлбэрээр тохиолдоно.

3. **Юрийн систем. Дунд хэсэг.** Жаргалантын голын давхаргадас Бэрхийн хүдрийн районы өмнөд хэсэг, Бэрхийн хүдрийн зангилааны урд зааг дагуу тухайн давхаргадас оршино. Давхаргадас доод, дунд, дээд дэд давхаргадаст хуваагдана. Доор орших үүслүүдтэй өнцгийн зөрүүтэй тогтоц үүсгэх элсэн чулуу, алевролитын үешил бүхий хөрзөн чулуу, хөрзөнлөг брекчүүдээс бүрдэнэ.

4. **Дээд юр-доод цэрэл. Цагаанцаывын давхаргадас.** Малийн ордын хязгаарт нэлээд талбайг эзлэх ба Цагаанцаывын томоохон буурц болон зуун тийш Батноровын, урагш Олончуурын хотгорыг хамарна. Давхаргадас нь үндсэн ба дунд эфузив хучдас болох ба ул чулуулагтай зохицох оршдос үүсгэн тогтсон. Буурцын (депрессийн) үндсэн тэнхлэгт чигтэй унал бүхий багавтар напутгай оршдос болно. Давхаргадас нь доод ба дээд дэд давхаргадаст хуваагдана. Доод давхаргадас терригений хөрзөн чулуу, элсэнчулуу, алевролит, гравелит, базалтын нимгэн үенцэр бүхий тунамал хурдаас бүрдэнэ. Энэхүү давхаргадас буурцан хүрээ хавиар гадаргад иш гарсан нь тохиолдоно. Дээд давхаргадас нь илүү тархаттай бөгөөд галт уулын үүсэлтэй (базальт,андезит-базальт) чулуулгийн зузаалгаас бүрдэнэ. Давхаргадасын зузаан 1000-1200 м орчим.

5. **Цэргийн систем.** Доод хэсэг Зүүнбаянгийн давхаргадас. Тухайн давхаргадас ордоос зүүн урагш ба буурцан захыг даган тогтсон. Цагаанцаывын давхаргадасын дунд-үндсэн эфузив дээр ул зохицсон тогтоц бүхий бараг бараг хэвтээ оршдостой. Суурь хэсэг нь элсэн чулуу ба алевролит бүхий хөрзөн чулуулгийн дээд хэсэг нь элсэн чулуу

алевролитын холимогшлоос бүрдэнэ. Давхрагдсын зузаан нь 100-300 м. Дээд хэсэгт нь маш нимгэн нүүрсний үе бүхий элсэн чулуу байна.

6. Дөрөвдөгчийн систем. Усны урсгалаар зөөгдсөн алнови-проловийн хайрга, элс, элсэнцэр, шавранцар, проловийн хайрга, элсэнцэр шавранцар, дайрга, бэлний үндсэн чулуулгийг хучих делови-эловийн бул чулуу, дайрга, элсэнцэр шавранцаас бүрдэнэ. Зузаан нь 30-40м. Дунд дөрөвдөгчийн үүсэл ихэвчлэн буурц ажиглагдах талбайд тохиолдоно. Ихэвчлэн хайрга, элс, шавраас бүрдэнэ. Орчин үеийн хурдас алнови, проловийн хайрга, элс, элсэнцэр, шаварлаг зэрэг нь түр урсацтай гольдролд таарах ба проловийн хайрга, шавранцар, дайрг зэрэг уулын хормойн хурдас, делови-эловийн бус чулуу, дайрга, элсэнцэр, шавранцар ба бэлний ул чулууг хучигч хурдас зэрэг хурдас 0,5-5,0м зузаан үе үүсгэн тохиолдоно. Бэрхийн худрийн район ба Малийн худрийн зангилаанд түрүү палеозой, түрүү мезозойн интрузив ба судалын үүслүүд бий. Малийн ордын талбайд зөвхөн түрүүн палеозойн интрузив тархсан байна.

7. Түрүү палеозойн интрузив. Хэрлэнгийн бүрдэл. Хэрлэнгийн бүрдлийн түрүү палеозойн интрузив нь Малийн орд дээр хязгаарлагдмал хэсгүүдийн байдлаар Засголын буурын зааг хавиар оршино. Интрузивийн бүрэлдэхүүнд боржин, биотитогт гранодиорит, амфибол-биотитийн дунд-том ширхэгтэй, профир маягийн чулуулаг тохиолдоно. Эрдсийн бүрдэл: Калийн хээрийн жонш (30-45%), плагиоклаз (20-35%), цахир (22-35%), биотит (5-10%), эвэр хуурмаг (<5%) болон магнетит, ильменит, циркон, сfen, монацит зэрэг 2-р зэргийн эрдсүүд бий. Хэрлэнгийн боржин нь худрийн зангилааны жоншийн ордуудын ихэнхийг агуулах орчин болдог.

Зүүн монголын флюоритын бусийн худрийн районы Малийн зангилаанд Малийн орд оршино. Ихэнх судлаачид худрийн зангилааны бүтцийн байр суурийг Малийн галт уулын тогтоцтой холбож үздэг.

Бэрхийн худрийн талбайн хил ба хойгуур өнгөрөх Батноровын хагарлаас урдуур өнгөрөх Засголын гүний хагарлын нэлөөлөлд уг худрийн зангилааг авч үзэх шаардлагатай. Засгол ба Олоннуурын бууриуудын зааг болох Меридианы дагуу чиглэлтэй хагарлуудын системийг дагасан палеозойн боржингийн цухуйцад худрийн талбай холбогдоно. Худрийн талбайн бүрдэлд 2 давхар ажиглагдана.

Доод давхар нь палеозойн боржингоос бүрдэх цухуйшууд юм. Дээд бүтцийн давхар нь хожуу мезозойн тектон-магмын идэвхижлийн районыг илтгэх Засголын буурац юм.

Доод хэсэгтээ том хэмхдэст терриген үүсэл, дунд, дээд хэсэгтээ цагаанцааны давхаргадасны дээд юр-доод цэрдийн базалтлаг ба шүлтлэг-хучиллэг вулканитаас бүрдэнэ.

## 7.2. Тесэл хэрэгжих бүсийн ашигт малтмал, тэдгээрийн байршил

Бэрхийн худрийн районд флюорит, холимог металл, молибден, вольфрам, цагаан тутамга, алт, чимэгээлийн чулуу зэрэг ашигт малтмал бий. Жонш нь тус районы гол эрдсийн түүхий эд болно. Бэрх, Дэлгэрхаан, зэрэг томоохон орд, Чимиidийн, Сэргээн, Овоо-Сум Хутаг, Хелийн холбоо, Конс-өндөр, Улс-өндөр, Наран уул, Пионер гэх мэт жижиг орд, илэрцүүдийг тухайн үед нь тогтоож ихэнхэд нь ашиглалт явуулсан. Флюоритын худэржилт нь цахир-флюоритийн судал хэлбэрээр тохиолдоно. Худрийн бистүүд тасалдлын бүтээд, үндсэндээ хожуу мезозойн өмнөх суурь ба хожуу мезозойн галтуул-тектоник буурацын хагарлын цавууд дахь талстлаг чулуулагт үссэн ба 900-1400м өндөржилтэй хэсгүүдэд тохиолдоно. Худрийн бист бүрэлдэх үндсэн металлгений хүчин зүйлүүд:

- Магмын хүчин зүйл нь флюоритын эрдэсжилтийг цагаан цавын давхаргадасны базалттай холбоно.

- **Үйлдвэрлэлийн ач холбогдолтой ордууд ба илэрцүүд нь 0,2% фтор агуулсан базалт ба андезит-базальтын хотойцуудын орчимд бүрэлдсэн.**
- **Тектоник.** Хүдрийн эрдэсжилт тодорхой тасалдал, хагарлын бусэд тохиолдоно. Зүүн-Хойд ба баруун хойд чиглэлийн бүсүүд хүдэржилтийн коэффициент талаас өөр хоорондоо ойролцоо.
- **Бүтэц.** Хүдрийн объектуудын хэлбэршил нь мезозайн тектоник хотойцуудын хажуу хэсэгтэй холбоотой бүтэц харуулдаг.
- **Литологи.** Чулуулгийн бүрдэлд хүдэржилтийн илүү тохиromжтой нутагшил (байрзүй) нэлөөлсөн.
- **Холимог (хар тугалга, цайр) метали.** Толгойт болон бусад цэгүүдэд илэрцүүд тогтоогдсон.
- **Молибден, вольфрам.** Бурд, Баянхаан хэмээх газарт илэрцүүд тогтоогдсон.
- **Цагаан тугалга.** Бэрх-Дэргэрхaanы бүсийн өргөрөг дагуу хагарлууд орчмоор цахир-касситеритийн илэрцүүд тогтоогдсон. Үүнд Шархадны комплекс багтана.
- **Чимэглэлийн чулуу.**

Гартаам. Зарим талбайд гартаамын үйрмэг (шороон) илрэц буй боловч үйлдвэрлэлийн сонирхолт татахуйц талбай тогтоогдоогүй. Цаашид энэ чиглэлээр судалгаа шаардлагатай. Ордын тогтцод дээд юра-доод цэrdийн цагаан-цавын давхаргадсын базалт тохиолдоно. Базалт, андезито-базальтаас бүрдэх цагаанцавын чулуулаг ордын бүх талбайд бий. Эдгээр нь баруун хойш  $30-50^{\circ}$  уналтай, чулуулаг нь бараан саарал, хар, ногоовтөр, саарал, ягаавтар хүрэн өнгөтэй.

Гартаам, кальцит, флюоритын 1-10 см хэмжээтэй үүслүүд дээрх чулуулаг дотор тохиолдоно. Зарим хоосон зайд болор, ягаан болорын ургацаг таарна. Эрдсийн бүрдэл: плагиоклаз- 68-75%, худэр-10%, карбонат-5%, цахир 1%.


Хоёрдогч болох иддингсит ба серпентино-хлорит нь бөөгнөрөл ба зарим жижиг хайрслаг үүсэл хэлбэрээр тохиолдоно.

- **Худэр.** 2 мм хүртэл ширхэг үүсгэнэ. Цахир 0.5 мм хүртэл хэмжээтэй байна.
- Боржин, порфирлог боржин нь ягаавтар саарал, бараан саарал, ногоовтор саарал жижиг, дунд зэрэг ширхэгтэй байдаг.
- Хаваас хэлбэрийн үүслүүд диабаз, диорит, андезитын порфирын судал байдлаар тохиолдоно.
- Дөрөвдөгчийн хурдас шаварлаг, элсэнцэр, дайрга, сул барыцалсан хайрганцар зэрэг чулуулгаас бүрдэнэ.

### 7.3. Физик-геологийн үзэгдэл, үйл явц

Авто замын зурvasын дагууд физик-геологийн үзэгдэл нийзэд хөгжсөн байна. Эдгээр үзэгдэл, процессыг 2 ангиан үзүүлээ.

1. **Намагжих үзэгдэл:** Ус, намгархаг газар гэдэг нь хуурай газар, устай нийлж буй шилжилтийн хэсэг бөгөөд энэ хэсэгт усны урсгал, хөрсний шим тэжээлийн эргэлт, нарны энерги нийлэн өвөрмөц экосистемийг үүсгэдэг. Төсөл хэрэгжих талбай нь Хурхын гол, Жаргалантын гол, Баян гол зэрэг томоохон голуудыг дайран өнгөрөх бөгөөд Хурх, Хүйтэний голын хөндийн нуурууд ус, намгархаг газартай.




Зураг 22. Замын трассын дагуу дайраадах томоохон ус, намгархаг газар, Хурхын их хөндий

2. Түр зуурын урсгал усны үйл ажиллагаа: Энэ үзэгдэл авто замын зурvasын дагууд түгээмэл ажиглагдана. Хаврын улиралд цасны ус хайлах, дулааны улиралд орсон их хэмжээний хур тунадасны усаар түр зуурын уерг автах нөхцөлтэй.

#### 7.4. Цэвдэг

Судалгааны зурvas талбай нь улирлаар хөлдөж гэсдэг бүслүүрт болон олон жилийн цэвдэг тохиолдлын тархалттай бүслүүр болон улиалын хөлдөлтийн бүсэд хамаарч байгаа бөгөөд олон жилийн цэвдэг хөрс илрээгүй болно.




Зураг 23. Монгол орчны цэвдэгийн зураг

## 7.5. Газрын гадаргын налуужилт

Газрын гадаргын налуужилт нь аливаа төслийн үйл ажиллагааны нөхцөлийн тодорхойлдог чухал хүчин зүйл болно. Судалгааны талбайн хувьд 0.88-8.82 градусын налуутай буюу дараах ангилалд хамаарч байна.

- 3<sup>0</sup>-ас бага налуутай бол аж ахуйн аливаа үйл ажиллагаа явуулахад тохиромжтой.
- 3-6<sup>0</sup> налуутай бол нисэх онгоцын буудлаас бусад зориулалтаар ашиглах боломжтой.
- 6-12<sup>0</sup> налуутай бол газар тариалан, аж ахуйн зарим салбарт тохиромжоор муу ба барилга байгууламж барыж байгуулахад газар шорооны ажлын хэмжээ ихэсдэг.
- 12-20<sup>0</sup> налуутай бол газар тариалан, зам харишцаанд тохиромж муутай, учир эвдэрэлээс хамгаалах нэмэлт байгууламж барыж байгуулах хэрэгтэй.



Зураг 24. Төлөвлөж буй трассын дагуу орчмын гадаргын налуужилт

## БҮЛЭГ 8. ГАДАРГЫН УС БА ГАЗРЫН ДООРХИ УС

### 8.1. Гадаргын усны сүлжээ, урсац, иөөц

Судалгааны район нь усзүйн хувьд Хойд мөсөн далайн ай сав хамаарна. Энэхүү ай савд Монгол орны нутаг дэвсгэрийн 20.6% хамаарах ба гол мөрний бүх урсацын 52.1% бүрэлддэг байна. Усан сүлжээний наягшил, гадаргын урсац ихтэй байна. Гол мөрний наягшил 0.07 км/км<sup>2</sup> бөгөөд тэжээлийн төрлүүд нь гүний ус 20-35%, борооны ус 40-50%, цасны ус 15-20%-ийг эзэнэ.

Урсацын жилийн тархалт нь тэжээлэсээ хамаарч сар улирлаар харилцан туйлын адилгүй бөгөөд хаврын их зарцуулга нь 4-р сарын дунд орчимоос 5-р сарын дунд үе хуртэл үргэлжилсэн энэ нь цас хайлж хаврын шар усны үер үүсэхтэй холбоотой. Цас хайлахаадаа ихэнх нь уурших, хөрсөнд нэвчих зэрэгээс хамаарч багахан хэсэг нь шар усны үерийг үүсгэнэ. Хаврын шар усны үер онгорсний дараах хугацаанд хур бороо бага, ууршилт их болдогоос голын усны зарцуулга татарч хавар зуны завсрлын үсийн усны нам түвшин тогтолц бараг 7-р сар хүрнэ. Хур тунадас их унадаг 7,8-р сар хаяа 9-р сард голын усны зарцуулга ийлээд их нэмэгдэж жилийн бүх урсацныхаа 60-80%-ийг онгореөнө. Жижиг голууд 12-р сард ёроолгүй хөндөж урсацгүй болдог байна. Жижиг голуудын усны эрдээжилт нь 100-200 мг/л байна.


Төлөвлөж буй авто замын зурvasын газар нь гадаргын усны сүлжээний хувьд Хойд мөсөн далайн ай савд хамаарах бөгөөд Онон, Хэрлэн голын сав газарт багтана. Замын трасс нь Хурхын голын баруун хойд хэсгээр 50-9224 м-ийн алслагдан дайран өнгөрөх ба байгын урсацтай Жаргалантын гол, Баян гол, Навчийн гол, түр урсацтай Зүүн зүртийн гол, Жаргалантын булаг, Чандмань гол, Тэнгэлийн гол, Бор булаг, Өглөгчийн гол зэрэг голууд урсана. Трассын дагуу Айраг нуур, Ар нуур, Холбоо нуур, Шар нуур, Биндэр нуур, Баян нуур, Булангын нуур, Цагаан нуур болон нэр нь тодорхойгүй 7 давс нуурууд байна. Баян булаг, Жаргалантын булаг, Баруун хогнийн булаг, Залаагийн булаг, Өгөөмөрийн булаг, Бор булаг, Чулуут булаг, Ург булаг, Талын булаг зэрэг 20 орчим булаг, шанд тааралдана. Замын трассын дагуу дайралдсан нуурууд байна.




Зураг 25. Замын трассын дагуу дайралдсан нуурууд



Зураг 26. Замын трассын дагуух худгүүд




Зураг 27. Замын трассын дагуух голууд




Зураг 28. Төслийн талбайн гадаргын усны зураг

Хүснэгт 20. Монгол орчны усны сав газрууд, тэдгээрийн усны нөөц


№	Усны сав газрын нэр	Ус хурх талбай, км <sup>2</sup>	Ай сав	Ашигтай буй усны нөөцийн төрөл	Гадаргын усны нөөц				Газрын доорх усны нөөц	
					саям <sup>3</sup> /жил			саям <sup>3</sup> /жил		
					Нийт	Экологийн	Ашиглах боломжит	Баримжат	Ашиглалт	
0	1	2	3	4	5	6	7	8	9	
1	Онон	28,241.0	НД	ГУ/ГДУ	1,480.0	1,211.0	259.0	344.0	0.6	
2	Хэрээн	107,906.0	НД	ГУ/ГДУ	567.0	507.0	59.5	721.0	43.9	



Зураг 29. Замын трассын төгсгөл хэсэг, Биндер сум, 115 дахь км




Зураг 30. Замын трассын эхний 95-110 км орчмын байрзүйн зураг




Зураг 31. Замын трассын эхний 75-95 км орчмын байрзүйн зураг




Зураг 32. Замын трассын эхний 50-75 км орчмын байрзүйн зураг




Зураг 33. Замын трассын эхийн 40-50 км орчмын байрзүйн зураг



Зураг 34. Замын трассын эхийн 20-40 км орчмын байрзүйн зураг



Зураг 35. Замын трассын эхийн 20 км орчмын байрзүйн зураг



Зураг 36. Замын трассын эхний 10 км-ийн байрзүйн зураг

## 8.2. Төсөл хөргжих нутаг дэвсгэр, түүний орчмын томоохон гол, мөрөн, нуурын мэдээлэл

Онон голын сав газар нь хамгийн тод ялгарсан, маш тогтвортой хил буюу ус хагалбарын шугамаар хязгаарлагдсан байдаг. Гол мөрний сүлжээ нь байгаль, дэлхий дээрх хамгийн эрэмбэлгэдэж, цэгцэрсэн нэгж, систембөгөөд энэ нь байгалийн баялгийн ашиглалт, хамгаалалтыг системчлэх үндэс болно. Онон гол Хэнтийн нууруны зүүн хойт хажуугийн Ононгийн халуун рашааны орчмоос эх авах бөгөөд нийт 808 км урт, 94040 км<sup>2</sup> ус хурах талбайтай, уүний 575 км урт, 29070 км<sup>2</sup> талбай нь Монголын нутагт оршино. Голын сав газарт нийтдээ 166 гол горхи, 47 нуур цөөрөм байдаг (2007 оны тооллого). Онон гол нь уулын гол тул унаалт ихтэй, урсгал хурдтай байдаг. Зарим газраа урстгалын хурд 1.5-2.0 м/с хүрэх боловч Балжийн бэлчирээс доош 1.0 м/с орчим болж буурна. Онон голын томоохон цутгал Агац, Балж, Эг, Барх, Жаргалант голууд нь эгц налуу хажуу бүхий уулархаг газраар урсдаг. Өнөөдрийн байдлаар Онон болон түүний цутгал голууд болох Хурх, Эг, Барх болон Балж гол дээр ус судалын 5 харуул, Гурван нуурын харуул зэрэг нийтдээ 7 ус судалын харуул ажиллаж байна. Цаашид ч Онон голын зарим томоохон цутгал голууд дээр ус судалын харуулуудыг байгуулах шаардлагатай. Онон голын усны жилийн дундаж өнгөрөлт Биндэр сум орчимд 32.9 м<sup>3</sup>/сек, Дадал сумын орчимд 56.4 м<sup>3</sup>/сек байгаа нь голын урсац уртын дагуудаа алдагдал багатай. Түүний цутгал голын хувьд олон жилийн дундаж өнгөрөлт нь 1.5-12.6 м<sup>3</sup>/сек хэлбэлзэнэ.

Хүснэгт 21. Онон голын зарим цутгал голын олон жилийн дундаж урсац

№	Гол, нуурын нэр	Ус хурах талбай, км <sup>2</sup>	Онон жилийн дундаж урсац		
			м <sup>3</sup> /сек	мм	км <sup>3</sup>
1	Онон-Биндэр	8810.0	32.9	105.0	1.01592
2	Онон-Дадал	25060.0	56.44	69.8	1.74283
3	Хурх-Хэнтий брингад	1520.0	1.50	30.8	0.04625
4	Эг-Батширээт	987.0	2.76	47.4	0.04625
5	Барх-Батширээт	1871.0	5.16	86.2	0.15947
6	Болж-Дадал	3698.0	12.63	106.6	0.39001

Шар ус, хур борооны үерийн их хэмжээ Онон голын дагууд 255-904 м<sup>3</sup> /сек, Хурх болон Эг зэрэг голуудын дагууд 45-70 м<sup>3</sup> /сек хүрнэ. Онон голын жилийн урсацын 15.5-31.1%-ийг газрын доорх ус, 6.5-12.7%-ийг хайлсан цас мөсний ус зэлэх бол хур борооны тэжээл давамгайлж 56.5-71.8%-ийг эзлий. Тухайн жилийн услагаас хамааран Онон голын сав газрын голуудын жилийн урсацын дийлэнх нь буюу 81.4-97.7% хавар зуны

улиралд ногдох (IV-X) бөгөөд хаврын саруудал (IV-VI сар) жилийн урсацын 9.5-14.8% бүрэлдэнэ. Хаврын урсац голын эх рүү ахиу бол зуны улирлын урсац голын дунд хэсгээр ахиу байна. Хүйтний улиралд жилийн урсацын 2.3-3.3% бүрэлдэх ба голын адаг руу өвлийн улирлын урсацын эзлэх хувь ишмэгдэнэ. Онон гол өвөлдөө ёроолдоо хүртэл хөлдөгтүй болно. Харин Хурх, Эг зэрэг бага голууд ёроолдоо хүртэл хөлдөнө.

Онон голын савд олон жилийн дунджаар  $3.12 \text{ km}^3$  (улсын хилээр) ус бүрэлдэх ба экологийн урсацын хэмжээ Онон голын дагууд олон жилийн дундаж урсацын 8-20% байх ба дунджаар 13.0% байна. Өөреөр хэлбэл, Онон голын сав дахь жилийн нийт усны хэрэглээ нь  $0.40 \text{ km}^3$  давахгүй байх шаардлагатай болно. Онон голын савд жилдээ 320.0 мм хур тунадас орно. Үүний 58-94 мм гадаргын урсацыг бүрдүүлж, үлдсэн 226-260 мм ууршилт, хөрс болон газрын доорх усны тэжээлд зарцуулагдана. Өөреөр хэлбэл, жилийн хур тунадасны 18-30% нь гол мөрний урсац болно. Статистик магадлалын загвараар дунджаар 100 жилд нэг удаа тохиох шар усны үерийн хэмжээ Онон голын дагуу  $730-850 \text{ m}^3/\text{сек}$ , хур борооны үер  $1360-2220 \text{ m}^3/\text{сек}$  хүрнэ.


Хүйтний улирлын гачиг үе томоохон гол мөрөнд 160-170 хоног, жижиг гол горхинд 190- 200 хоног үргэлжинэ. Онон-Биндэр харуулгаар тооцсон өвлийн гачиг үзийн онгөрөлт өвлийн улиралд  $0.14 \text{ m}^3/\text{сек}$  болно. Хөмөл голоор ОХУ-аас усны бохирдолт орж ирж улмаар Онон голын усны чанарт серөг илөөлөл үзүүлж байсан ба цаашид ч энэ байдал үргэлжлэх магадлалтай. Иймд гадаргын усны ажиглалт хэмжилтийн сүлжээг нягтруулж усны горим, неец, чанарын орон зай ба цаг хугацааны хувьд нягтруулж, ажиглалт хэмжилтийн багаж төхөөрөмжийг сайжруулан, чанартай, тасралтуй мэдээллийг бүрдүүлэх, улмаар хилийн усны асуудлаар ОХУ-тай гэрээ хэлэлцээрийг тодруулах, нарийвчлах шаардлага байна.

Хэнтэй аймгийн Цаг, уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчны шинжилгээний лаборатори нь гадаргын усны чанарт БОНХАЖСайдын А/02 дугаар тушаанаар батлагдсан хотолбөрийн дагуу 7 дугаар сард Хэрэгн гол /дээд болон доод цэг/, Онон гол /Биндэр сум/, Онон гол /Дадал сум/, Эг болон Барх гол /Батширээт сум/, Хурх гол /Өмнөдэлгэр сум/, Балж гол /Дадал сум/, Улз гол /Норовлин сум/ гэсэн хяналт шинжилгээний цэгээс нийт 9 дээж авч MNS 4586-98 стандартын дагуу 18-21 торлийн /биохимийн хэрэгцээт хүчил төрөгч (Bxx), жинзгэдэх бодис (ж/б), нитритийн азот ( $\text{NO}_2^-$ ), нитратын азот ( $\text{NO}_3^-$ ), аммони ( $\text{NH}_4^+$ ), фосфор (P), фтор (F), перманганатын исэлдэх чанар (ПИЧ), ЕС, магни (Mg), хлор (Cl), төмөр (Fe), кальци (Ca), хатуулаг, сульфат ( $\text{SO}_4^{2-}$ ), ууссан хүчилтөрөгч ( $\text{O}_2$ ), (цаашид дээрх үзүүлэлтүүдийг товчилсон нэрээр тэмдэглэнэ) /үзүүлэлтээр шинжилгээ хийн усан дахь бохирдуулах бодисын агууламжийг тодорхойлдог байна. Усны чанарын хяналт-шинжилгээний хотолбөрийн дагуу 04 дүгээр сарын 26-нд Хурх-Өмнөдэлгэр харуулын ажиглагч сорыцыг авч 04-р сарын 27-нд БОШЛ-д ирүүлж сорыцод усны химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойллоо. Сорыцод хийсэн шинжилгээний дүнгээс үзэхэд: голын усны эрдэжжилт 85,0 мг/л байсан ба голын ус үзүүлэлтээр усны чанарын стандарт MNS4586-98 дахь хүлээх агууламж /цаашид ХА гэх-/аас давсан бохирдолгүй, цэвэр байсан байна бохирдолгүй, цэвэр байсан байна.

Эх сурвалж: Онон голын сав газрын байгаль орчин, нийгэм эдийн засгийн суурь судалгааны хураангуй

### 8.3. Судалгааны талбай орчмын гадаргын усны лабораторийн шинжилгээний үр дүн

Байгаль орчны төлөв байдлын судалгааны ажлын хүрээнд төлөвлөж буй трассын дагуу гадаргын усны дээж авч Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлал, шим тэжээлийн лабораторид шинжилгүүлэв. Дээжлэлт авсан цэгээс тус бүр 1,5 литрийн хэмжээтгэй 1 дээжийг 2021 оны 11 сарын 20-ны өдөр цутглуулж, 2021 оны 11 сарын 22-ны өдөр нь лабораторийд хүргүүлсэн болно.



Зураг 37. Усны дээж авсан цэгийн байршил

Хүснэгт 22. Дээж авсан цэгүүдийн газарзүйн солбилцол

Дээж авсан цэгийн координат			
Хурхын гол			
Уртраг	110°	17'	31.415"
Өргөрөг	48°	25'	54.784"
Баян гол			
Уртраг	109°	49'	47.359"
Өргөрөг	48°	04'	48.593"
Өмнөдэлгэр сумын төвийн хүн амын үндны худаг			
Уртраг	109°	50'	35.05"
Өргөрөг	47°	54'	00.86"



Зураг 38. Уст цэг -01. Өмнөговь аймгийн сумын төвийн худаг



Зураг 39. Уст цэг-02. Хурхын гол



Зураг 40. Уст цэг-03. Баян гол

#### Лабораторийн шинжилгээний дүн:

Уст цэг -01. Өмнөговь аймгийн сумын төвийн худаг:

#### Хүснэгт 23. Усны химийн задлан шинжилгээний дүн

№	Шинжилсэн үзүүлэлт, ижж	ЗДХ	Шинжилгээний аргын стандарт	Шинжилгээний дүн
1	Усны орчин	6.5-8.5	MNS ISO 10523:2001	7.7
2	Цахилгаан дамжуулах чадвар, мСм/см	1.0	MNS ISO 7888:1999	0.408
3	Онго, градус	20.0	MNS ISO 7888:2000	20.0
4	Ерөнхий катуулаг, мг-экв/л	7.0	MNS 6778:2019	1.9
5	Кальци, мг/л	100.0	MNS 1097:1970	25.8
6	Магни, мг/л	30.0	MNS 1097:1970	0.7
7	Хлорид, мг/л	350.0	MNS 4424:2000	3.5
8	Сульфат, мг/л	500.0	MNS 6271:2011	8.0
9	Аммони, мг/л	1.5	MNS 1097:1970	0.2
10	Нитрат, мг/л	50.0	MNS ISO 7888:1999	0.03
11	Темер, мг/л	0.3	MNS 4430:2005	0.0
12	Нитрит, мг/л	1.0	MNS 6779:2019	0.02

13	Фтор, мг/л	0.7-1.5	MNS 6271:2011	0.2
----	------------	---------	---------------	-----

**Уст цэг-02. Хурхын гол:**

**Хүснэгт 24. Усны химийн задлан шинжилгээний дүн**

№	Шинжилсэн үзүүлэлт, нэгж	ЗДХ	Шинжилгээний аргын стандарт	Шинжилгээний дун
1	Усны орчин	6.5-8.5	MNS ISO 10523:2001	7.3
2	Цахилгаан дамжуулах чадвар, мСм/см	1.0	MNS ISO 7888:1999	0.248
3	Өнгө, градус	20.0	MNS ISO 7888:2000	20.0
4	Ерөнхий хатуулаг, мг-экв/л	7.0	MNS 6778:2019	1.1
5	Калыци, мг/л	100.0	MNS 1097:1970	18.0
6	Магни, мг/л	30.0	MNS 1097:1970	2.4
7	Хлорид, мг/л	350.0	MNS 4424:2000	3.1
8	Сульфат, мг/л	500.0	MNS 6271:2011	4.9
9	Аммони, мг/л	1.5	MNS 1097:1970	0.03
10	Нитрат, мг/л	50.0	MNS ISO 7888:1999	0.0
11	Темер, мг/л	0.3	MNS 4430:2005	0.04
12	Нитрит, мг/л	1.0	MNS 6779:2019	0.002
13	Фтор, мг/л	0.7-1.5	MNS 6271:2011	0.2

**Уст цэг-03. Баян гол:**

**Хүснэгт 25. Усны химийн задлан шинжилгээний дүн**

№	Шинжилсэн үзүүлэлт, нэгж	ЗДХ	Шинжилгээний аргын стандарт	Шинжилгээний дун
1	Усны орчин	6.5-8.5	MNS ISO 10523:2001	8.1
2	Цахилгаан дамжуулах чадвар, мСм/см	1.0	MNS ISO 7888:1999	0.0224
3	Өнгө, градус	20.0	MNS ISO 7888:2000	25
4	Ерөнхий хатуулаг, мг-экв/л	7.0	MNS 6778:2019	1.1
5	Калыци, мг/л	100.0	MNS 1097:1970	14.0
6	Магни, мг/л	30.0	MNS 1097:1970	4.2
7	Хлорид, мг/л	350.0	MNS 4424:2000	3.1
8	Сульфат, мг/л	500.0	MNS 6271:2011	1.1
9	Аммони, мг/л	1.5	MNS 1097:1970	0.06
10	Нитрат, мг/л	50.0	MNS ISO 7888:1999	0.0
11	Темер, мг/л	0.3	MNS 4430:2005	0.0
12	Нитрит, мг/л	1.0	MNS 6779:2019	0.003
13	Фтор, мг/л	0.7-1.5	MNS 6271:2011	0.0

Усны лабораторийн задлан шинжилгээний дунгээр шинжилсэн үзүүлэлтууд нь “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Үндны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үзүүлэлт. MNS 0090:2018” стандартад заасан зөвшөөрөгдхөд дээд хэмжээнээс бага буюу бохирдол үүсээгүй байгааг илтгэнэ.

Нийгмийн зүүрүү мэндийн үндэсний төвийн Хоол судлаал, шим тэжээлийн лабораторийн задлаг шинжилгээний дунг хавсаргав.

**8.4. Төслийн талбайн орчмын газрын доорх ус**

Төсол хэрэгжих бүс нутаг нь гидрогеологийн зоогдел хурийтлалын бүсэд уулс хоорондын өргөссөн хөндийд байрласан байна. Энэ орчмын өргөссөн хөндийд деревдэгчийн сэвсгэр хурдсан дахь уст ус давхарга, протерозойн түний ан цавын уст бүрдлийг ялгаж болно. Мөн түүнчлэн энэ орчимд тектоник хагарлын дагуу хагарлын ан цавын ус үүссэн байх бөгөөд гидрогеологийн өрөмдлийгийн үзүүлэлтүүдээр үндэрэг ихтэй /Q=4л/с/ худгууд гарсан байдаг байна.

**Дорогогчийн сэвсгэр хурдсан дахь уст үе:** Энэ уст үе нь уулс хоорондын хөндийг хамрах бөгөөд ус агуулагч чулуултуудад хайргархаг эс, шакартай хайрлганцар байна. Уст үеийн зузаан дунджаар 10м орчим гүнд хэлбэлзэнэ. Хөндийн ёроолоос булаг, горхи гарч орчныхоо газрыг намагшуулсан байна. Урьд өмнө Бэрхийн жоншины үйлдвэр орчимд Хэнтий аймгийн усны аж ахуйн газраас өрөмдсөн худгуудын өгөгдлүүдээс үзэхэд 1/55, 26/55 дугаартай худгууд нь ундрага сайтай, уст үе нь 12-36м гүнд илэрч 38м гүнд 4л/с бүхий ундрага өгч байсан байна. Гэхдээ уурхайн зориулалтгаар ашиглахад дээд талын 36м хүртэл газрын доорхи ус шүүрч орж ирнэ. Энэ орчимд урьд өмнө бэлчээр усжуулалтын чиглэлээр өрөмдсөн гүн өрмийн ундрага сайтай олон худгууд байсан байна.

**Проторозойн гүний ан цавын уст бүрдэл:** Энэ уст үе нь кембр, перм, юра-цэргийн галт уулын, тунамал, балхмал үүсэлтэй чулуулагт хагарлын ан цавын ус үүссэн байна. Ан цав бүхий чулуулгийн массив нь агаарын хур тунадасны чөөнөт нэвчилгээр тэжээгдэж буй болсон газрын доорхи усыг цуглуулан дамжуулан урсгах үүргийг гүйцэтгэдэг. Энэ хагарлын ан цавын ус нь дунджаар 150м орчим хүртэл нэвчих бөгөөд ундрага нь 1.0-2.0м түвшний бууралтанд 6л/с хүрдэг байна. Урьд өмнө өрөмдсөн 1/55 дугаартай 157м гүнтэй худгийн өгөгдлөөс үзэхэд 1.0м түвшний бууралтанд 2.3-4.3л/с ундрага өгч, 17.7м гүнд тогтсон байна. Энэ нь усжилтын хэмжээ их байгааг харуулж байна. Иймд малтгалтын явцад гүний ус их хэмжээгээр орж ирэх учраас түүнийг зайлцуулан ашиглах боломжтой.

Онон голын сав газрын газар зүйн хувьд гүний ус хурамтлуулдаг гол тогтоц нь голын хөндий, уулзвар бэлчир, адаг орчмын садаргууд, голын хөндий дахь өргөсөн хотгор юм. Тэдгээрийн дотор Батширээт сумын баруун хойно орших Арангатын хөндий, Онон, Хурх голын бэлчир, Хүрхрээ нуур, Их болон Бага цагаан нууруудын хоорондох хөндий, Балж, Галттай, Тэнгэлгийн голын бэлчир хөндийнүүд ордог. Хоттор, хөндий, тал, хоолойн үнэмлэхүй ондor 850-1200 м хооронд буюу өрөнхийдөө суусан шинжтэй. Олон жилийн цэвдэг Онон голын эх бүрдэж буй Их Хэнтийн нурууны зарим оргил, ар хажуугаар алаг цоог, тасалдсан байдлаар, харин Барх, Хурх, Шуус зэрэг голын ус хагалбар, уулын ар хажуу, Онон голын ус хагалбарын зарим хэсэгт ховор, алаг цоог, жижиг талбайд тархсан байдаг. Онон голын алтловийн хурдсаар хучигдсан хөндийд хур тунадсын 3-7 хувь, зарим салангид талбайд буюу өргөсөн хэсэгт 50 дээш хувь нь нэгчдэг байна. 400-500 мм хур буудаг Ононгийн эх, дунд орчмын бууж буй хурын 10-20 хувь, 500 мм хэмжээнээс дээш хур буудаг Онон голын эх орчмын уул нуруудыг бүрхэж тархсан сэвсгэр хурдсаар хучигдсан үндсэн чулуулаг руу бууж буй хурын 10-20 хувь нь тус тус шингэдэг байна. Онон голын сав гүний усны нөөц баялгийн зургийг үндэслэн 1 км<sup>2</sup> талбайн усны нөөц баялгийг 1) 16.5 л/с-ээс их буюу дунджаас их хүртэл нөөцтэй, 2) 1-3 л/с хооронд буюу дундаж нөөцтэй, 3) 0.1-1.0 л/с хооронд буюу багаас дундаж нөөцтэй, 4 ) 0.03-0.1 л/с хооронд буюу бага нөөцтэй, 5) 0.03 л/с-ээс бага буюу тун бага нөөцтэй гэж ангилан тооцоолоход 551.17 сая шоо метр буюу Онон голын сав газрын доорх усны нөөцеөр багатай байна. Энэ нь зөвхөн ойрын жилүүдэд усны хэрэглээг хангахад л хүрэлцэлтэй юм.

**Хүснэгт 26. Хур тунадасны нэвчилтийн хувь**


ГДУ-ны урсац, мм/жил	Хур тунадас, мм/жил			Нэвчилтийн дундаж хувь
	500 дээш	400-500	300-400	
Нэвчилтийн хувь	Нэвчилтийн хувь	Нэвчилтийн хувь		
5-10	-	-	1-3	2
10-20	-	3-7	-	5
20-50	-	5-13	-	9
50-100	10-20	-	-	15
>100	-	>50	>50	50

Эх сурвалж: Онон голын сав газрын байгаль орчин, нийгэм эдийн засгийн суурь судалгааны хураангуй

## **БҮЛЭГ 9. ХӨРСӨН БҮРХЭВЧ**

## **9.1. Төслийн талбай орчмын хөрсөн бүрхэвчийн шинж чанар, онцлог, төлөв байдал**

Төлөвлөж буй замын трасс нь Хэнтиййн аймгийн Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр сумдын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн дайран өнгөрөх бөгөөд тус бүс нутаг нь Монгол орны хөгжлийн мухалгаар Хангайн их мужийн Хэнтийн мужийн Хэнтийн зүүн тойрогт хамааралдана.



Зураг 41. Хөрс тазарзүйн мужлалтын зураг

Төсөл хэрэгжих талбай орчимд тархсан хөрсний жагсаалтыг) дараах хэв шинж, дэд хэв шинж, төрлийн хамаарна.

## ❖ Уулын ойн хөрс

Хэвшигж: Уулын ойн ширэгт бараан хөрс

Дэлхэврээнд

1. Хэвийн
  2. Нунтаг карбонатлаг
  3. Далд глейрхэг (нугархаг)
  4. Глейрхэг
  5. Бүдүүн ялзмагт
  6. Дарагдмал үетэй

❖ Уулын хээрийн хөрс

Хэв шинж: Уулын хүрэншороон хөрс

Дэд хэв шинж:

1. Карбонатгүй хархурэн
2. Нунтаг карбонатлаг хар хүрэн
3. Нунтаг карбонатлаг хүрэн

Төрлүүд:

1. Ердийн
2. Дээр карбонаттай
3. Доор карбонаттай

❖ Голын татмын хөрс

Хэв шинж: Аллювийн нутын глейрхэг хөрс

Дэд хэв шинж:

1. Аллювийн нутын ширэгт-глейрхэг
2. Аллювийн нутын далд глейрхэг бараан


Төрлүүд:

1. Ердийн
2. Карбонатлаг
3. Хужирлаг
4. Бусгаа

Эх сургалж: Монгол орны хөрс Доржготов Д., УБ 2003

## 9.2. Төлөвлөж буй замын трассын дагуу хийснүүдийн судалгаа

Тус төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хээрийн судалгааны ажлыг “Мон Газар Экологи” ХХК-ийн мэргэжилтэн, шинжээч нар 2021 оны 11-р сарын 20 өдөр гүйцэтгэв. Төсөл хэрэгжих зуравс газар нь Монгол орны хөрсний антишалаар уулын ойн, уулын хээрийн, тал хөндийн болон голын татмын хөрсний бүлэгт хамаарах уулын ойн нутгархаг, уулын ойн ширэгт бараан хөрс, уулыг хархурэн, уулын хүрэн, далд глейрхэг хар шороон хөрс болон аллювийн нутын хөрс тархсан байна.



Зураг 42. Төслийн талбайн хөрсний зураг

### Хөрсний нэр: Уулын ойн ширэгт барагн хөрс

#### Хөрсний нэрийн код: 1214

Энэ хэвшинжийн хөрс ойн бүсийн доод захаар хээрийн харшороон, хүрэншороон, нутын ялзмагт - далд глейрхэг хөрсүүдтэй хилжэх орших тул экологийн хувьд өргөн хэлбэлзэлтэй, гарал үүслийн хувьд өөр өөр чиглэлтэй байна. Нэгдүгээрт, тухайн био уур амьстадын иехцэлд бүсийн хэвшинжийн хөрс болж анхнаасаа бие даан тогтвортсон, хөсрүүдээрт, харшороон, хүрэншороон, нутын хөрстэй газар ой мод турж ургаснаас болоод тэдгээр хөрсний алдрал, хувьсал өөрчлөлтийн үр дунд бий болсон, гуравдугаарт, ойн ургамалшил алдарт хээрших үйл явцын нөлөөгөөр үүссэн байж болно. Энэ учраас тухайн хөрсний шинж төрх мөн олон янз бөгөөд заримдаа хээрийн хөрстэй адил нунтаг карбонатын хуримтлалтай, заримдаа нутын хөрсний глейрхэг шинжийг хадгалсан, тэр ч байтугай дарагдмал хөрсний үстэй ч бий. Ойн ширэгт барагн хурс ойролцоогоор улсын нийт нутгийн 1.7% -тай тэнцэх талбайг эзлэх бөгөөд дундаж өндөр уулсын ар хажуугаар 850-900 м- ээс 1600-1700 метрийн үнэмлэхүй өндөрт, Хангайн нурууны захын уулст 1800-2000 метрийн өндөрт шинэс, шинэс-хус, шинэс нарс, шинэс-нарс-хус, дан хус болон хус-ушиас холишон ургасан етгэн өвслөг бурхэвчтэй (бурхэц нь 50-80%) ойд тогтвортжино. Өвслөг ургамлын бүрхэвч сайн хөгжсөн, бүрэлдэхүүнд нь ойн болон нутат-ойн, нутат-хээрийн зүйл элбэг байна.

Олон жилийн цэвдэг байхгүй тохиолдолд улирлын хөлдөлт нипээн зузаан үеийг (2-2.5 м хүртэл) хамарч, хөлдөлт гэсэнт удаан хугацаагаар үргэлжилдэг. Хээрийн ажиглалттар 6-р сард 100-120 см, 7-р сард 130-150 см-ийн гүнд улирлын цэвдэг тохиолдох байв. Олон жилийн цэвдэг нутгархаг газраар голчлон тохиолдох бөгөөд улирлын гэсэлтийн гүн нь 1.5-2 метр хүрэх тул хөрс үүсвэрийн явцад нөлөө багатай. Бидний ажиглалтаар ойн нутгархаг хөрстэй газар 7-р сард 80-100 см-ын гүнд олон жилийн цэвдэгтэй байшаа. Биологийн идэвхтэй (+10°C-аас дээш ) температур ойн барагн хөрсөнд 35-40 см хүртэл гүн нэвчдэг (Ундрал, 1978) -ээс харахад дулааны хангамжаар сайн байна.

Хөрсний чийгийн гол эх үүсвэр болох хур борооны ус хөрсөнд гол төлев 50-60 см гүн, хур ихтэй зарим жил 100 см хүртэл гүн нэвчиж чийглэнэ. Үүнээс гадна улирлын ба олон жилийн цэвдэгийн гэсэнт, гадаргын урсацын нөлөөгөөр хөрсөнд нэмэгдэл чийг хуримтлах, хөрсний гүнд түр хугацаагаар хэт чийглэг иехцэл бүрдэх явдал заримдаа тохиолдоно.

Уулын ойн ширэгт барагн хөрсний гол онцлог бол ялзмаг хуримтлалын давхарга сайн хөгжсөн, заримдаа дээрээ бүдүүн ялзмагт, ширэгт давхаргатай, чандруужих болон төмрийн исэлжих үйл явцын илрэл байхгүй, ялзмагийн бодисын найрлагад гуминий хучил давамгайлах учраас тод хар, барагн саарал өнгийн ялзмагт давхаргатай, тэр нь бөөмерхөг үрлэнцэр бүтэцтэй, доороо нунтаг карбонатын хуримтлалтай байх нь элбэг, заримдаа глейрхэг шинж будэг илэрсэн супавтар хучилгэг урвалын орчинтой, шингээгдсэн сууриудаар бүрэн хангагдсан байна.

### Хөрсний нэр: Уулын ойн нутгархаг барагн хөрс

#### Хөрсний нэрийн код: 1215

Энэ хэвшинжийн хөрс нь барагн хөрс хавь ойрын өндөршег газраас ирэх гадаргын урсацаар нэмэгдэл чийг авах боломжтой иехцэлд үүсэж бий болно. Энэ хөрсний ялзмаг хуримтлалын давхаргын дээд хэсэгт нь ширэгжилтийн шинж тэмдэг тод илэрч үе давхаргууд нь: O-Ad-A-AB-B (BC)-C гэсэн бүтэцтэй байна. Ойн дэвсгэр хучаасны (O) зузаан 2-5 см (дунджаар 3.5 см), хүрэвтэр барагн саарал өнгөтэй, сэвсгэр тогтоцтой, Ad давхаргын зузаан 5-10 см, барагн саарал буюу хар өнгөтэй, бөөмерхөг-үрлэнцэр бүтэцтэй, ялзмаг хуримтлалын (A) давхаргын зузаан 15-35 см (дунджаар 25 см) байна.

AB давхарга нь заримдаа будэг бор саарал өнгөтэй, заримдаа ялзмагийн бааран саарал өнгө хошуурч орж ирсэн, бааран өнгийн долгионтсон цүлхэнгүүд үүссэн, ялзмаг дээрээсээ нэвчиж халтартсан байх ба зузаан нь 7-40 см (дунджаар 26 см) хүрнэ. А ба AB давхарга нь нийлдээ зэгэлдүү саарал, төмрөн саарал өнгө түяатай болж гадаргаасаа үе үе ус чийгээр ханаж глейжилтийн шинж будэг (A , AB) илрэх явдал хааяа тохиолдоно. В давхарга нь будэг бор өнгөтэй, заримдаа дээрээсээ ялзмагийн бодис нэвчиж халтартсан байдлытай, зузаан нь дунджаар 24 см (хамгийн нимгэн нь 11, хамгийн зузаан нь 56 см). Доошооноо аажмаар бор шаргал өнгөтэй BC давхаргад шилжинэ. Заримдаа энэ давхарга ч бас ялзмагийн нэвчилгээс болж халтартсан байна.

Ялзмагийн агууламж Ad давхаргад 12-15% хурдэг нь будуун ялзмагийн зүйл бага зэрэг байдгийг харуулж буй хэрэг. А давхаргад 7-8%, AB давхаргад 2-4% , в давхаргад 1-2 % орчим ялзмагтай. Ялзмагийн бодис доошоо гүн нэвчиж заримдаа 100 см гунд 1% ялзмагтай байх ч бий. Нуурстөрөгч, азотын (C:N) харьцаа 13-17 байгаа нь органик үлдэгдлийн ялзмагтлын эрчээр түрүүчийн хоёр дэд хэвшинжийн хөрснөөс арай сул гэдгийг илтгэж байна. Энэ нь тухайн хөрсөнд чийгийн хангамж илүү, харин дулаан бага зэрэг дутагдсантай холбоотой бизээ. Ялзмагийн бодисын бүрэлдэхүүнд гуминий хүчин эрс давамгайж ( Сгх : Сфх = 1.3-1.9 ) ялзмаг нь тогтвортой фульват-гуматын шинжтэй байна. Хөрсний бух үе давхарга сувалтар хүчилэг орчинтой , заримдаа гүн рүүгээ хүчилэгийн үзүүлэлт нэмэгддэг. Шингээгдсэн сууриудын нийлбэр ялзмаг хуримтлалын (Ad, A) давхаргад 100 гр хөрсөнд 15-16 мг - экв хүрнэ. Гидролит хүчилшилийн үзүүлэлт бага. Энэ хөрс сууришлаг элементээр бүрэн хангагдсан байна. Хеделгэент төмрийн агууламж хөрсний дээд хэсэгт арай нэмэгдэх хандлагатай боловч морфологийн хувьд томрийн ислийн хуримтлалын шинж тэмдэг ул ажиглагдана. Ширхэгийн бүрэлдэхүүний хувьд дунд ба хонгөн шавранцар хөрс зонхишино. Энэ хөрсөнд хур борооны ус 40-50 см гүн нэвчих бөгөөд мен гадаргын урсацаар нэмэгдэл чийг авах учраас дээд хэсэг нь зуны турш чийгтэй, ялзмагийн бодис доошоо нэвчиж халтартахаас гадна чийг ихтэй үед зэгэлдүү саарал , төмрөн саарал туха тодорч хөрсний дээд давхаргад (Ag , ABg) данд глейрхэг шинж илрэх нь цөөнгүй .

**Хөрсний нэр:** Данд глейрхэг хар широон хөрс

**Хөрсний иэришийн код:** 2105

Энэ хэвшинжийн хөрс нь хөрс тадаргын урсацаар шлуудэл чийт хуримтлах боломжтой уулын бэл хормойд ойр харыцангуй хотос хонхордуу газраар байрлах бөгөөд энэ хөрсний чийгжилтэд улирлын цэвдэг багагүй үүрэгтэй. Хавар, зуны эхэн үед улирлын цэвдгийн гэсэлгээс үүссэн ус чийт хөрсөнд түр хугацаагаар хуримталах хөрсний профилийн доод хэсэгт хэсэг зуур шлуудэл чийгтэй орчин бий болдог байна. 7-р сарын сүүлч ба 8-р сард цэвдгийн гэсэлгийн гүн тухайн жилийн цаг уурын нөхцөл, ул хөрсний шинж чанараас хамаар 170-аас 250 см хүртэл хэлбэлзэнэ. Энэ хөрсөн дээр нутгат-хээрийн ба хээржүү нутын ургамалши зонхилах бурхэц нь голдуу 80-90% байна. Ялзмаг хуримтлалын давхарга (A) нь гүн бааран саарал буюу бараг тас хар өнгөтэй, үрлэнцэр-бөөмөрхөг бутгэцтэй, доод давхаргатаа аажим шилжиж заримдаа доошоо хэл маягтай хошуурч орсон байна. Энэ давхаргын дээд өнгөн (0-5см, 0-10см) хэсэг сайтар ширэгжсэн байх ба A давхаргын зузаан нь дунджаар 32 см (хамгийн бага 16-18 см, хамгийн их нь 45-50 см ) байна. Ялзмагийн доод ( AB ) давхарга нь сааралдуу түяатай бааран бор, халтар саарал, зэгэлдүү саарал өнгөтэй, дээрээс хошуурч орж ирсэн ялзмагийн өнгөр, толбуудтай байх нь элбэг, зузаан нь дунджаар 19 см ( хамгийн нимгэн нь 10 см , хамгийн зузаан нь 30 см ) хүрнэ. Ялзмагт (A+AB) үеийн нийт зузаан 40-60 см хүрэх бөгөөд давсны хүчилд ихэвчлэн эдгээр давхаргын доороос, хааяа A давхаргаас эхэлж бургина. Заримдаа хөрсний бух үе давхарга угаадж карбонатын хуримтлалгүй байх ч бий. Хөрсний доод

карбонатын хуримтлалын давхаргуудад ялзмагийн халтартсан өнгөр, зэгэлдүү саарал туха, түүнчлэн зосорхог шар, зэгэл хөхөвтөр өнгийн жижиг бидэр толбууд үзэгдэж глейжилтийн шинж тэмдэг будэг илэрсэн (BCa,g;BCCa,g; CCa,g ) байх нь цөөнингүй. Мөн удаан үргэлжлэх улирлын цэвдгийн налөөгөөр херсний доод давхаргад үелсэн хайрсаархуу бүтэц үүссэн нь зарим тохиолдолд тол харагдана. Нутгархаг харшороон херс ялзмагийн бодисоор баялаг, А давхаргын дээд (0-10 см) хэсэгт 8-16%, мөн давхаргын доод (20-30 см) хэсэгт 4-8% ялзмагтай байна.

**Хөрсний нэр:** Уулын хархүрэн хөрс

**Хөрсний нэршилийн код:** 1501

Энэ хэвшинжийн хөрс нь нунтаг карбонатын хэвийн хуримтлалтай, A-B-BCCa-CCa гэсэн үе давхаргуудтай. Бараан хүрэн өнгөтэй ялзмаг хуримтлалын (A) давхарга нь 3.5-5% ялзмагтай, зузан нь дундажар 16 см (хамгийн бага нь 8 см, хамгийн их нь 25 см). В давхарга нь 2-3% ялзмагтай, метаморф шинж тод илэрсэн нь цөөн, зузаанаар 14 см (хамгийн бага нь 7 см, хамгийн их нь 22 см). Энэ давхаргад карбонатын хуримтлал байхгүй байна. Хөрсний гадаргаас эхлэн сайр чулуу ихтэй. Гол төлөв хагас метрийн гүнд суурь чулуулгийн элпови-деловийн хурдас оршино. Карбонатын хуримтлалын давхарга нь нунтаг карбонатын нэвчмэл цайвар толбуудтай, CO<sub>2</sub>-ын хэмжээ ихэнхдээ 3-7% хүрнэ. Уулын хархүрэн ба карбонатгүй хүрэншороон хөрс байгалийн үржил шимээр сайн, өвслөг ургамлын бүрхэц 50-70% хүрнэ. Эдгээр хөрсний дээд талын 0-20 см үед ялзмагийн нөөц 70-90 т/га, нийт азотын хэмжээ 6-7 т/га орчим байна. Ийм хөрстэй газрыг жилийн туриш бэлчээрт ашиглахаас гадна зарим нөхцөлд хадлан авч болно.

**Хөрсний нэр:** Уулын хүрэн хөрс

**Хөрсний нэршилийн код:** 1502

Энэ хэвшинжийн хөрс нь уулын хархүрэн хөрстэй харьцуулбал ялзмагийн агууламж bagatay, ялзмаг хуримтлалын үе давхарга нь нимгэн, өнгөөр мэдэгдэхүйц гэгээтэй, карбонатын давхарга нийзэн дээр байдлаараа ялгаатай. Үе давхаргууд нь A-B-BCCa-CCa гэсэн бүтэцтэй. Тод хүрэн өнгөтэй ялзмаг хуримтлалын давхарга нь дундажаар 14 см, 2-3% ялзмагтай. Ширхэгийн бүрэлдэхүүнээрээ хөнгөн шавранцар, элсэнцэр хөрс зонхишино. Карбонатын хуримтлалын давхаргуудад саармаг буву түүнтэй ойролцоо, доод давхаргуудад, шүлтэг шинжтэй. Уулын хүрэн хөрс байгалийн үржил шимээрээ хангалитай, дээд талын 0-20 см үе дэх ялзмагийн бодисын нөөц 50-70 т/га, бүх азотын хэмжээ 5-6 т/га орчим байна. Энэ хөрсөн дээрх өвслөг ургамлын бүрхэц 30-50% хүрнэ. Ийм хөрстэй бэлчээрийг жилийн дөрвөн улираад сэлгэж ашиглах боломжтой.

**Хөрсний нэр:** Алловийн нутын хөрс

**Хөрсний нэршилийн код:** 3206

Энэ хэвшинжийн хөрс нь газрын доорх ус болон голын үерийн усаар үе үе тэжээгддэг төв татмын чийглэг нөхцөлд бүрэлдэж бий болох бөгөөд түүний чийгжилтэд цэвдэгийн гээлтээс үүсэх ус чийг зохих хэмжээгээр налөөлне. 7-р сарын сүүлчээр 130-150 см гүнд цэвдэгтэй байх явдал цөөнгүй ажиглагдана. Газрын доорх ус ихэнхдээ 90-160 см гүнд орших бөгөөд түүнээс доош байх ч бай. Хөрсний температурын горимыг судалсан (Убугунов, Убугунова, 1998) дунгзэс үзэхэд +5°C-ын температур тухайн хөрсөнд 5-р сараас 10-р сар хүртэл, +10°C-ын температур 6-р сараас 9-р сар хүртэл, +15°C буюу түүнээс дээш температур 7-8-р сард ажиглагдах бөгөөд +5°C-ын температур 70-80 см, +10°C температур 50-60 см гүнд нэвчдэж байна. 20 см гүн дэх биологийн идэвхтэй (+10°C) температурын нийлбэр 400-550°C хүрнэ.

Хавар газар гэсэх болон шар усны үсрэйн үед нутын хөрс хамгийн их чийгтэй болох бөгөөд энэ нь 6-р сарын дунд хүрэл үрэлжлийз. Түүнээс хойш хур борооны усаар голчлон тэжээгдэхийн хамт хөрсний доод хэсэг гүний усаар чийглэгдэнэ.

Ургамалын хувьд алаг өвс, утгэн, улаан толгой бүхий нутын бүлгэмдэл зонхилж 90-100% бүрхэц үүсгэнэ. Газар дээрх ургамлын фитомасс 41-47 ц/га, газрын доорх фитомасс 271-359 ц/га, хөрсний гадарга дээр унаж хагдарсан өвсний үлдэгдэл 2-13 ц/га хүрэх бөгөөд энэ бүрдүүг оршицуулад фитомассын нийт хэмжээ 331-399 ц/га болдог байна.

Энэ хөрсөнд чийг, дулааны хангамж тэгш хүрэлцээтэй учраас ургамлын үлдэгдэл задарч ялзмагжих үйл явц эрчимтэй явагдаж нарийн ялзмагийн хуримтлал тушгтай давамгайлах төлөвлөгөөнийг бий болгоно.


Морфологийн хувьд сайтар хөгжсөн ширэгт (Ad) давхарга, ялзмагийн хуримтлал (A) давхарга, глийжилтийн шинж тэмдэг заримдаа тод, заримдаа будэг илэрсэн (AB, Abg, B, Bg, BC, BCg) давхаргууд тодорхой ялгарч харагдахаас гадна аллюний наанги элсэн хурдасны судал үеүд, дарагдмал хөрсний үс байнга ажиглагдана.

Аллюний нутын хөрс байгалийн үрэжил шимээр онд, шим тэжээлийн бодис болон ялзмагийн неөц арвинтай байна. 0-20 см үе дэх ялзмагийн неөц 144-241 т/га, бүх азотын неөц 10-15 т/га, фосфорын неөц 3.3-4.4 т/га, калийн неөц 40-49 т/га хүрдэг.

Эх сурвалж: Монгол орны хөрс Доржгатов Д., УБ 2003

#### 9.2.1. Судалгааны үр дүн

Тус замын трассын дагуу нийт 6 цэгт дээж авч хээрийн бичиглэл хийв. Хөрсний хими, физик шинж чанар болон хөрсөнд агуулагдах зарим хүнд металлын агууламжийг тодорхойлуулах зорилгоор дээжүүдийг “Трийн лаб” ХХК-ийн Хөрс судалын лабораторид шинжилгээний үр дүн болон хээрийн бичиглэл зэрэгт тулгуурлан хөрсний хими физик шинж чанар, онцлог зэргийг бичив.



Зураг 43. Хөрсний дээж авсан цэгүүдийн байршил

**Хүснэгт 27. Агаарын чанарын хэмжилт хийсэн цэгүүдийн газарзүйн солбицол**

Дээжний нэр	Хэмжилт хийсэн байрлал	Хөрсний дээж авсан цэгийн солбицол	Хөрсний хэвшинж
Дээж-1	Хэнтий, Өмнөдэлгэр сумын төв, замын трассын эхлэл	109°48'59.56"	47°53'31.63"
Дээж-2	Хэнтий, Өмнөдэлгэр сум, трассын 20 дахь км-т	109°50'16.07"	48°02'22.36"
Дээж-3	Хэнтий, Өмнөдэлгэр сум, замын трассын 50 дахь км-т	110°03'22.09"	48°13'28.72"
Дээж-4	Хэнтий, Багширээт сум, замын трассын 70 дахь км-т	110°17'32.55"	48°22'28.58"
Дээж-5	Хэнтий, Биндэр сум, замын трассын 97 дахь км-т	110°32'04.01"	48°32'45.09"
Дээж-6	Хэнтий, Биндэр сумын төв, замын трассын 115 дахь км-т	110°36'05.97"	48°36'54.79"



Зураг 44. Хөрсний 1-р зүсэлтийн гадаргын зураг, цэгийн байршил



Зураг 45. Хөрсний 2-р зүсэлтийн гадаргын зураг, цэгийн байршил



Зураг 46. Хөрсний 3-р зүсэлтийн гадаргын зураг, цэгийн байршил



Зураг 47. Хөрсний 4-р зүсэлтийн гадзаргын зураг, цэгийн байршил



Зураг 48. Хөрсний 5-р зүсэлтийн гадзаргын зураг, цэгийн байршил



Зураг 49. Хөрсний 6-р зүсэлтийн гадзаргын зураг, цэгийн байршил

Лабораторийн шинжилгээний дүн:

Хүснэгт 28. Хөрсний үржил шимт чанар

Хөрсний хувиниж	Дээжийн иэр	рНН <sub>2</sub> O (1:2.5)	CaCO <sub>2</sub> %	Язваг %	EC <sub>2,5</sub> dS/m	Давс, %	Шимт тэжээлийн элементүүд, мг/100гр		Шингээгдсэн сууриуд, мг-экв/100гр		
							P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O	Ca+Mg	Ca	Mg
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
Уулын хархурэн	Дээж-2	7,45	0,00	5,95	0,036	0,02	4,8	23	38,0	36,2	1,8
Алтанзийн нутгын	Дээж-3	7,80	0,00	6,01	0,034	0,02	4,6	23	30,1	27,8	2,3
Уулын хурэн	Дээж-4	8,15	3,29	1,28	0,090	0,04	1,2	15	17,1	13,1	4,0
Уулын ойн шаррогт бараан	Дээж-5	8,21	0,00	2,05	0,042	0,02	2,2	20	16,2	13,0	3,2

**Хөрсний урвалын орчин (рН).** Энэ үзүүлэлт нь хөрсний хүчилгэг болон шүлглэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний рН-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 5.6-6.0 бол дунд зэрэг хүчилгэг, 6.1-6.5 сул хүчилгэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлглэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлглэг, 8.5-9.0 хүчтэй шүлглэг гэж үздэг. Ерөнхийдөө хөрсний урвалын орчин сул хүчилгээс сул шүлглэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад тохиromжтой гэж үздэг. Судалгааны үр дунгээс (хүснэгт 28) харахад уулын ойн ширэгт бараан, уулын хархүрэн болон аллювийн нутын хөрсний рН-ийн утга нь 7.45-8.21 урвалын орчинтой буюу ургамал ургахад тохиromжтой хөрс байна.

**Хөрсний карбонат.** Хөрсний карбонат гэдэг нь нүүрстөрөгчийн гуравч исэлтэй ( $\text{CO}_3$ )-тэй нэгдсэн газрын металлуудын (Ca, Mg) давс юм. Карбонатын тархалт, хэмжээ нь хөрсний үржил шим, элэгээд тэсвэртэй байдал, боломжит чийгийн багтаамжид нөлөөлдөг. Хөрсийг карбонатын агууламжаар нь 0% карбонатжаагүй, 0-2% сул карбонатжсан, 2-10% дунд зэрэг карбонатжсан, 10-25% хүчтэй карбонатжсан, >25% маш хүчтэй карбонатжсан гэж үзэлдэг. Хөрсний карбонатын агууламж дунд зэрэг буюу <10% байхад тохиromжтой гэж үзинэ. Судалгааны үр дунгээс (хүснэгт 28) харахад нийт дээж авсан цэгүүдэд хөрсний карбонат 0% буюу карбонатжаагүй байна. Өөрөөр хэлбэл энэ талбайд тархсан уулын ойн ширэгт бараан, уулын хархүрэн болон аллювийн нутын хөрс нь чийг барих чадвар маш муу, элэгдэл эвдэрэлд тэсвэргүй шинж чанартай байна. Дээж-4 буюу Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг, замын трассын 70 дахь км-т Булангийн нуурын ойролцоо авсан уулын хархүрэн хувьд 3.96% буюу дунд зэрэг карбонатжсан хөрс байна.

**Хөрсний ялзмаг буюу органик карбон (C).** Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задарлаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялзмагийн бодисын гол үүрэг ач холбогдол нь хөрсний физик нөхцөлийг сайжруулдаг, чийгийн багтаамжыг нэмэгдүүлдэг, хамгийн сайн бүтэц үүсэхэд нөлөөлдөг, усанд уусамтгай үржил шимийн бодисуудыг тогтоон барих, хөрсөн дэх биологи ба микробиологийн иджэвхийг сайжруулж ургамлын үндэсний хөгжилтийг дэмждэг, хөрсөн дотор явагдах химийн урвалуудад буффер (зохицуулагч)-ийн үүрэг гүйцэтгэдэг, хөрсөн дэх организмын хүнс болон энергийн эх үүсвэр болдог, хөрсний агаар солилцоог сайжруулдаг зэрэг олон талын ач холбогдолтой байдаг. Хөрсийг ялзмагийн агууламжаар нь <1% маш бага, 1-2% бага, 2-5% дунд зэрэг, >5% их ялзмагтай гэж үзэлдэг. Судалгааны үр дунгээс (хүснэгт 28) харахад уулын хархүрэн хөрсний 0-20 см дэх ялзмагийн агууламж дунджаар 1.28-5.95% буюу багас их агууламжтай хөрсний төрөнд орж байгаа нь нэг хэвшинийн хөрс хэдий ч дээж авсан байршил, хөрсний элэгдэл, эвдрэлийн хэмжээ зэрэг хүчин зүйлийн нөлөө байна. Уулын ойн ширэгт бараан хөрсний 0-20 см-т ялзмагийн агууламж 2.05% буюу дунд зэрэг байгаа бол, аллювийн нутын хөрсний ялзмагийн агууламж 6.01% буюу их агууламжтай байна.

**Хөрсний цахилгаан дамжуулалт (EC).** Хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хайлбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Хөрсөн дэх илүүдэл давс нь хөрс-усны тэнцвэрт байдалд нөлөөлж ургамлын өсөлтийг сааруулдаг. Мөн хөрсний EC-ийн үр дунд тулгуурлан хөрсний давсжилтгэг хянах, давсжсан хөрсийг сайжруулах зэрэг ажлыг хийдэг. Хөрсийг EC-ээр нь 0.0-0.26 dS/m сул давсархаг, 0.26-0.77 dS/m дунд зэрэг давсархаг, 0.77-1.78 dS/m их давсархаг, 1.78-3.55 dS/m маш их давсархаг, >3.55 dS/m хэт их давсархаг гэж үзэлдэг. Судалгааны үр дунгээс

**харахад (хүснэгт 28) уулын ойн ширэгт бараан, уулын хархурэн болон аллювийн нутын хөрсний 0-20 см-т ЕС-ийн утгын хэлбэлзэл 0.034-0,090 dS/m буюу сул давсархаг байна.**

**Хөрсний хөдөлгөөнт фосфор, кали ( $P_2O_5$ ,  $K_2O$ ).** Хөрсний азот, фосфор, кали (N,P,K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь я дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Хөрсон дэх фосфорын пентоксид ( $P_2O_5$ ) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорын пентоксидыг агууламжаар нь <2mg/100g бол бага хангамжтай, 2-4mg/100g бол сайн хангамжтай гэж үзэлддэг. Хөрсөн дэх калийн исэл ( $K_2O$ ) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийн исэл ( $K_2O$ )-ийг агууламжаар нь <10 mg/100g бол бага хангамжтай, 10-20 mg/100g бол сайн хангамжтай гэж үзэлддэг. Судалгааны үр дүнгээс (хүснэгт 28) харахад  $P_2O_5$ -ын утгын хэлбэлзэл 1.2-4.8mg/100g -ийн хооронд, дунджаар 3.2 mg/100g буюу сайн хангамжтай байна. Хөдөлгөөнт калийн хувьд утгын хэлбэлзэл нь 15-30 mg/100g -ийн хооронд буюу дунджаар 19.25 mg/100g буюу маш сайн хангамжтай байна.

**Хүснэгт 29. Хөрсний механик шинж чанар**

Хөрсн	Дээжийн нэр	Гүц, см	Механик бүрэлдэхүүн, % (мм-ээр)						
			1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Уулын хархурэн	Дээж-1	0-20	9,7	21,8	48,8	3,0	12,4	4,4	19,8
Уулын хархурэн	Дээж-2		35,8	40,5	1,3	9,0	5,4	8,0	22,5
Аллювийн нутын	Дээж-3		47,6	24,4	1,3	18,5	4,3	3,8	26,7
Уулын хүрэн	Дээж-4		47,6	24,4	5,3	14,5	4,3	3,8	22,7
Уулын ойн ширэгт бараан	Дээж-5		25,2	50,0	3,7	12,0	4,6	4,4	21,0
Уулын хархурэн	Дээж-6		29,7	47,7	3,1	10,7	8,6	0,2	19,5

**Хөрсний механик (ширхэгийн) бүрэлдэхүүн.** Хөрсний механик бүрэлдэхүүн нь 1мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракци нь зонхиц байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний иршил хамаардаг. Элсийн ширхэгийн хэмжээ 1-0.05мм, тоосных 0.05-0.002мм, шаварных <0.002мм тус тус байдаг. Хөрсний механик бүрэлдэхүүн нь чийг багтаамж, нэвчилтийн эрчим, органик бус шим тэжээлийн бодисын хангамж, нягтшил зэрэг олон үзүүлэлтэнд маш илөөстэй байдаг. Элсэнцэр болон элсэн механик бүрэлдэхүүнтэй хөрс нь ус чийг тогтоон барих чадвар муутай, ургамалд хялбар ашиглагдах үржил шинмээр ядмаг байдаг. Судалгааны үр дүнгээс (хүснэгт 29) харахад уулын ойн ширэгт бараан, уулын хархурэн болон аллювийн нутын хөрсний физик шаврын агууламж дунджаар 19.5-26.5% буюу элсэнцэр болон хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна. Дээж-1 болон Дээж-6-үүдийг суурин газруудаас авсан буюу Өмнөдэлгэр, Бийнээр сумдын төвөөс авсан дээжнүүдийн хувьд физик шаврын агууламж 19.5-19.8% буюу элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрс байна. Бусад замын трассын дагуу буюу эзгүй хээр авсан дээжнүүдийн хувьд хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

### Хүснэгт 30. Хөрсөн дэх зарим хүнд металын агууламж

Зүсэлтийн дугаар	Гүн, см	Хүнд металын агууламж, мг/кг					
		Ni	Cd	Pb	Zn	Cr	Cu
Дээж-1	0-20	34.5	-	1.4	15.8	81.4	7.9
Дээж-6		15.0	-	0.7	9.4	14.8	20.1
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 5850:2019/		60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0

Хөрс судилалын лабораторийн задлан шинжилгээний дүнгээр дээрх б өрлийн элементүүд “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдол үүсээгүй байгааг илтгэнэ.

“Трийн лаб” ХХК-ийн Хөрсний задлан шинжилгээний хариуг хавсаргав.

Төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө хийсэн энэхүү судалгаанд төслийн талбай нь ямар нэгэн хүнд элемент, шатах тослох материал, нян бактерд бохирдоогүй буюу цэвэр, хөрсний урвалын орчин өнгөн үе давхарга нь хүчтэй шүүгчэг, зарим хэсэгтээ давсжилтүй, хөдөлгөөнт фосфор, хөдөлгөөнт кали хангамжаар маш сайн, хөрсний үргжил шимиийн түвшин маш сайн байна. Зам барилгын ажлыг эхлэх үе шат болон замын байгууламж дараа тээвэрийн хэрэгслийн тоо ихсэх үед хөрсний унаган төрх алдагдах, хүнд металлаар бохирдох зэрэг техноген сөрөг нелоөлөл ихсэж болзошгүй.

#### 9.3. Хөрсний эзлэгдэл зөвдрэл

Төлөвлөж буй замын трассын дагуу олон салсаа ширеэний талбай нь ямар нэгэн хүнд элемент, шатах тослох материал, нян бактерд бохирдоогүй буюу цэвэр, хөрсний урвалын ойн, уулын хээрийн, тал хөндийн болон голын татмын хөрсний бүлэгт хамаарах уулын ойн нутгархаг, уулын ойн ширэгт бараан хөрс, уулыг хархурэн, уулын хүрэн, дадд глейрхэг хар ширеэний талбай нутгын хөрс тархсан байна. Тус хөрсний хэвшинээс бүрээс төлөөлүүдээ 6 цент дээж авсан бөгөөд хөрсний лабораторийн задлан шинжилгээний үр дүнг эдгээрийн хими, физик шинж чанартай харьцуулахад хэвийн буюу шинж чанар өөрчлөгдөөгүй байна.








Зураг 50. Замын трассын дагуух орчны харагдар байдал

## БҮЛЭГ 10. УРГАМЛАН НӨМРӨГ

### 10.1. Ургамлан нөмрэгийн хэв шинж, зүйлийн бурдэл, ангиал

Монгол орны ургамал газарзүйн мужлал хийх оролдлогыг В.Л.Комаров /1908/, Н.В. Павлов /1929/ нар, төв Азийн мужлалтыг Е.М.Лавраско /1940, 1941/ нар тус тус хийж байжээ. Мөн А.А.Юнатов 1949 онд хийсэн бөгөөд тэрээр Монгол орныг ботаник газарзүйн З мух, 7 прокинц, 23 тойрог, районд хуваасан байна. В.И.Грубов (1955) Төв Азийн ургамал газарзүйн мужлалыг анх тостоож, түүнд Монголын ургамлын аймгийн Төв Азийн ургамлын аймагт эзлэх байр суурийг тодруулсан бөгөөд тэрээр сүүлд 1982 онд Монгол орны ургамал-газарзүйн мужлалтыг 16 тойргуудад хуваасан нь өнөөг хүртэл мөрдөгдөж байна. Төсөл хэрэгжих нутаг нь ургамал газарзүйн тойргоор Монгол дагуурын тойрот хамарагддаг. /В.И.Грубов, 1963/.




Зураг 51. Монгол орны ургамал-газарзүйн мужлал (Грубов)

#### Монгол орны ургамал-газарзүйн мужлал (Грубов):

1. Хөвсгелийн уулын тайгын тойрог
2. Хэнтийн уулын тайгын тойрог
3. Хангайн уулын тайгын тойрог
4. Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрог
5. Хангайн уулын нутаг хээрийн тойрог
6. Ховдын уулын цэлжсэн нутаг хээрийн тойрог
7. Монгол Алтайн уулын хээрийн тойрог
8. Дундад Халхын хуурай хээрийн тойрог
9. Дорнод Монголын хээрийн тойрог
10. Их нууруудын хотторын цэлөрхөг хээрийн тойрог
11. Олон нуурын хөндийн цэлөрхөг хээрийн тойрог
12. Дорнод говийн цэлөрхөг хээрийн тойрог
13. Говь Алтайн уулын цэлөрхөг хээрийн тойрог
14. Зүүнгарын говийн (цэлийн) тойрог
15. Алтайн өвөр говийн (цэлийн) тойрог
16. Алашаа говийн (цэлийн) тойрог

Төсөл хэрэгжих талбай нь ургамал-газарзүйн мужлалаар Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойротг хамаарна. Тус тойротг Хангайн уулархаг бүс нутгаас ба баруун хойноос зүүн урагш чиглэсэн, уртаараа 600 орчим км, хойш Хөвсгел нуур хүртэлх өргөн уудам нутгийг хамаарна. Энд Алтай Соёны өндөр уулын ургамлаас гадна Сибирийн тайгын элементүүд, нөгөө талаас Монголын хээрийн төлөөлөгчид зонхилох ба өөрийн унаган ургамал болон түгээмэл тархац бүхий зүйлүүдэй юм. Энэ тойротг нийт 1547 зүйл ургадаг ба зөвхөн энд тохиоцдох 45 зүйл ургамал тэмдэглэгдэжэ. Үүнээс: Юлдэн шүүдрийн ойм, Юнатовын Шивэлз, Павловын Сорвоо, Их бушилз, Бага улалж, Регелийн Аллаглгүйцэцэг, Цэх Ахилцагаан, Дайрт Унагансүүл, Алтайн Нил, Түвэд ланцуй, Элдэв үст Цийлэг, Алтайн Иршимбэ, Таван судалт Төмөрдээ, Нуцгэн шүхэрэгэнэ, Дашиу хажуут Хумиж, Шүдэрхэг Гичгэнэ, Төгрөг навчигт Хус, Маалинга навчигт Хасалгана зэрэг болно.



Зураг 52. Төсөл хэрэгжих замын трассын дагуу тархсан ургамлын анги, Монгол орчны бэлчээр ба хадлангийн ангилалаар

#### 10.1.1. Тесэл хэрэгжих орчны ургамлан номрэг, түүний онцлог

Тесэл хэрэгжих талбайд хийсэн агаарын чанарын хэмжилтийг “Мон Газар Экологи” ХХК-ийн мэргэжилтнүүд 2021 оны 11-р сарын 20 өдөр хийж гүйцэтгэв. Хээрийн судалгааны үеэр агаарын температур  $-11^{\circ}\text{C}$ - $(-16^{\circ}\text{C})$  хүйтэн, салхи 5-7 м/с ны хурдтай, цас бурхуул тогтсон байсан тул ургамлын бичиглэл үйлдээгүй болно. Энэхүү бүлэгт тесэл хэрэгжих талбай орчмын бусад судлаачдын ургамлын талов байдлын судалгааны тайлант авч үзэв.

Тесэл хэрэгжих талбай орчмын нутаг дэвсгэр нь ургамал газарзүйн мужлалтаар Евразийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн Дорнод азийн Эрээний нурууны тойрогт хамаарна. Уг тесэл хэрэгжих орчинд Ботууль-алаг өвст, түмэн тана-ботуульт, хус болон улиангаран төглийн зүр өвс-алаг өвс-ботуульт ургамлын бүлгэмдэл зонхилон тархжээ.

Ботууль-алаг өвст, түмэн тана-ботуульт, хус болон улиангаран төглийн зүр өвс-алаг өвс-ботуульт ургамлын бүлгэмдэл нь Монгол орны ойт хээр болон хээрийн бүсэд тархсан байдаг. Алаг өвс-Ботуульт бүлгэмдэл нь алаг өвс- жижиг үетэнт бэлчээрт хамрагдах бөгөөд ийм бүлгэмдэл нь манай орны ойт хээр болон хээрийн бүсэд тархсан байдаг. Энэ бүлгэмдэл нь алаг өвст болон хялганат хээрийн малын бэлчээрт дунд юм уу их ашигласан үед үүснэ. Алаг өвс-ботуульт ургамлын бүлгэмдэлд алаг өвст нутын болон хээрийн бэлчээрт зонхилон ургадаг марал навчилт гичгэнэ, хэрчлээст бэвлэнцэр, алтайн согсоолж, фишерийн бэрцэцэг, завадскийн цагаалзай, шошлойрхог хошоонгор, эмийн сөд, шар өрөмтуул, эвэрт сэргэг, өргөн навчилт тайжийн жинс зэрэг алаг өвс ихсэж, зарим нь зонхилон ургадаг. Их ашиглагдсан нуга хээрийн бэлчээрийг амраахад алаг өвс-үетэн ихсэж байна. Энэ бүлгэмдэл ургамал нь манай оронд түүхийн урт хугацааны туршид уур амьсгалын дулаарах, хүйтрэх, хуурайших үйл явц ихсэх багасах зэргээр өөрчлөгддэж ирсэн болон олон жилийн турш малын бэлчээрэлтийн нэлэөгөөр алаг өвс-үетэнт хээр болж өөрчлөгдсөн байна. Иймээс манай орны малын бэлчээрт ашигладаг нутгуудад хялгана, ерхөг, даагансүүл, ботууль, хазааргана, биелэг, түнгэ зэрэг үетэн зонхилсон алаг өвс-үетэнт бэлчээр ихээхэн тархсан байна.

Алаг өвс-ботуульт бүлгэмдэлд саман ерхөг, дэрвээн хазааргана, том цэцэгт даагансүүл, дагуурын биелэг, агь, крыловийн хялгана зэрэг ургамлууд зонхилон ургана. Түүнчлэн коржинскийн улааж, дагуур хатны цэцэг, ширэг улааж, адамсын шарилж, ишгүй гичгэнэ, нангиад түнгэ, имт гичгэнэ, алтайн согсоолж, хос шүдэг, сонгино, хургай шарилж, байгаль хялгана, хялгасан дэвжэргэнэ, дэлхээ тогторгоно зэрэг ургамал тархсан байдаг. Бүлгэмдлийн нийт ургамлын дундаж өндөр нь 20-30 см орчим, нийт бүрхэц нь 55-70% орчим ба бүх ургац нь 30орчим га/ц байдаг байна. Эдгээр ургамлын бүлгэмдэл нь ихэвчлэн цайвар хүрэн хөрсөн дээр тогтвортодог байна.

Ойт хээр болон хээрийн бүсэд их ашиглагдсан бэлчээрийг удаан хугацаагаар амраах буюу ашиглажгүй байх үед ургамлын зүйлийн тоо, зонхилох ургамлын бүлгэмдэл үүсгэх үүрэг зэрэг нь өөрчлөгдхөхийн зэрэгцээ ургамал тус бүрийн тогтвортой байдал, тэсвэрлэх онцлог, өрсөлдөх чадвар зэрэг үзүүлэлтүүд өөрчлөгддөг байна.

Алаг өвс-ботуульт хээрийн бүлгэмдлийн нийт бүрхэц ургамлын 55 орчим хувь нь нас гүйцсэн ургамал байдаг ба үлдсэн нь цухуйц эсвэл бачир ургамал байдаг байна. Алаг өвс-ботуульт ургамлын бүлгэмдэлд зонхилон ургадаг зарим зүйлүүдийн талаар авч үзвэл: Крыловын хялгана: нягт дэгнүүлт олон наст үет ургамал бөгөөд цацагласан хэлбэрийн үндэсний системтэй. Дунд насын хялган 4-7 см голчтой дэгнүүл үүсгэдэг ба 32-54 см өндөр, 4-7 ширхэг үржлийн, 17-19 см өндөр, 35-60 ширхэг ургал найлзууртай байна. Крыловын хялгана нь хуурай хээрийн зонхилогч ургамал бөгөөд хүрэн хөрстэй газар ихэвчлэн ургадаг.

**Байгаль хялгана:** нягт дэгнүүлт олон наст үет ургамал бөгөөд цацагласан хэлбэрийн үндэсний системтэй. Дунд насын хялгана 6-18 см хүртэл голчтой дэгнүүл үүсгэдэг ба 60-90 см өндөр, 9-12 ширхэг үржлийн, 40-60 см өндөр, 60-70 ширхэг ургал найлзууртай. Байгалийн хялгана нь уулын хээр, нугархуу хээр, хээрийн зонхилогч бөгөөд нута, хээрийн янз бүрийн механик бүтэцтэй хүрэн хөрстэй газар ихэвлэн тархан ургадаг. Крыловын болон байгаль хялгана нь 8 сарын эхээр цэцэглэдэг буюу орой цэцэглэдэг үржлийн хэмтэй, үрээр үрждэг ургамал юм.

**Марал навчит гичгэнэ:** урт голносон үндэстэй олон наст ургамал бөгөөд 30-35 см өндөр, 3-4 ширхэг үржлийн, 8-15 см өндөр, 2-3 ширхэг ургал найлзууртай. Энэ ургамал зүр өвст, хялганат, алаг өвст хээрийн зонхилогч ургамал бөгөөд нута, хээр, уулын хээрийн хүрэн хөрстэй газар ихэвчлэн тархана. Орой цэцэглэдэг хөгжлийн хэмтэй, үрээрээ үрждэг ургамал.

**Агь:** зэллэсэн үндэслэг иштэй хагас сөөгөнцөр ургамал бөгөөд 20-30 см өндөр ургадаг, 20-30 ширхэг үржлийн, 4-7 см өндөр, 15-34 ширхэг ургал найлзууртай. Хэсэг хэсэг ургасан 8-14 см голчтой дэгнүүл үүсгэнэ. Орой цэцэглэдэг хөгжлийн хэмтэй.

**Саман ерхог:** сийрэг дэгнүүлт олон наст үет ургамал юм. Энэ ургамал нь 2-4 см голчтой дэгнүүл үүсгэдэг бөгөөд 20-50 см өндөр, 5-6 ширхэг үржлийн, 10-20 см өндөр, 2-4 ширхэг ургал найлзууртай байдаг. Орой цэцэглэдэг хөгжлийн хэмтэй ургамлын тоонд орно. Давсархаг хөрснөөс бусад хэвшинжийн хөрсөнд ургах боломжтой ургамал юм. Дагуур биелэг: цацагласан үндэсний системтэй, сийрэг дэгнүүлт, олон наст үет ургамал юм. Энэ ургамал нь 4-6 см голчтой сийрэгхэн дэгнүүл үүсгэн ургах ба 30-40 см өндөр, 50-90 ширхэг үржлийн найлзууртай. Өндөр уул, уулын хээр, нутын хээр, хээрийн ургамлын бүлгэмдэлд зонхиilon болон дэд зонхилогчийн үүрэг гүйцэтгэдэг. Дагуур биелэг нь янз бүрийн нөхцөл дэх хөрсөнд сайн ургаж чаддаг онцлогтой ба эрт цэцэглэдэг хөгжлийн хэмтэй.

**Том цэцэгт даагансүүл:** цацагласан үндэсний системтэй. Нягт дэгнүүлт олон наст, үет ургамал, 5-12 см хүртэл голчтой иштэд нягт дэгнүүл үүсгэдэг бөгөөд 25-41 см өндөр, 5-11 ширхэг үржлийн, 5-8 см өндөр, 17 ширхэг ургал найлзууртай. Энэ ургамал нь уулын хээр, нутын хээр, хээрийн ургамлын бүлгэмдлүүдэд зонхилогч, дэд зонхилогчийн үүрэг гүйцэтгэдэг. Хайргархаг болон хүрэн хөрстэй газраа тархах бөгөөд нэлээд эрт цэцэглэдэг үржлийн хэмтэй ургамал юм.

#### 10.1.2. Ургамлын зүйлийн бүлгэмдлийн олон янз байдал:

Зүүн бүсэд нийтдээ ургамлын 28 бүлгэмдэл (бүлгэмдэл)-д хамгааллын болон аюул дарамтын доорх шалгуураар үзэлгээ хийсэн.

- Бүлгэмдлийн нөөцийн үзэлгээ,
- экобус нутгийн хүрэн дэх тархацийн үзэлгээ
- хэт ашиглалтын үзэлгээ,
- амьдрах орчны доройглын үзэлгээ,
- УУЛ уурхайн нөлөөллийн үзэлгээ,
- дэд бүтцийн нөлөөллийн үзэлгээ,
- түймрийн нөлөөллийн үзэлгээ.

Зүүн бүсийн ургамлын 28 бүлгэмдлийн 3 (10.7%) нь умардын тайга, 5 (17.9%) нь уулын хээр, 8 (28.6%) нь сэруүн бүсийн шилтүүст ой, 6 (21.4%) нь сэруүн бүсийн хээрийн биомд багтана. Эдгээр бүлгэмдлийг монгол оронд тархсан байдалд үзэлгээ хийж үзэхэд 10 (35.7%) нь тодорхойгүй, 17 (60.7%) нь монгол орны нийт нутаг дэвсгэрийн 20 хүртэл хувьд, 1 (3.6%) нь 21-40%-д тархалттай байна. 28 бүлгэмдэлээс Хэнтий Дагуурын мужид 22 нь тохиондох ба 9 бүлгэмдэл нь (40.9%) нөөцийн үзэлгээ хийх боломжгүй, мэдээлэл хомс гэсэн ангиалд хамрагдаж байна. Харин 10 бүлгэмдэл нь (45.5%) 30 хүртэл хувь, 3

бүлгэмдэл нь (13.6%) 50-70% хүртэл хэмжэгээр ишоц нь сүүлийн арван жилд хомсдож байгаа болно. Хэнтий Дагуурын мужид 22 бүлгэмдэл нь тохиолдох бөгөөд үүнээс 8 бүлгэмдэл (36.4%) нь зах хязгаарын, 9 бүлгэмдэл (40.9%) нь тасархайтсан, 5 бүлгэмдэл (22.7%) нь хязгаарлагдмал тархалттай байна.

#### Онцгойлох ургамлын бүлгэмдэл

Нийтээ ургамлын 28 эвшигий (бүлгэмдэл) дээрх шашууруудаар үнэлж үзээд 15 бүлгэмднийг хамгаалах зайлшигүй шаардлагатай гэж үзүүлээ. Үүнд:


1. *Betula mandshurica* in silva betulina (*Betulo platyphylla* + *B.mandshurica*)
2. *Adonis mongolica* in montano-steppis graminoso-Variiherbosis
3. *Larix dohurico* in silva mixta *Pinus silvestris* + *Pinus krylovii* + *Betula mandshurica*
4. *Pteridium aquilinum* in silva betulina laxiuscula
5. *Allium nerinifolium* in pratis variiherboso-caricoso-graminosis
6. *Euphorbia pallasiana* in siccis steppis graminoso-variiherbosis
7. *Allium macrostemon* in variiherbosa association on land with basic stone
8. *Aconitum kusnezoffii* in pratis riparii graminoso-caricosis
9. *Scirpus Acorus calamus* in et phragmites association in zona litoralis
10. *Rosa xanthina* in declivitates stepposae lapidosae
11. *Caragana spinosa* in vaile fluminis
12. *Oxycoccus microcarpa*, *Vaccinium myrtillus* drosera anglica et *D.rofundifolia* in palidibus sphagnosis elatis
13. *Paonia lactiflora* in steppa pratensis variiherbosa - graminosa
14. *Scutellaria viscidula* in siccis steppis graminosa-Variiherbosis
15. *Brachanthemum mongolorum* in siccis steppis graminoso- variiherbosis

#### 10.2. Ой

Манай улсын ойн сангийн нийт талбай 18.3 сая.га, 140 гаруй зүйлийн мод, сеөгөөс буряанд бөгөөд 1.4 тэрбум шоомстр мөдны иөөцтэй юм. Үүнээс ойн талбай нь 16.7 сая.га, ойгоор бурхэгдсэн талбай нь 12.9 сая.га буюу нийт нутаг дэвсгэрийн 8.2 хувийг эзэлдэг. Сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд ойгоор бурхэгдсэн талбай түймэр, хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдэх, хууль бусаар их хэмжээний сод бөлтгэсэн зэргээс болж улсын хэмжэнд 1.4 сая.га-гаар хорогдсон тооцою гарсан байна. Монгол орны ой нь Төв Азийн эрэ тэс уур амьсталтай нөхцөлд зохицрон ургадаг учир байгалийн жамаар нөхөн сэргэх чадавхиар нэн хязгаарлагдмал, түймэр, хөнөөлт шавьж болон хүний түйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд хялбархан өртдөг уулын ой юм. Манай орны ой дэлхийн усны гурван том ай савын хагалбарыг дагаж ургасан бөгөөд гол, мөрний усны иөөцийг зохицуулан хамгаалах, цэвэршүүлэх, хөрсийг элögдэл эвдэрэлэх хамгаалах, уур амьсталыг зоодруулэх, хүчээндээний хийг шингээх, амьтан, ургамал, бичил бистний амьдрах тааламжтай орчныг бурдуулэх, мөнх цэвдгийг тогтоон барих зэрэг экологийн өндөр ач холбогдолтой. Эрдэмтэд Ой бол ус, ус бол ургац, ургац бол амьдрал гэсэн дүгтэлт гаргаж, ой модыг ногоон алтын хэмээн нэрлэдэг.

Монгол орны ой, мод нь хөрс, ургамалжилтын хэв шинж, уур амьсталын өвермөц онцлогтойгоор тархан ургадаг учраас өөр, хоорондоо ялгаатай таг, царам, уулын тайга, тайгархаг, тайгажуу, ойт хээрийн гэсэн өндөршил буслуур үүсгэдэг.

Төлөвлөж буй замын трасс нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Батширээт, Бинцэр сумдын нутгийг дайран өнгөрөх бөгөөд тус сумдын нутагт 884,831 та талбайг хамрах шинэс, нарс, хус, улиангар, хуш бухий ой 1.5-17 км зайд алслагдан байрлаж байна.



Зураг 53. Төлөвлөж буй замын трасс, түүний орчмын ойн зураг

Хүснэгт 31. Ойн төрөл, талбайн хэмжээ

№	Ойн нэр	Талбайн хэмжээ, га
1	Нарс	47,144
2	Хус, улиангар	23,740
3	Хуш	198,900
4	Шинэс	615,046

## БҮЛЭГ 11. АМЬТНЫ АЙМАГ

### 11.1. Төслийн талбай орчмын амьтны аймгийн онцлог

Төлөвлөгдөж буй замын трасс нь Монгол улсын байгалийн бүс, бүслүүрийн онцгойор ойт хээрийн болон хээрийн бүсэд багтдаг ба Засаг захиргааны хуваариар Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт сумдын нутаг дэвсгэрийг дайран өнгөрөн. Төслийн талбай болон түүний орчимд ой, хээрийн ан амьтад тархжээ. Зонхилогч хөхтөн амьтны бүлэг нь тарвага, үндсэн тэжээл нь ургамлын ногоон хэсэг, ичээлдэг бөгөөд идэвхитэй амьдардаг. Хээрийн хөхтөний булгэмдэл зонхилен. 360км<sup>2</sup> талбайд оногдох хөхтөний зүйлийн тоо 12-16 байна. Уийн цагаан оготно, монгол тарвага сийрэг тархсан.

Хэнтий аймгийн нутаг дэвсгэр нь газрын гадарын үндсэн хэв шинж, уур амьсгалын нөхцөлтэй уялдсан хөрс, ургамал, амьтны төрөл зүйлээр ялгаатай уулын тайга, уулын ойт хээрийн бүслүүр, хуурай хээр, целийн хээрийн бүсэд хуваагдаж ургамалгазарзүйн Хэнтий уулын тойрог, Монгол дагуурын ойт хээрийн тойрог, Дундад халхын хээрийн тойротг хамарагддаг нь амьтны аймгийн төрөл, зүйлээр баялаг байх нөхцлийг бүрдүүлсэн. Хэнтий аймагт сээр нуруутны төлөөлөл болох 376 зүйл, сээр нуруугүйтний төлөөлөл болох 400-аад зүйл нийт 730 гаруй зүйлийн амьтад амьтад амьдарч байгааг судлаачид тогтоогоод байна.

**Сээр нуруутны төлөөлөл:** Хөхтөн 5 баг 17 овог 70 зүйл тэмдэглэгдсэнээс шавьж идээлтэй 8 зүйл, сарысан далавчтан 6 зүйл, туулай хэлбэртэн 4 зүйл, мэрэгчтэн 28 зүйл, махан идээлтэй 17 зүйл, туруутан 7 зүйл, загас-7 баг 11 овог 32 зүйл, хоёр нутагтан -2 овог 3 зүйл, мөлхөгчид-2 баг 2 овог 5 зүйл, жигүүртэн -17 багийн 49 овгийн 158 төрлийн 322 зүйл байна.

**Сээр нуруугүйтний төлөөлөл болох / Онон голын сав газар/:** Шавьж-13 баг 109 овог 265 төрлийн 352 зүйл байна. Эдгээрээс ойн хортон шавьж 7 баг 34 овог 97 төрлийн 151 зүйл, зеелен бистэн-2 зүйл, алз хэлбэртэн-2 зүйл байна.

**Хэнтий аймгийн ховор амьтад:** Ховор амьтдыг хамгаалах асуудал нь нэг улс орны хувьд төдийгүй дэлхий нийтийн ач холбогдолтой юм. Хэнтий аймагт Монгол орон төдийгүй дэлхийд ховордож анхааралц өртсөн олон зүйл амьтад нийзэдгүй тархсан байдаг. **Үнд:**

Нэн ховор амьтад:

- хөхтөн 4 зүйл /голын халиу, азийн минж, шивэр хандгай, баданги хүдэр/,
- шувуу 5 зүйл /цагаан тогоруу, реликт цахтай, бор бүргэд, усны нөмрөг бүргэд, мөгийч загал/,
- загас 1 зүйл /хар мөрний хилэм/ буюу нийт 10 зүйл амьтан

Ховор амьтад:

- хөхтөн 4 зүйл /аргаль, халиун буга, ойн булга, хүрэн баавгай/,
- шувуу 12 зүйл /одой галуу, хонин тоодог, манхин галуу, байгалийн нугас, гээгт нугас, ойн шийхнуухэй, шар эзэгт хөмрөг, усны бух шувуу,
- хан бүргэд, азийн цууцал, хархираа тогоруу, цагаан сүүлт нөмрөг бүргэд/,
- загас 1 зүйл / тул/
- дугуй амьтан 1 зүйл /номхон далайн мөгор/
- шавьж 5 зүйл /бэр цэцгийн шумбуур, дамнуургын цэнхэр соно, аполлон, махиан дэвүүр, спорадикус үхэр хэдгэнэ/,
- хавч хэлбэртэн 1 зүйл /голын хавч/.

- залдажбистэн 2 зүйл /дагуурын сувдан хясаа, монгол танан хясаа/,
- хоёр нутагтан 1 зүйл /шивэр гүлмэр/ буюу ийт 27 зүйл амьтан байна.

**Монгол улсын “Улаан ном”-д:**

- хөхтөн 3 зүйл / голын халиу, шивэр хандгай, азийн минж/
- шувуу 12 зүйл / хар тогоруу, реликт цахтай, цэн тогоруу, хар өрөвтас, хээрийн галуу, усны цагаан сүүлт номрөг бүргэд, цагаан тогоруу, халбаган хошуут, гангар хун, хоншуу галуу, явлаг сар, хонин тоодог/
- хоёр нутагтан 1 зүйл / шивэр гүлмэр/

**CITES-ын I,II-р хавсралтанд**

- хөхтөн 3 зүйл / аргал хонь, мануул мий, саарал чоно/
- Зэрлэг амьтан хамгаалах Боннын конвенци
- хөхтөн 1 зүйл /цагаан зээр/

**Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо (IUCN)- ны хөхтөн амьтдын ховордолын зэргийг үзэлэх шалгуур:**

**Эмзэг ангилалд:**

- хөхтөн 3 зүйл /аргал хонь, баданга хүдэр, нохой зээх/

**Ховордож байгаа ангилалд:**

хөхтөн 3 зүйл / шилүүс мий, мануул мий, хэрэм/

**Монгол улсын “Улаан данс”-д:**

**Устаж болзошгүй ангилалд:**

- хөхтөн 6 зүйл / аргал хонь, цагаан зээр, монгол тарвага ,молцог хандгай, халиун буга, баданга хүдэр/

**Ховордож байгаа ангилалд:**

- хөхтөн 7 зүйл /зэрлэг гахай, шилүүс мий, мануул мий, шар үнэг, хярс мий, бараан хэрэм, саарал чоно / амьтад хамрагдаж байна.

**Хүснэгт 32. Төсөл хэрэгжих бус нутгийн онцлох статустай зүйлийн олон янз байдал**

№	Зүйлийн нэр	Шинжлэх ухааны нэр	IUCN Red List (2006) Global category	CITES I, II хавсралт	Монгол улсын Уллан ном, 1987, 1997	Монгол улсын Улаан ном 2013	Улаан данс (2006)	Жагсаалт, /ЗГ-ын 2012 оны 7 дугаар тогтоолын I-р	Амьтны тухай хууль
<b>1</b>	<b>Баданга хүдэр</b>	<b>Moschus moschiferus</b>	<b>ЭМ</b>	<b>II</b>	+	+	УБ	-	НХ
<b>2</b>	<b>Зэрлэг гахай</b>	<b>Sus scrofa</b>	<b>АӨ</b>	-	-	-	ХБ	-	-
<b>3</b>	<b>Бор гөрөөс</b>	<b>Capreolus pygargus</b>	<b>АӨ</b>	-	-	-	АӨ	-	-
<b>4</b>	<b>Халиун буга</b>	<b>Cervus elaphus</b>	<b>АӨ</b>	-	+	-	УБа	+	ХО
<b>5</b>	<b>Цагаан зээр</b>								
<b>МАХ ИДЭШТИЙН БАГ - CARNIVORA</b>									
<b>1</b>	<b>Саарал чоно</b>	<b>Canis lupus</b>	<b>АӨ</b>	<b>II</b>	-	-	ХБ	-	-
<b>2</b>	<b>Шар үнэг</b>	<b>Vulpes vulpes</b>	<b>АӨ</b>	-	-	-	ХБ	-	-

3	<b>Харс үнэг</b>	<b>Vulpes corsac</b>	<b>АӨ</b>	-	-	-	<b>ХБ</b>	-	-
<b>ТУУЛАЙ ХЭЛБЭРТНИЙ БАГ – LAGOMORPHA</b>									
1	Чандага туурай	Lepus timidus	АӨ	-	-	-	АӨ	-	-
2	Боролzon туурай	Lepus tolai	АӨ	-	-	-	АӨ	-	-
<b>МЭРЭГЧДИЙН БАГ – RODENTIA</b>									
1	Монгол тарвага	Marmota sibirica	АӨ	-	-	-	УБ	-	-
2	Бараан хэрэм	Sciurus vulgaris	XO	-	-	-	ХБ	-	-
3	Сахалт багваахай	Myotis mystacinus	XO	-	-	-	АӨ	-	-
4	Дагуур огдой	Ochotona daurica	АӨ	-	-	-	АӨ	-	-
5	Үрт сүүлт зурам	Citellus undulatus	АӨ	-	-	-	АӨ	-	-
6	Орог зусаг	Phodopus sungorus	АӨ	-	-	-	АӨ	-	-
7	Дорнодын шашуурхай	Cricetulus pseudogriseus	XO	-	-	-	АӨ	-	-
8	Хэргэлзий оготно	Microtus gregalis	АӨ	-	-	-	АӨ	-	-
9	Улийн цагаан оготно	Lasiurus brantii	АӨ	-	-	-	АӨ	-	-
10	Монгол чичуул	Meriones unguiculatus	XO	-	-	-	АӨ	-	-

Тайлбар:

CITES /Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora/-

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай /CITES/ Вашингтоны конвенц

АӨ – анхааралц өртөхөөргүй, ЭМ – эмзэг,

УБа – Устаж байгаа, ХБ – ховордож болзошгүй, УБ – устаж болзошгүй,

НХ – нэн ховор, XO – ховор.

#### 11.1.1. Амьтдын тархац, нөөц

##### 1. Цагаан зээрийн тархац, байршил, тоо толгой

Хүснэгт 33. Цагаан зээрийн нөөцийн үзэлгээ

Сумын нэр	Боломжит тархац (км <sup>2</sup> )	Цөм байршил (км <sup>2</sup> ) /St/	Сорилын талбай (км <sup>2</sup> ) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/	Хязгаар-95% CI
Өмнөдэлгэр	2242.947	407.3	156.4	70	182	101-1004
Батширээт	78.0	58.2	22.0	58.	153.	78-233
Биндэр	95.5	55.5	24.3	58.	132	50-287

##### 2. Халиун бугын тархац, байршил, тоо толгой

Хүснэгт 34. Халиун бугын нөөцийн үзэлгээ

Сумын нэр	Боломжит тархац (км <sup>2</sup> )	Цөм байршил (км <sup>2</sup> ) /St/	Сорилын талбай (км <sup>2</sup> ) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Өмнөдэлгэр	2935.91	589.47	45.1	49	640±25
Батширээт	3570.75	1225.39	180.0	154.0	1408±32
Биндэр	1239.31	497.68	29.7	15	251±16

### 3. Бор гөрөөсний тархац, байршил, тоо толгой

**Хүснэгт 35. Бор гөрөөсний нөөцийн үнэлгээ**

Сумын нэр	Боломжит тархац ( $\text{km}^2$ )	Цөм байршил ( $\text{km}^2$ ) /St/	Сорилын талбай ( $\text{km}^2$ ) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Өмнөдэлгэр	2588.6	958.7	115.3	148	1231±35
Батширээт	4088.0	1797.6	140.5	117	1497±38
Биндэр	2561.5	942.9	31.4	28	841±28

### 4. Зэрлэг гахайн тархац, байршил, тоо толгой

**Хүснэгт 36. Зэрлэг гахайн нөөцийн үнэлгээ**

Сумын нэр	Боломжит тархац ( $\text{km}^2$ )	Цөм байршил ( $\text{km}^2$ ) /St/	Сорилын талбай ( $\text{km}^2$ ) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Өмнөдэлгэр	918.13	101.11	10.3	50	491±18
Батширээт	2028.45	764.05	216.4	185	653±19
Биндэр	1162.07	122.96	75	43	242±12

### 5. Монгол тарваганы тархац, байршил, тоо толгой

**Хүснэгт 37. Монгол тарваганы нөөцийн үнэлгээ**

Сумын нэр	Боломжит тархац ( $\text{km}^2$ )	Цөм байршил ( $\text{km}^2$ ) /St/	Сорилын талбай ( $\text{km}^2$ ) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Өмнөдэлгэр	286.89	77	31	128	477±122
Батширээт	51.58	10	5	40	206±15
Биндэр	206.88	69	45	70	210±35

6. Молцог хандгай (*Alces alces*)-н тархац, байршил, тоо толгой: 2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар  $7163.4 \text{ km}^2$  нутагт  $190\pm13$  толгой молцог хандгай 1000 га-д 0.2 бодгаль ногдох нягтишилтай байна.
7. Баданга хүдэр (*Moschus moschiferus*)-ийн тархац, байршил, тоо толгой: 2017 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар  $6556.9 \text{ km}^2$  нутагт  $143\pm11$  толгой баданга хүдэр 1000 га-д 0.2 бодгаль ногдох нягтишилтай байна.
8. Саарал чонын тархац, байршил, тоо толгой

**Хүснэгт 38. Саарал чонын нөөцийн үнэлгээ**

Сумын нэр	Боломжит тархац ( $\text{km}^2$ )	Сорилын талбай ( $\text{km}^2$ ) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Өмнөдэлгэр	7940.9	271.2	11	322±18
Батширээт	5870.2	122.2	15	721±27
Биндэр	4115.1	125.5	11	361±19

### 9. Шар үнэгний тархац, байршил, тоо толгой

**Хүснэгт 39. Шар үнэгний нөөцийн үнэлгээ**

Сумын нэр	Боломжит тархац ( $\text{km}^2$ )	Сорилын талбай ( $\text{km}^2$ ) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Өмнөдэлгэр	5100.7	147	9	312±18
Батширээт	5011.7	119.2	6	252±16
Биндэр	3222.3	55	4	234±15

### 10. Хярс үнэгний тархац, байршил, тоо толгой

**Хүснэгт 40. Хярс үнэгний нөөцийн үнэлгээ**

Сумын нэр	Боломжит тархац ( $\text{км}^2$ )	Сорилын талбай ( $\text{км}^2$ ) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Өмнөдэлгэр	1239.2	157	10	79±9
Батширээт	549.4	175	6	19±4
Биндэр	864.2	55		0±0

**11. Хярс үнэгний тархац, байршил, тоо толгой**

**Хүснэгт 41. Хярс үнэгний нөөцийн үнэлгээ**


Сумын нэр	Боломжит тархац ( $\text{км}^2$ )	Сорилын талбай ( $\text{км}^2$ ) /Ssd/	Ажиглагдсан бодгаль /Ns/	Нийт нөөц /Nt/
Өмнөдэлгэр	1239.2	157	10	79±9
Батширээт	549.4	175	6	19±4
Биндэр	864.2	55		0±0

Төслийн талбайд тархсан зарим хөхтөн амьтдын товч мэдээлэл, онцлог, тархцын талаар мэдээлэл оруулав.

**БАДАНГА ХҮДЭР (*MOSCHUS MOSCHIFERUS*)**

Баданга хүдэр Хэнтийн тайгын бүх хэсэгт, Хангайд хөвчин нуруу болон Булнай, Тарвагатай, Эрчим зэрэг салбар нурууны өндөр уулын хэц ар хажуугийн шинэс, ху шин ой дагаж алаг цоог тархажээ. Хэнтий, Хангайн баданга хүдэр морфологийн гол шинжээрээ Алтай, Өмнөт сибирийн хүдэртэй ойропшоо тул *Moschus moschiferus moschiferus* Linnaeus зүйлхэнд хамааруулан (Дуламцэрэн 1975) үзэж бийсан бол Хангай, Хэнтийд сибирийн баднга хүдэр *Moschus moschiferus sibiricus* зүйлхэнд хамаарах популяци байгаа нь тодорхой болжээ (Дуламцэрэн 1989). Харин Хөвсгөл, Соёны уулсаар *Moschus moschiferus moschiferus* Linnaeus тархсан байна (Дуламцэрэн 1970). Баников (1954) монгол орны худрийн тархцыг захидаа тухайн үед Хангайг тун бага судалсаны учир баданга хүдэр тархсан Тарвагатайн нуруунд байж болжонг үй хэмээн үлээмжийн газрыг мэдээгүй байдал (Дуламцэрэн нар 1989). Хэнтийн тайгын хэмжээнд баданга хүдэр ерийн амьтан бөгөөд Хангайн хөвчин нурууны ой модт ой хэсэг, Тарвагатай, Эрчимиийн нуруунд хориод цэгт баданга хүдэр олж тэмдэглэсэн бөгөөд энэ мужийн Цагаантуруут голын эхэнд баданга хүдэр байгааг анх П.Тарасов олж тэмдэглэжээ. Иймээс баданга хүдэр Хэнтийн тайгын хэмжээнд түгээмэл, харыцангуй жигдэвтэр, харин Хангайд урьд мэдэж байснаас хавьгүй их газар хоорондоо хол тасархай, алаг цоог тархалттай (Дуламцэрэн 1989).


Судалгаагаар баданга худрийн боломжит тархац нутаг манай орны засаг захиргааны хуваарын дагуу 12 аймаг, голомт нутаг нь 11 аймгийн нутгийг ямар нэг хэмжээгээр хамарч байна. Мөн манай орны нийт 29 сав газрын 19 баданга худрийн голомт болон тархац нутгийг хамарч байна. Баданга худийн голомт болон тархац нутгийн хамгаалалд Увс нуур-Тэс, Хяргас нуур-Завхан, Идэр, Чулуут, Орхон, Хануй, Хөвсгөл нуур-Эг, Туул, Хараа, Сэлэнгэ мөрөн, Ерөө, Онон зэрэг сав газрууд чухал үүрэгтэй. Ялангуяа баданга худрийн зах хязгаар тархац, голомт нутаг харьяалагдаж буй Хяргас нуур-Завхан, Увс нуур-Тэс, Бөөн цагаан нуур -Байдраг, Туул, Онон зэрэг баданга хүдэр түүхэн тархац нутгийн эргэн үзэгдэх, нутагшиж, тогтвортожиж популяци бий болж тархцаа тэлэх явцад болгоомжтой, анхааралттай хандаж, энэ талын судалгаа мониторингийн ажлуудыг зохион явуулах талаар мэргэжлийн байгууллага, удирдах байгууллагуудад хандах шаардлагатай байна.



Зураг 54. Монгол орны баданга хүдрийн тархац, байршлын судалгааны мэдээ (Биологийн хүрээлэн 2010).

#### **ХАЛИУН БУГА (*CERVUS ELAPHUS*)**

Халиун буга Хэнтий, Хангай, Хөвсгөл орчмын уулс, Хянганы салбар уулс, Монгол Алтайн ойт хээр, уулын тайгын б үсэд тархман бөгөөд монгол орны ойт нутгийн хил халиун бугын тарханы хилтэй давхцацаг байжээ. Монгол оронд Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулсад марал халиун буга (*C.e.sibiricus*), харин Хэнтийн зуун зах бэл, Халх голын сав Хянганы салбар уулсаар зээрд халиун буга (*C.e.xanthopygus*), Дорон тал хээрт (Навчвандан) алшаа халиун буга (*C.e.alashanicus*) гэх хоорондоо ялгаа багатай гурван зүйлжэн тархсан (Банников 1954; Дуламцэрэн 1970; 1977; Соколов, Орлов 1980; Соколов нар 1982; Дуламцэрэн нар 1989, Дмитреев нар 1992, Дуламцэрэн 2006) бөгөөд сүүлийн 2 зүйлжэн бий эсэхийг нарийвчлан судалж батлаагүй байна (Дуламцэрэн 2006). Халиун бугын тархац, популяцийн судалгааг Биологийн хүрээлэ нгээс монгол орны ойн туруутны популяцийн судалгааны хүрээнд тодруулж нөөцийг тодорхойлсон байдаг (Биологийн хүрээлэн 2010). Энэ судалгаагаар халиун буга манай орны 14 аймгийн нутгийг хамарсан 124612 км<sup>2</sup> нутагт тархсан болохыг тодруулсан зэрэгцээ халиун бугын тархац нутгийн 20.8% (26029 км<sup>2</sup>) ТХГН-и сүлжээнд, харин 9.5% (11897 км<sup>2</sup>) орон нутгийн орон нутгийн тусгай хамгаалалттай (ОНТХГ) газарт хамрагдсаныг (зураг 12) тогтоосон байдаг. Судалгааны хугацаанд 412 сурэг, 1648 халиун буга бүрлгэснээс 1000 га-д 2.5 бодгаль ногдох нягтшилтэй, 16482 (95% магадлал: 10186-23505 бодгаль) халиун бугын нөөцтэйг тооцсон байна. ТХГН-н ангилал тус бүрээр тооцосон халиун бугын тархац, нөөцийг уулын системээр тоймлон узвэл Хэнтийд 14093 км<sup>2</sup> нутагт дунджаар 3551, Хангайд 2968 км<sup>2</sup> нутагт дунджаар 1016, Хөвсгөлд 1041 км<sup>2</sup> нутагт дунджаар 508 халиун буга бий тооцсон байдаг (Биологийн хүрээлэн 2010).



**Зураг 55. Монгол орны халиун бугын тархац, байршилын судалгааны мэдээ (Биологийн хүрээлэн 2010).**

Халиун бугын амьдрах орчин, тархацын загварчлал хийсэн бидний судалгаагаар манай орны Хөвсгөл, Хан гай, Хэнтийн гол нуруу, тэдгээрийн салбар, зах бэлийн уулс, Орхон, Сэлэнгийн савын намавтар уулс, Халх, Номрөгийн сав, Лханчинвандад уулын орчмын уулс, хөндий, Хархираа -Түргээний уулын систем, Говь-Алтайн уулсын зарим хэсгийг хамарсан 347068.04 км<sup>2</sup> талбайд энэ зүйл туруутан байршил, идээнийн тохиromжтой нутаг байгаагийн 21% буюу 73266.86 км<sup>2</sup> нутаг голомт нутагт тооцогдож байна (зураг 13). Биологийн хүрээлэнгийн судлаачид (2010) судалгааныхаа үндсэн дээр халиун бугын цөм нутгийн хэмжээг нийт тархац нутгийн 72.6% (90514 км<sup>2</sup>) гэж тооцсоноос биднийхээс бараг Здахин их байна.

Халиун бугын тархац нутаг мансай орны засаг захиргааны хуваарын дагуу 17 аймаг, голомт нутаг нь 14 аймгийн нутгийг ямар нэг хэмжээгээр хамарч байна. Мөн манай орны нийт 29 сав газрын 26 сав газрын нутгийг халиун бугын тархац нутаг хамарч байхад голомт нутаг нь 21 сав газрын нутгийг ямар нэг хэмжээгээр хамарч байна. Халиун бугын голомт болон тархац нутгийн хамгаалац Увс нуур-Тэс, Хяргас нуур-Завхан, Идэр, Чулут, Хануй, Орхон, Туул, Хараа, Хөвсгөлийнур -Эг, Сэлэнгэ мөрөн, Ерөө, Онон болон Мэнэнгийн тал зэрэг сав газрууд ихээхэн чухал үүр эгтэй болно. Мен халиун бугын гүйдлээр үзэгдэх, тогтвожих, орон нутгийн сүрэг бий болох, тархац нутаг тэлэх г.м цаашдын хамгааллын менежментэд Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий болон Алтай нуруу түүний салбар уулсыг хамарсан сав газруудын үүрэг оролцоо их, тодорхой үүрэг түйцүүлжээ.

**ЯНГИР ЯМАА (*CAPRA SIBIRICA*)**


**Статус:** Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангиллын шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бус нутгийн хэмжээнд “ховордож болзошгүй” гэж үзэлэгдсэн.

**Хамгаалсан байдал:** Монгол улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор ховор амьтны хавсралтад бүртгэсэн. Тархац нутгийг Говийн их дархан цаазат газар, Хорьдол Сарьдаг, Богдхан уулын дархан цаазат газар, Их Богд, Говь турван сайханы байгалийн цогцолборт газар зэрэг улсын тусгай хамгаалалттай газарт хамруулсан.

**Биндэрийн овоо:** Батширээт сумын төвөөс урагш 45 км-т орших Биндэрьяа уулын узуур овоог 17-р зууны үед анхдугаар богд Өндөр гэгээн Занабазар Ононтын халуун рагцаанд бараалхаад буцах замдаа их Хэнтий нурууны төгөстгөл овоо ихсийн газар өршөөсөн нутаг хэмээн дээдлэн тахисан тухай домоглон ярилцдаг. Уг овоо нь Хөвчийн дайчин жонон вангийн хошууны гол тахилга овоо болон тахигдсаар ирсэн түүхтэй бөгөөд 1930-аад онд тасарсан/тус сумын харыгат зайран бөө Цэрэн баавай 1970-д онд нууцар тахиж байсан. 1990 онд сэргээн тахиснаас хойш Өмнөдэшгэр, Гурванбаан, Биндэр сумдууд жил жилээр ээлжлэн тахисаар байна.



Зураг 64. Биндэрьяа овоо

**Бинцэръяа хан ууланд орших Өглөгчийн хэрэм:** Тус хэрмийн тойргийн нийт урт нь 3.8 м. Хэрмийн ондөр хэсгээрээ 3.1м. Байгалийн бартаат хэсэгт байрлалаасаа шалтгаалан хэрмийн ондөр 1-3м орчим, өргөн нь 1.5м орчим. Монгол-Америкийн хамтарсан Чингис хаан экспедицийнхэн хэрмийн дотор талд 2 малтлага судалгаа хийсэн. Уг малтлагын нэгзэс барилтын суурь ханzan хаалтын систем, нөгөөгөөс нь нимгэн банзан австай буши зэрэг илэрсэн. Уг хэрэм нь МЭ11-13 зууны үеийн хэрэм юм.

**Бинцэръяа хан ууланд орших Рашиан хадны олон үеийн дурсгал:** Рашиан хадны анхны судалгааны ажлыг археологич Х.Пэрлээ 1943 онд хийсэн бөгөөд түнээс хойш хэд хэдэн удаа очиж судалсан байна. 1968 онд дахин судлах явцад нэгэн том чулуунд тогтсон хаг хөгцийн дор элдэв зураг дүрс байхыг ажиж нүүрэн талд нь 180 гаруй, ар талд нь 40 гаруй сэргээн дээр нь 50 гаруй дүрс сийлсэн байдал. Чулуун самбарын урт нь 6м, өргөн нь 2-3м зузаан нь 0.6-0.7м хэмжээтэй юм. Чулуун самбар дээрхи тамгуудыг нэг үед сийлсэн зүйл биш болохыг ажиж сийлсэн арга барил, тэдгээрээс олдсон хадны зураг, самбар чулууг малтаж гаргахад илэрсэн чулуун зэвсгийн зүйлс, хүрэл зэвсгийн үеийн ваарын хагархай, Киданы үеийн ваарын хагархай зэрэгт үндэслэн шинэ чулуун зэвсгийн сүүл үеэс эхлийн МЭ 10 зууныг дуустал үед нэмэн сийлсэн гэж үзж байна.

**Хажуу нуурын буган чулуун хөшөө:** Рашиан хадны зүүн зүтг 3 км зайд хүрлийн үеийн дөрвөлжин буши бухий дурсгалт газрын төв хэсгийн том хэмжээтэй булиши баруун хойд талд байрлах 2 ширхэг буган чулуун хөшөө. Уг 2 хөшөө нь зүүн хойноос баруун өмнөд чиглэлд хоорондоо 10 орчим м зайдай байрлажээ. Зүүн талын буган хөшөө нь 21x43x40 см, нөгөө нь 190x40x30 см хэмжээтэй юм. Хөшөөнд ашигласан чулуу нь цагаан боржин бөгөөд чулууны онцлог байдлаас болж сийлсэн дүрс нь зарим газартай хэмхэрч унасан, зураг дүрс тод ялгарч харагдахгүй байдалтай болжээ. Зүүн талын хөшөөнд сийлсэн зураг дүрс нь харьцаангуй мэдэгдэхүйц байна. Энэ хөшөөний доод талд онгон хөрснөөс 30-40 см ондерт гүн шулуун зураас, оройгоосоо доши мөн дээш ижил зайд дан шулуун татах хашааг 3 хэсэг болгожээ. Дээд хэсэгт нь дутуй дүрс, тамга тэмдэг, дунд хэсэгт нь хийсвэр байдлаар дүрсэлсэн 3 бугын дүрс, доод хэсэгт нь зэвсэг багажийн зүйл дүрсэлсэн байна. Евро Азийн нутагт 600 гаруй буган хөшөө тархсан байдгаас Монгол улсын 550 орчим нь бүртгэгджээ. Монголын нутагт тархсан буган чулуун хөшөө нь голчлон төв болон баруун нутагт орших бөгөөд энэ буган хөшөө хамгийн зүүн захад орших буган хөшөө юм.

#### 4. Хангалын нуурын ДГ

Хангал нуур нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд оршино, Хэнтий аймгийн зүүн өмнөд хэсэг орших бөгөөд ойт хээрийн бүсэд оршино. Хурхын гол, түүний цутгал Жаргалант гол хоёрын хооронд оршино. Энэ бол ойт хээрийн бүсэд орших хамгийн том нуур багаад бусад нууруудыг бодвол усны горимын хувьд нийзэд тогтвортой гэж үзж болно. Эргэн тойрон хадтай уулсаар хүрээлэгдэн 1326 м үнэмлэхүйн ондерт орших энэхүү нуур тектоникийн хонхорт тогтох, хамгийн урт нь 2 км, өргөн нь 500-1200 м, талбай нь 1,5 хавтгай дөрвөлжин км хурдэг байна. Нуурын хөвөөгөөр ондөр дэнж мөргөнчөг байхгүй, налуу эрэгтэй, олон, зэгс ургаснаас гадна, хус, бургас, боролзгоно хаана ургана. Нуурын өроол жигд, зах хөвөөгөөр бүдүүвэр боржингийн үйрмэг байх боловч шавранцар хурдас тархана. Усны тунголаг 1,6-1,7 м, хамгийн их гүн зөвхөн баруун хойд талдаа 2,3м хүрнэ. Усны неөц одоо 49 сая шоо метр, харин геологийн онгөрсөн үед үнээс их байсан батлах ор мөр үлдээжээ. Нуурын өмнөд талд усны захаас 10-15 м зайдай 1,5 м орчим ондөр далан байдал. Энэхүү далан 100 шахам метр байсан боловч хожим ургсал усанд идэгдэн 50-60м сэтрэн эмсийжээ. Одоо энэ сэтрхий дахь


жижиг хувилаар горих урсац Жартгалантын голд цутгадаг учир энэ нуур урсгал нуур юм. Ус нь 10 дугаар сарын сүүлчээр халдаж, 5 дугаар сарын эхээр гэснэ. Усны химийн бүтцийг үзвэл 1 литр усны нийт эрдэсжилийн хэмжээ 722,76 мг, хуурай үлдэц 480,4 мг усны хатуушилт 2,8 мг/экв болно.

Хэнтийн өндөр уулс зүүн, баруун, урагшлах тусмаа намссаар дундаж өндөр ууласт шилждэг. Тийм хэсэгт Хангалын нуур байх бөгөөд напууттар хажуу нь дэлсви, проловийн сэвсгэр хурдаар илүүтэй бүрхэгдээз. Тиймч учраас үндсэн чулуулаг ил гарсан нь бага юм. Гуу жалгаар нилээд хэрчигдсэн бөгөөд тэдгээрийн амсарт хушуурсан туугдас давхарлан тогтсон үзэгдээ. Хад асга цөөн тохиолдохын хамт солифлокцийн үзэгдэл ч ховор юм. Энгэр хажууд нарины цацраг эгц тусч ууршилт зрчтэй явах нөхцлийг бүрдүүлнэ. Зуны борооны ус хөрсөнд хадгалаагдах нь харьцангуй бага. Энэхүү ландшафт наран ишүү зэгдэг тул өдрийн агаарын температурын хэлбэлзэл их байна. Хур тундасны хэмжээ харьцангуй бага учир уур амьсгал хуурайттар боловч ойн ургамал ургах наад захын нөхцөл алдагддагүй гэж хэлж болно. Тэрч байтугай өвөл ордог цас ой дотор багагүй хунгарлана. Хөрсон бүрхэвч ойн бараан хөрснеес бүрэлдэх бөгөөд механик бүрэлдэхүүний хувьд голчлон элсэнцэр юм. Харин ялзмаг багатай байдаг, дээд давхарганд 3-4 хувцас бараг үл хэтэрнэ. Олон жилийн цэвдэг чулуулаг энд гол төлөв 3-4 метрээс доопш гүнд орших тул хөрсний тогтвортолжонд төдийлэн мэдэгдэхүйц үзүүлдэгтүй байна. Энэ хөрсон дээр өвслөг ургамал шигүү ургаж төгөл үүсч тогтвортсон байна. Ойн гишүү нь 0,4-0,5-ас үл хэтэрдэг буюу ерөнхийдөө сийрэг гэсэн уг. Ийм ойд сеөг ургамлын төрөл зүйлээр цөөн юм. Сеөг ургамлаас бургас, далан хамыс, нохойн хошууг дурдаж болно. Харин өвслөг ургамлын зүйл ишүү олон бөгөөд сибирь шимтэглэй, мягмарсанжаа, холтсон цэцэг, тортон шарилж, гүзээлзгэнэ зэрэг ургамал чухал үүрэг гүйцэтгэнэ.

## БҮЛЭГ 14. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ


### 14.1. Төсөл хэрэгжих нутгийн нийгэм, эдийн засгийн төвч танишуулга

Тус “Өмнөдэлгэр-Биндэр-115 км хатуу хүчилттай автозам” нь Монгол улсын байгалийн бус, бүслүүрийн онцлогоор ойт хээрийн болон хээрийн бүсэд орших ба Засаг захиргааны хуваариар Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт сумдын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн дайран өнгөрнө. Замын трассын эхлэл цэг буюу Өмнөдэлгэр сум нь Улаанбаатар хотоос зүүн тийш 268 км, Чингисхан хотоос баруун хойш 195 км зайд байрлана. Тус хатуу хүчилттай зам барих төсөл нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр сум зэрэг суурин газруудыг хатуу хүчилттай замтай холбосон хүн амын нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой төсөл юм.




Зураг 65. Төслийн талбайн засаг захиргааны зураг

Замын зурvas газар нь Хэнтийн аймгийн Өмнөдэлгэр сумын Төвийн 6-р баг, Хэнтий 3-р, Батширээт сумын Хурх 3-р баг болон Биндэр сумын Мандалхаан 2-р баг, Онон 5-р багуудын нутаг дэвсгэрийг дайран өнгөрнө. Тус төслийн байгаль орчны төлөв байдлын үзүүлэлтийн хээрийн судалгааны үеэр замын трассын дагуу 33 малчдын өвөлжээ, намаржааны газартай тааралдах, эдгээрийн газарзүйн солбижолыг тэмдэглэж, фото зургаар баримтжуулав.



**Зураг 66. Замын трасс дайран өнгөрөх багууд**




**Зураг 67. Замын трассын дагуу дайралдах саянжээ, намаржааны байршил**

Хүснэгт 46. Замын трассын дагуу байрлах өвлийн, намаржааны солбицол

Өвлийн, намаржааны дугаар	Солбицол	
	ЗУ	ХӨ
1	109°52'09.13"	47°57'36.53"
2	109°52'00.81"	47°57'45.53"
3	109°52'45.53"	47°57'45.53"
4	109°50'52.41"	47°58'47.07"
5	109°50'59.51"	47°58'59.51"
6	109°50'28.18"	48°01'04.42"
7	109°50'18.13"	48°02'17.58"
8	109°50'17.42"	48°02'18.37"
9	109°49'40.82"	48°03'05.44"
10	109°49'52.48"	48°03'53.03"
11	109°54'48.97"	48°07'36.22"
12	109°56'06.31"	48°08'08.19"
13	109°57'23.47"	48°10'11.83"
14	109°58'05.67"	48°10'28.01"
15	110°04'12.99"	48°15'58.05"
16	110°06'29.93"	48°16'57.57"
17	110°08'15.61"	48°18'05.26"
18	110°12'18.09"	48°20'37.38"
19	110°16'19.35"	48°22'07.49"
20	110°17'47.72"	48°22'33.56"
21	110°17'52.19"	48°23'38.34"
22	110°17'49.66"	48°25'06.72"
23	110°20'26.52"	48°27'36.64"
24	110°21'11.91"	48°28'07.07"
25	110°21'35.65"	48°28'10.94"
26	110°23'13.46"	48°29'08.52"
27	110°24'00.95"	48°29'59.69"
28	110°24'16.23"	48°30'07.26"
29	110°24'39.45"	48°30'23.99"
30	110°24'39.31"	48°30'24.09"
31	110°24'41.92"	48°30'26.91"
32	110°25'23.66"	48°31'03.72"
33	110°30'52.50"	48°33'18.73"



Зураг 68. Өмнөдэлгэр сумынг төв



Зураг 69. Замын трассын дагуу байрлах өвөлжөө, хаваржаа


#### 14.2. Хэнтий аймгийн нийгэм-эдийн засгийн толов байдал

Хэнтий аймаг нь Монгол орны эдийн засгийн Зүүн бүсийн хойд хэсэгт нийслэл Улаанбаатар хотоос 330 км зайд оршдог. Хойд талаараа Оросын Холбооны Улстай хил залгана. Улс дотор Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр, Төв, Сэлэнгэ гэх 6 аймаг

Улсын нийслэлийн Багануур дүүрэгтэй хилийдэг. Аймгийн төвийг 2013 оноос Их эзэн хааны нэрээр Чингис хот хэмээн иэрлэсэн. Хэнтий аймаг 80311 мянган хавттай дөрвөлжин км газар нутагтай, 76019 мянган хүн амтай, Засаг захиргааны 18 нэгжтэй, 4409317 мянган толгой малтай, аймгийн нэг хүнд 1.0 хавттай дөрвөлжин км нутаг, бодод шилжүүлийнээр 15 толгой мал ноогддог. Аймгийн эдийн засгийн гол чухал салбар нь мал аж ахуй юм. Хэнтий аймгийн ихэнх сум Тал хээрийн байгалийн бусэд хамрагдах бөгөөд хархи Цэвхэрмандал, Өмнөдэлгэр, Батширеэт, Бандэр, Баян-Адрага, Дадал, Норокчин сум Ойт хээрийн бусэд орно. Аймгийн нийт нутгийн 63.2 хувийг бэлчээр, 4.1 хувь хадлангийн талбай, 0.8 хувь тариалангийн талбай, 14.1 хувийг ойн талбай, 16.5 хувийг тусгай хэрэгцээний газар эзэлдэг. Манай улсын нийт ойн талбайн 7.9, хадлангийн талбайн 19.0 хувийг тус аймаг эзэлдэг. Аймгийн нийт нутаг далайн түвшнээс 830-2362 метрийн ондорт өргөгдсөн, төрийн тахилгат Хэнтий хан уул (2362), Дэлгэрхан уул (2111), Баян улаан уул (2042) зэрэг сүрлэг сайхан уулс, Хэрлэн, Онон, Балж зэрэг гол мөрөнтэй.

**Хүснэгт 47. Хэнтий аймгийн хүн амын тоо**

Хэнтий аймаг	Хүйс	2016	2017	2018	2019	2020
	Нийт дун	73,608	76,019	77,664	77,320	78,813
	Эрэгтэй	37,293	38,360	39,229	39,085	39,829
	Эмэгтэй	36,315	37,659	38,435	38,235	38,984
	Орхийн тоо	23,784	24,705	25,172	23,906	24,372



**Газарзүйл онцлог:** Хэнтий нуруунаас эх авсан Онон, Хэрлэн, Улз, Балж зэрэг 70 гаруй том, жижиг голууд, Ононгийн халуун рашаан, Аварга тосон, Гурван нуур, Тарс, Жаргал нуур зэрэг алкаал, эмгэг тайлах рашаан ус олонгой. Хэрлэн, Онон, Улз, Хурх голын сав, Чандаган, Баяны уудам тал хөндий, тансаг сайхан бэлчээр, хар хөрстэй хадлан тариалангийн үргэлийн шимт талбайнууд байдаг. Эх газрын эрс уур амьсгалтай, өвөлдөө ондер дараалгтай, хур тунадас багатай, хүйтэн цэлмэг өдөр олон, жилийн дундаж агаарын

температур -10 градус, зарим өвлийн -46 градус хүртэл хүйтээрдэг, хамгийн халуу нь 7,8 дугаар сард +39 градус, жилд дунджаар 200-300 мм тунадас унана.

**Хөдөө аж ахуй:** 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дунгээр 4868.4 толгой мал тоолуулж өмнөх оноос 223.4 мянган толгой буюу 4.8 хувиар өссөн байна. Үүнээс тэмээ 0.04 буюу 1 хувиар буурсан, адuu 6.5 мянга буюу 2 хувиар, үхэр 28.2 мянга буюу 7.9 хувиар, хонь 101.3 мянга буюу 4.3 хувиар, ямаа 87.5 мянга буюу 5.4 хувиар тус тус очижийн машин тоо 4 төрөл дээрээ өссөн байна. Нийт мал сүргийн дотор адuu 6.7 хувь, үхэр 7.8 хувь, тэмээ 0.1 хувь, хонь 50.4 хувь, ямаа 35.0 хувийг тус тус эзэлж байна. Аж үйлдвэрийн салбарт 50 гаруй аж ахуйн нэгж 300 -аад иргэд үйл ажиллагаа явуулж, түүнд 1800 гаруй ажиллагсад ажиллаж байна. Аж үйлдвэрийн салбарын дунгээр 81764986.0 сая төгрөгийн бутээгдэхүүн үйлдвэрийн 112304609.5 сая төгрөгийн бутээгдэхүүнийг зах зээлд барьнуулав. Энэ онд өмнөх оны мөн үстий харьцуулахад үйлдвэрийнг 17699.6 сая төгрөг, борлуулалт 45809.7 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

**Боловсрол:** 2019– 2020 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 1806, 10 дугаар ангид 702 хүүхэд зэлсэн суралцсан нь өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 1 дүгээр ангид элсэгчид 11.1 хувиар өсч, 10 дугаар ангид элсэгчид 22.8 хувиар буурсан байна. Энэ хичээлийн жилд 755 багш ажилласж байгаагийн 79.6 хувь болох 601 нь эмэгтэй багш нар байна. Сургуулийн дотуур байранд 1289 хүүхэд амьдарч байна.

**Эрүүл мэнд:** Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр энэ онд 1567 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн оноос 7.3 хувиар буюу 107 хүүхдээр өссөн байна. Нэг хүртэлих насандын 25 хүүхэд эндсэн. Халдварт өвчинеэр 533 хүн өвчилсөн нь өнгөрсөн оноос 16.5 хувиар буюу 105 хүнээр буурсан байна. Халдварт өвчинеэр өвчлөгчдийн дотор трихомониазиар өвчлөгчид 12.4, вируст гепатитаар өвчлөгчид 1.9, сүрьеэз өвчинеэр өвчлөгчид 24.4, тэмбүү, хүйтэн өвчинеэр өвчлөгчид 36.4 хувийг тус тус эзэлж байна. Энэ онд 370 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 2.5 хувиар өссөн байна. Нийт нас барсан хүний 23.5 хувь нь эмнэлэгт нас барсан байна.

**Нийгмийн халамж, даатгал:** Нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын мэдээгээр энэ онд нийгмийн халамжийн сангаас 48970 хүнд 12052.7 сая төгрөгийн тэтгээр тэтгэмж, хөнгөлөлтийг олгосон байна. Нийт халамжийн сангийн 23.8 хувийг тэтгэвэрт, 11.8 хувийг тэтгэмж, 6.7 хувийг ахмад настан, тахир дутуу хүмүүст үзүүлэх хөнгөлөлтэд тус тус зарцуулсан байна. Харин 57.7 хувийг амьжиргаа дэмжих мөнгөн тусламж үзүүлэхэд зарцуулжээ.

**Төсөв, санхүү:** 2019 оны 12 дугаар сарын байдлаар төсвийн орлогод нийт 10983.4 сая төгрөг төвлөрөхөөс 14459.9 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 3476.5 сая төгрөг буюу 31.7 хувиар төлөвлөгөө бишээсэн байна. Татварын бус орлогод төвлөрүүлж ёстой 825.3 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг 73.0 хувиар давуулаан бислүүлж, төсөвт татварын бус орлогоор 1427.9 сая төгрөг төвлөрсөн байна. Орон нутгийн төсвийн байгууллага нийт 64395.6 сая төгрөгийн зарлагатай ажилласан нь төлөвлөснөөсөө 4398.2 сая төгрөгөөр бага зарцуулалттай ажилласан байна.

#### 14.3. Өмнөдэлгэр сумын нийгм-эдийн засгийн төлөв байдал

Өмнөдэлгэр сум нь Хуучнаар Сэцэн хан аймгийн Мэргэн гүний хошууны нутагт 1923 онд Өндөрцагаан уулын хошуу нэртэйгээр байгуулагдсан. 1925 оноос Сэцэн хан аймгийн Засаг захиргааны зохион байгуулалт хийхэд Дэлгэрхаан сум болгон өөрчилсөн. Хөвчийн Жонон вангийн хошууг 10 гаруй сум болгон шинээр зохион байгуулахад Дэлгэрхаан нэртэй сум хоёр болсон байна. Үүнийг ялгахын тулд газар нутгийн

байрлааэр нь Хойд-Дэлгэрхaan, Омнө Дэлгэрхaan гэж ирлэсэн бөгөөд сүүлд “хаан” гэдэг нэр нь хасагдах Өмнөдэлгэр гэж ирлэгдсэн түүхтэй.

1956 онд Гурванбаян сумын баруун тал, 1974 онд Хэнтий /Хойд Дэлгэрхaan/ сум, 1999 онд Хурхын сангийн аж ахуй буюу Гурванбаян сум ийилж одоогийн Өмнөдэлгэр сум болон өргөжсөн. 2020 оны байдлаар сум нь засаг захиргааны 7 багтай нийт 5870 хүн амтай. Хойгуураа ОХУ-тай 50 орчим км газраар, зүүн талаараа Батширээт сум, Бинцэр сум, зүүн урдуураа Хэрээн сум, урдуураа Мөрөн сум, баруун талаараа Жаргалтхаан, Цэнхэрмандал сумдууд, баруун хойд талаараа Төв аймгийн Мөнгөнморьт сум, Сэлэнгэ аймагтай хишлэдэг.



Зураг 70. Өмнөдэлгэр сум руу орох хэсэг, алсаас харагдах байдал

**Байгаль цаг уурын онцлог:** Нутгийн хойд хэсэг нь бүхэлдээ Хэнтийн нурууны уулс юм. Энд орших Хэнтий ханы нурууны оргийн далайн түвшнээс 2452 м өндөр, мөн Хэнтий ханы араар далайн түвшнээс 2298м өндөр Дуут Ян, 2278м өндөр Их Сүүхлэг, 1818м өндөр Цонжийн чuluу, 1754м өндөр Бөхөг цагаан, 2098м Бэрэнчин Ян, 2362м өндөр Бурхан халдун, 2007м өндөр Тарсын тээгсэрг, 1863м өндөр Улаан байц, 1517м өндөр Сант, 2297м өндөр Цүүц, 1958м өндөр Их даваа уулууд байхаас гадна Сумын хамгийн нутгийн хамгийн нам цэг нь Хурхын гол сумын хилийг зүүн хойшоо огтолон гарч байгаа цэгт далайн түвшнээс 100 орчим м өндөрт оршино. Өмнөдэлгэр сум нь хойд талаараа ОХУ, баруун хойд талаараа Цэнхэрмандал, Төв аймгийн Мөнгөнморьт, зүүн болон зүүн хойд талаараа Хэрээн, Жаргалтхаан сумдуудтай хишлэдэг. Улаанбаатар хотоос 300км, Хэнтий аймгийн төв Чингис хотоос 110км ажлаагдсан ба 1088989,2 мянга нутаг дэвсгэртэй, Монголын ой тал хэр хосолсон Хэнтий нурууны уулархаг нутгийн урд хэсэгт оршино

**Хүн ам:** 2020 оны байдлаар сум нь засаг захиргааны 7 багтай нийт 1875 өрхийн 5870 хүн амтай. Өмнөдэлгэр сумын хүн амын 37%-ийг 0-17 наасны хүүхэд, 53% нь хөдөөмөрний наслын залуучууд, 10% нь ахмад насттан байна. Сүүлийн 5 жилийн хүн амын тоон үзүүлэлтийг харахад өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 48. Өмнөдэлгэр сумын хүн амын тоо

Өмнөдэлгэр сум	Хүйс	2016	2017	2018	2019	2020
	Нийт дун	5,379	5,652	5,789	5,851	5,890
	Эрэгтэй	2,691	2,849	2,914	2,943	2,966
	Эмэгтэй	2,688	2,803	2,875	2,908	2,924

	Нийт дун	623	666	656	640	629
1-р баг, Нирэн	Эрэгтэй	299	319	320	315	307
	Эмэгтэй	324	347	336	325	322
2-р баг, Баянзурх	Нийт дун	691	751	788	818	846
	Эрэгтэй	371	396	420	444	459
	Эмэгтэй	320	355	368	374	387
3-р баг, Хэнтий	Нийт дун	908	1,001	1,042	1,086	1,104
	Эрэгтэй	448	509	532	557	564
	Эмэгтэй	460	492	510	529	540
4-р баг, Талын булаг	Нийт дун	357	423	423	432	431
	Эрэгтэй	166	211	207	203	206
	Эмэгтэй	191	212	216	229	225
5-р баг, Чигдэгчин	Нийт дун	641	635	673	676	693
	Эрэгтэй	325	331	339	339	349
	Эмэгтэй	316	304	334	337	344
6-р баг, Төвийн	Нийт дун	1,248	1,263	1,254	1,253	1,260
	Эрэгтэй	595	591	593	587	596
	Эмэгтэй	653	672	661	666	664
7-р баг, Гурвалжилин	Нийт дун	911	972	953	946	927
	Эрэгтэй	487	492	503	498	485
	Эмэгтэй	424	421	450	448	442
	<b>Орхийн тоо</b>					
		1,732	1,770	1,882	1,870	1,875




График 6. Өмнөдэлгэр сумын хүн амын тоо /2016-2020/


**Зам төхөр:** Сумын төв Ондераанас 110 км, Улаанбаатараас 300 км орчим зайдай оршино. Тус сум нь Мянганы замд 55км ойрхон. Сумын төвдөө 2,5км сайжруулсан широон замтай. Багууд хоорондоо широон замаар холбогддог.

**Аж ахуй язгыг:** Сумын хэмжээнд нийт 42 аж ахуй нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж 18,3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 6,8 сая төгрөг, аймагт 148,2 сая төгрөг, орон нутагт 75,8 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Зах


зээлийн эдийн засгийн өнөөгийн иехцэлд дэд бүтэц, газар тариалан, жижиг дунд үйлдвэрээс хөгжүүлэх байгаль, нийгэм эдийн засгийн таатай иехцөл бүрдсэн.

**Газар тариалан:** Хэнтий аймгийн газар тариалангийн талбайн 80% нь тус суманд байдаг. Сумын хэмжээнд 7389,4 га газар тариалангийн эргэлтийн талбайтай үүнээс 7274,9 га-д үр тариа тариалж 7280,8 тонн ургац, 114,5 га-д төмс хүчиний ногоо тариалж 1247 тонн ургац хураан авсан.

**Мал ажс ахуй:** Сумын хэмжээгээр 2020 оны байдлаар нийт 627435 толгой мал, 1476 малчин өрх тоологдсон. Харин тус сумын малын тоо толгой 2015 оноос хойш 191103 толгой малаар өссөн үзүүлэлтийн малчдын тоо 99-р ижмэгдсэн байна.



Зураг 71. Өмнөдэлгэр сумын малчдын тоо /2015-2020/



Зураг 72. Өмнөдэлгэр сумын малын тоо /2015-2020/

#### 14.4. Биндэр сумын нийгэм-эдийн засгийн талов байдал

1923 онд Ардын засгийн газрын 38, 43-р тогтоод, 1923.01.05-ны өдөр батлагдсан нутгийн захиргааны дурмийн дагуу Хан Хэнтий уулын аймгийн Биндэрьяа уулын хошуу хэмээн нэрлэж Баянхутаг, Баян-Өлзийт, Баруун баян, Хутагтхайрхан, Дэлгэрхаан Жинс, Биндэрьяа, Түмэн, Жаргалан, Баря, Баян-Адрага зэрэг 10 сумаар зохион байгуулж төв Биндэрьяа нь Хурх голын хойно төвлөрч Шагдарын Гомбо тэдэг хүн хошуу даргаар ажилласж байжээ. Хэнтий аймгийн Биндэр сум нь Хамаг Монголын Ханлиг-Чингис хааны голомт, Их Монгол улсын Тулгар төрийн тоонот нутаг хэмээн түүхийн сурвалж бичгүүд, эрдэмтэн судлаачдын бүтээлүүдэд тэмдэглэгдсээр ирсэн газар билээ. Аих 1980-аад оны үед бие даасан засаг захиргааны нэгж болон Халхын Сэцэн Хан аймгийн Хөвчлийн Жонон вангийн хошуу гэж бүрэлдэн тогтсон гэж үздэг. Тэр үедээ уг хошуу нь ОНон, Хурх, Эг, Барх, Угалзар Тэнгилэг, Уужим, Жавхлант, Ург Гурван Манхаадай зэрэг уудам нутгийг

хамарч, Сэцэн Хан аймгийн 25 хошууны 16-тай нь ил залган, хүн амынхаа тоогоор аймагтаяа томоохонд тооцогдож байжээ.

**Байгаль цаг уурын онцлог:** Биндэр сум 536601 га нутагтай, далайн тувшиээс дээш дунджаар 1049м өргөгдсөн, өвөлдөө дунджаар -23 хэм орчим, зундаа дунджаар +18 хэм, жилийн дундаж температур -2,2 хэм, жилд дунджаар 317 мм тунадас унадаг. Монгол улсын хилийн хойд хэсэгт Хэнтийн шурууны зүүн салбар уулсын өвөр, ойт хээрийн бүсийн өргөн уудам нутгийг хамарч ОХУ – ын Байгаль чанадын хязгаар, Дадал, Баян-Адрага, Батноров, Хэрлэн, Өмнөдэлгэр, Батширээт сумдуудтай хил залган орших бөгөөд Өндөрхаан хотоос 180 км, Улаанбаатар хотоос 406 км алслагдсан, Хэнтий аймгийн хойд бүсийн тулгуур төв 4000 гаруй хүн амтай томоохон сум юм.




Зураг 73. Биндэр сум, алсаас харагдах байдал

**Хүн ам:** Одоо тус сум засаг захиргааны 5 багт 1326 өрхийн 4051 хүн амтай, 174,0 мянган малтай, 478 малчин өрхтэй, 25 мянгат малчинтай. Сумын хүн амын 70 хувь нь залуу болон дунд насныхан, 25 хувь нь хүүхэд, 5 хувь нь ахмадууд байна.

Хүснэгт 49. Биндэр сумын хүн амын тоо

Биндэр сум	Хүс	2016	2017	2018	2019	2020
	Нийт дүн	4,004	4,013	4,063	4,034	4,068
	Эрэгтэй	2,053	2,053	2,086	2,073	2,088
	Эмэгтэй	1,951	1,950	1,977	1,961	1,980
1-р баг, Баян-Өндер	Нийт дүн	613	621	655	658	670
	Эрэгтэй	310	315	328	334	335
	Эмэгтэй	303	306	327	324	335
2-р баг,	Нийт дүн	700	695	693	696	707

<b>Мандахзан</b>	<b>Эрэгтэй</b>	<b>369</b>	<b>365</b>	<b>363</b>	<b>365</b>	<b>370</b>
	<b>Эмэгтэй</b>	<b>331</b>	<b>330</b>	<b>330</b>	<b>331</b>	<b>337</b>
3-р баг, Баянгол	<b>Нийт дун</b>	<b>820</b>	<b>824</b>	<b>841</b>	<b>821</b>	<b>823</b>
	<b>Эрэгтэй</b>	<b>409</b>	<b>409</b>	<b>424</b>	<b>422</b>	<b>423</b>
	<b>Эмэгтэй</b>	<b>411</b>	<b>415</b>	<b>417</b>	<b>399</b>	<b>400</b>
4-р баг, Дэлгэрхан	<b>Нийт дун</b>	<b>657</b>	<b>659</b>	<b>651</b>	<b>647</b>	<b>649</b>
	<b>Эрэгтэй</b>	<b>350</b>	<b>351</b>	<b>349</b>	<b>340</b>	<b>341</b>
	<b>Эмэгтэй</b>	<b>307</b>	<b>308</b>	<b>302</b>	<b>307</b>	<b>308</b>
5-р баг, Онон	<b>Нийт дун</b>	<b>1,214</b>	<b>1,214</b>	<b>1,223</b>	<b>1,212</b>	<b>1,219</b>
	<b>Эрэгтэй</b>	<b>615</b>	<b>613</b>	<b>622</b>	<b>612</b>	<b>619</b>
	<b>Эмэгтэй</b>	<b>599</b>	<b>601</b>	<b>601</b>	<b>600</b>	<b>600</b>
<b>Биндэр сум</b>	<b>Өрхийн тоо</b>					
		<b>1,269</b>	<b>1,300</b>	<b>1,331</b>	<b>1,299</b>	<b>1,326</b>




**График 7. Биндэр сумын хүн амын тоо /2016-2020/**

**Газар тариалан:** Газар тариалан үр тариа, 20 га талбайд төмс, 10 га талбайд хүнсний ногоо, тариалж 2600 тонн үр тариа, 340 тонн төмс, 142 тонн хүнсний ногоо хураан авч байна


**Аж ахуй иэгж:** Суманд төсвийн 6 байгууллага, 22 аж ахуйн иэгж байгууллага, 14 төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

**Зам тээвэр:** Сумын газар нутаг дээгүүр ОХУ-ыг Нийслэлтэй холбосон улсын чанартай 35.6 км авто зам дайран өнгөрдөг. Багууд хоорондоо шороон замаар холбогдуулж байна.

**Мал аж ахуй:** Сумын хэмжээгээр 2020 онд нийт 253,885 мал тоологдсоноос цэвэр үүдээр, эрлийз, нутгийн шилмэл омгийн мал, нийт малын 12,5 хувь байна. Малчдын тоо 155 байгаа нь 2015 онтой харьцуулжад 733-р буурсан байна. Харин тус сумын малын тоо толгой 2020 онд 253885 тоо толгой гэж тоологдсон нь 2015 оны мөн үетэй харьцуулвал 79885 тоо толгойгоор өссөн үзүүлэлтэй байна. Энэ нь тус бус нутагт 1 малчинд ноогдох малын тоо жил ирэх тусам өссөн үзүүлэлтэй байна.



Зураг 74. Биндер сумын малчдын тоо /2015-2020/



Зураг 75. Биндер сумын малын тоо /2015-2020/

Эх сурвалж: *Статистикийн нэгдсэн мэдээллийн сан*

## БҮЛЭГ 15. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НАЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ АРГА ЗАМ

### 15.1. Байгаль орчны болзошгүй налөөлэл

Авто замын төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт налөөлж болзошгүй хэлбэрүүд, түүний шинж чанар зэргийг урьдчилсан байдлаар тодорхойлсон бөгөөд мөн глашид налөөллөөс урьдчилсан сэргийлэх зорилгоор авах арга хэмжээний чиглэл, зарим зөвлөмж, саналыг төвч тусгав.

*Шууд налөөлөл /Сөрөг налөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж/*

- ✓ Зам барилгын ажлын улмаас болон төслийн талбайн орчин тойронд олон салаа зам үүссэнээс тоосжилт үүсэх, хөрс эвдрэх  
*/Хуурайшилт ихтэй үед хөрс, шороо хийсэхийг багасгах, услах, үржил шимт өнгөн хөрсийг хамгаалах, нөхөн сэргээж тэгшилсэн газрыг аль болох ботижоо хугацаанд өнгөн хөрсөөр хучиж ургамалжуулах, зүлэгжүүлэх, нөхөн сэргээх/*
- Ургамлан нөмрөг устах, ургамлын терөл зүйл хомсдох, бэлчээрийн ургамал хомсдоноос бэлчээрийн талбай багасах  
*/Ургамлын терөл зүйл, тархалтыг тогтоох, ургамлан нөмрөг хомсдох, устахаас сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, ховор болон иэн ховор ургамал байгаа эсэхийг тогтоож, хэрэв тэдгээр нь байгаа бол хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг иж бүрэн төлөвлөх/*
- Битум, шатах, тослох материалыар газар, хөрс, ус бохирдох  
*/Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч шандындаас сэргийлэх, хаягдлыг цуглуулж цэвэрлэн эргүүлж ашиглах арга хэмжээг төлөвлөх, бохирдсон хөрсийг цэвэрлэх, зайлцуулах арга хэмжээ авах/*
- Зам байгуулах явцад шинээр карьеер үүсгэснээс газар, хөрс эвдрэлд орох  
*/Карьериg байгуулахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах, нөхөн сэргээлтийн ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх/*
- Ажиллагсдын түр сууц, тосгон, түүний цогцолбороос байгаль орчин, хүний эруул мэндэд таагүй налөөлөл учруулах  
*/Ажиллагсдын тосгон, орон сууцны цогцолбороос гарах хатуу, шингэн хаягдлыг зориулалтын тусгай цэгт, эмх цэгцтэй хадгалах, зохих цэвэрлэгээ, халдвартай түүхэлт хийж, байгаль орчинд халгуй аргаар тогтмол хугацаанд зайлцуулж байх/*
- Газар шорооны ажлын үед болон замын байгууламж байгуулах, нух суваг шуудуу татсанаас газрын эвдрэл үүсэх  
*/Газар шорооны болон замын барилга байгууламжийн ажлын үед эвдэрсэн газрыг засч тэгшлэх, нөхөн сэргээх, ургамалжуулах, мод, зүлэг тарих, тэрчилэн суваг шуудуу татах ажлыг тусгай зураг төслийн дагуу хийж/*
- Хөрс гулсах, нурах, урсах зэргээр хөдөлгөөнд орж, замын ховилд орох, замыг эвдрэлд оруулах  
*/Замыг тогтвортжилт сайтай хөрс бүхий газарт барыж байгуулах, замын суваг, шуудууг татахдаа гадартын урсын нөхцөлийг харгалзан тооцох/*
- Замын урсац зайлцуулах хоолой, шуудуугаар урсах усны урсгалын налөөгөөр замын байгууламж болон ойр орчмын газар, хөрс эвдрэлд орох  
*/Усны урсыг гадагшуулах хоолой, сувгийн тооцоог нарийвчлан хийх, усны хоолойг байрлуулахдаа жижиг хүрхрээ үүсэхээс зайлсхийх, ус зайлцуулах суваг, шуудууг чулуу болон бетоноор доторлож бэхжүүлэх/*
- Байгалийн ёнгө, төрх байдал өөрчилгэх (замаар хэрчигдэх, хөрс урсах, гулгах)

/Газрын хэрчигдэл, овон төвөн, нух, хонхор үүсгэж, тухайн газар нутгийн үзэсгэлэнт байдлыг алдагдуулахаас сэргийлэх, замын дагуух ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөх/

- Автомашин, тээврийн хэрэгслийн дуу чимээ нэмэгдсэнээс ан амьтан дайжих, байришил тархалт нь өөрчлөгдхөх, амьдрах орон зай нь хумигдах.

/Замыг төлөвлөх, барьж байгуулахад тухайн нутаг дэвсгэрт байгаа ан амьтны тоо толгой, байришил тархалтыг тогтоох, тэдгээрийг ургж дайжихаас сэргийлэх арга хэмжээг урьдчилан төлөвлөх/

/Хөрс эвдрэх, ургамлан нөмрөг устахаас сэргийлж, түр хугацааны зэрэгцээ замыг тавьж, замын ажил дууссаны дараа түүнийг хааж, нөхөн сэргээх арга хэмжээ авах/

#### **Шурд бус налоолол**

- Зам барьж байгуулсаныг дэд бүтэц хөгжин хүн амын төвлөрөл ихэсч, хууль бус агуулур, хууль бусаар мод огтлох, бэлтгэх, тээвэрлэх үйл ажиллагаа эрчимжих
- Зам, дэд бүтцийн хөгжлийг дагаж хууль бус ан агуулур хийх явдал ихсэх, ан амьтны нөөц хорогдох, амьдрах орчин нь өөрчлөгдхөх

/Ан амьтны тоо толгой, байришил, тархалтыг тогтох тэдгээрийг хамгаалах арга хэмжээ авах, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг эрчимжүүлэх

- Биологийн төрөл зүйл өөрчлөгдхөх, нөөц нь хомсдох

/Тухайн нутаг дэвсгэрийн биологийн төрөл зүйлийн нэр төрөл, нөөцийг тогтоох, тэдгээрийг хамгаалах арга хэмжээг төлөвлөх, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг эрчимжүүлэх/

#### **Байгаль орчны чанарын өөрчлөлт**

Зам барилгын ажлын үед гадаргын болон гүний усны горим, чанарт өөрчлөлт орох, хөрсний элэгдэл, эвдрэг уүсэх, агаарын бохирдол уүсэх зэрэг шууд налеөлөл ажиглагдана.

**Байгалийн онго төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор**  
Зам барилгын ажлын үед байгалийн онго төрх өөрчлөгдхөх, карьер, нух үүсгэх, овоолго широе бий болох, ойр орчмын газрын хөрс эвдрэлд орох зэрэг шууд бөгөөд урт хугацааны налеөлөл бий болж, хүчтэй налеөлөл үүснэ. Түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор илрэх, зам барилгын ажлын үед өртөх тохиолдод холбогдох хууль тогтоомжийн дагуу хамгаалалтад авах шаардлагатай. Мен палеонтологийн судалгааг төлөвлөж буй трассын дагуу хийлгэх шаардлагатай.

#### **Эдийн засаг, нийгмийн асуудал**

Хатуу хучилгтай авто зам байгуулах нь улс орны эдийн засаг, орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэхэд чухал хувь измэр оруулаад зогсохгүй төв, орон нутгийн нүүрс тээвэр, ачаа эргэлтийг сайкруулах, хүн амыг зах зээлд ойртуулах, тээврийн хэрэгслийн эвдрэл, саатлыг багасгах зэрэг олон зэрэг талтай. Эдгээр нь шууд бөгөөд урт хугацааны зэрэг налеөлөлд хамаарна.

Авто замын төсөл нь амьтдын шилжилт хөдөлгөөнд ихээхэн налеө үзүүлж байгаа бөгөөд зам дээр зэрдэх нөхцөл үүснэ. Энэ ург хугацааны шууд бус бөгөөд урт хугацааны серег налеөлөлд хамаарна.

#### **Бусад налоолол**

Энэ төрлийн налеөлөлд газар ашиглалт болон ахуйн хаягдалтай холбогдолтой зүйлүүдийг оруулав. Зам барьж байгуулах явцад олон салса зам гарснаас орчны хөрс эвдрэх, агаарын тоосжилт ихсэх, ургамлын бүрхүүл хомсдох зэрэг налеөлөл үүснэ.

Хүчтэй задар бороо орж, карыср усанд автах, уруйн үерт автах зэрэг тохиолдол гарч, байгаль орчинд хүчтэй нөлөөлөх, уруйн үерийн гүнзгий түүсэх, зам барилгын ажил, болон байгаль орчинд ихээхэн хохирол учруулж болох талтайг анхаарч, түүнээс урьдчилан сэргийлэх буюу усны хамгаалалтын суваг, даланг байгуулж ажиллах нь зүйтэй юм.

Түүнчлэн ахуйн бохир ус, шатах тослох материал хөрсөнд нэвчих, хог хаягдал хадгалах цэгт ариутгал, хандваргүйжүүлэлт хийхгүй байх, ариун цэврийн дэглэмийг сахналгүйн улмаас эвгүй үнэр, халдварт өвчин гарах нөхцөлтэй.

### 15.2. Хог хаягдлын менежментийн зөвлөмж

Төслийн үйл ажиллагаанаас буюу зам барилгын үе шатанд ажигчдын ахуйн болон зам барилгын үйл ажиллагаанаас хатуу хог хаягдал, шингэн хаягдал, хийг хаягдал гарна.

*Ахуйн хатуу хог хаягдлыг зайлцуулах:* Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдлыг төслийн талбай дахь хог хаягдлын цэгт цуглувалж, харьяа орон нутгийн хөлбөгдох байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр цаг тухай бүрд нь хогийн нэгдсэн цэг дээр тээвэрлэн зайлцуулах шаардлагатай. Цаашид хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, хатуу хог хаягдаар орчны хөрс, агаар бохирдохос сэргийлж, ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж дахин боловсруулах цэгт тушаах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй.

*Зам барилгын ажлын үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдлыг зайлцуулах:* Техник технологийн зааварчилгаа, журмыг баримтлан ажилласан нөхцөлд битум, цементний үлдээдээ зэрэг хог хаягдал гарахгүй байх нөхцөлтэй. Зам барихад хэрэглэх элс хайрга нь бат бех зэрэг шаардагдах чанарын хувьд стандартад тохирох эсэхийг зохих газарт шинжлүүлсний дараа шаардлага хангасан материалыг хэрэглэх тул карьер болон ухманнаас гарах техникийн шаардлагад тэнцэхгүй материалын хэмжээг урьдчилан тооцох боломжгүй юм. Замын хатуу хучилт хийх битумэн зуурмагийг бэлтгэх технологи ажиллагааг хатуу баримтлах шаардлагатай байдаг бөгөөд технологийн горим андагдан техникийн шаардлага хангахгүй болсон зуурмагийг ил задгай, замбараагүй хаясан нөхцөлд тухайн талбайн хөрс, ургамлан бүрхэвчийг бохирдуулах, улмаар устгах аюултай. Санамсаргүй байдлаар ийм төрлийн хаягдал гарсан нөхцөлд уг зуурмагийг орон нутгийн хатуу хог хаягдлын цэгт гэрээ, зөвшөөрлийн дагуу зөөверлон зайлцуулах шаардлагатай.

Төсөл хэрэгжүүлэгч нь серег нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлж, арилгах хог хаягдлын менежментийн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Ажигчдын байр, сууринг барихдаа ариун цэврийн нэгдсэн цэг, бие засах газар, шингэн хог хаягдлыг хаях, хатуу хучилт хийж доторлосон тусгай нүх цооногт хийх эсвэл зөөврийн био жорлонг ашиглах. Эндээс гарах хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт анхан шатны ариутгал хийж зориулалтын машинаар зөөж зайлцуулна. Төсөл хэрэгжүүлэгч нь техник технологийн зааварчилгаа, журмыг баримтлан ажилласан нөхцөлд битум, цементний үлдээгдэл зэрэг хог хаягдал гарахгүй байх нөхцөлтэй гэдгийг сайтар анхаарах.
- Тус замын барилгын ажлын үе шатанд хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, хатуу хог хаягдаар орчны хөрс, агаар бохирдохос сэргийлж битүү зориулалтын саванд хуримтуулж, ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж орон нутгийн хөлбөгдох байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлэн зөөверлюх.

- Зам барилгын үед ашиглах талбайг үнэн зөв тогтоох, шатах тослох материал хадгалах, засвар хийх талбайг үер, галын аюулд өргөхөөргүй газарт сонгон байрлуулж, санамсаргүй тохиолдоор асарахаас сэргийлэх.
- Ахуйн бохир усыг бохир усны цооногт цуглуулах бөгөөд бохир ус хадгалах цооног нь “Ахуйн бохир усны цооногийг доторлок ашиглах журам”-ын (БО-ны, ЭМ-ийн сайдын 1995 оны 169/171 дүгээр тушаалын хавсралт) шаардлагыг хангасан байх шаардлагатай.
- Хог хаягдлыг цуглуулах зориулалтын сав, хогийн цэгийн орчмыг цэвэрлэх, цуглуулах сав байгуулах.
- Хатуу хог хаягдал нь удаан задарч, бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учир байгаль орчинд хамгийн их хор хөнөөлтэй. Иймд төслийн үйл ажиллагаанд байгальд шууд хаяхас илүүтэй хог хаягдлын менежментийн 3R /Reduce- хаягдлыг багасгах, Recycle - хог хаягдлыг дахин боловсруулах, Reuse - хог хаягдлыг дахин ашиглах/ санаачлагыг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй.
- Дахин ашиглагдах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж хоёрдогч түүхий эд хүчин авах газарт нийшуулэх нь хэрэгтэй. /Жишээ нь түүхий эдийн сав багасаа боодол/.
- Гал тогооноос гарах хатуу хог хаягдлыг болон ажилчдын өдөр тутмын хэрэглээнээс гарах ахуйн гаралтай хог хатуу хаягдлыг нэг цэгт төвлөрүүлж, ангилан ялгаж, битүүмжлэл сайтай зориулалтын төмөр саванд цуглуулж зөвлөрөгжсөн цэгт булаг орон шүүгийн засаг захиргаанаас заасан цэгт зайлцуулна.
- Хог хаягдлын зориулалтын цэгээс нэгдсэн хогийн цэгт тээвэрлүүлэхэд “MNS 5344:2011 “Ахуйн хог хаягдал тээвэрлэлт, ангилал. Ерөнхий шаардлага” стандартыг баримтална.
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах буюу хог хаягдал бага үүсгэдэг, үр яшгийн, удаан хугацаанд ашиглах боломжтой, байгаль орчинд хор хөнөөл багатай түүхий эд, бүтээгдэхүүн хэрэглэх.

Тус төслийн хэрэгжилтийн хугацаанд аль болох хог хаягдлыг бага гаргах боломжит нехцийг бүрдүүлж ажиллах ба хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад танигдсан эрх, үүргийг хүлээж, хориглюсон үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх тал дээр анхилж ажиллах.

Төсөл хэрэгжүүлэгч нь дараах **Гургийг** хүлээнэ. Үүнд:

- Энгийн хог хаягдаа ангилан ялгах / Хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, цуглуулах төрөлжүүлээн ялгах/
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх
- Эзэмшилийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршиулахгүй байх;
- Нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, месийг цэвэрлэх;
- Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, бушилах эрх бүхий иргэн, аж ахуйн изгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;

Эдгээр үйл ажиллагааг **хориглон**. Үүнд:

- Хог хаягдлыг дэд бүтцийн шугам, хоолой руу хаях
- Хог хаягдлыг ил задгай шатаах
- Хог хаягдлыг тогтоосон цэгээс бусад газарт хаях

- Хөрс бохирдуулагч жорион байгуулах
- Зууханд нийтгэг материалтай хог хаягдал шатаах
- Нийтийн эзэмшилийн хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх

#### **15.2.1. Хог хаягдлын тухай хуулийн зөвлөмж**

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 05 дугаар сарын 12-ний өдрийн чуулганы нэгдсэн хурацаанаар Хог хаягдлын тухай хуулийн Шинэчилсэн найруултыг баталсан. Тасол хэрэгжүүлэгч нь төслийг хэрэгжүүлэхдээ “Хог хаягдлын тухай хууль”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах бөгөөд тус хуулийн 10.1-д заасан **эрх**-ийг эдэлж, 10.2-т заасан **урэх**-ийг хүлээн. Мөн 10.3-т заасан үйл ажиллагаа явуулахыг **хориглоно**.

**Хүснэгт 50. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх**

Хуулийн заалт	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын <b>эрх</b>
10.1.1	Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн талаар төрийн болон нутгийн захираганы байгууллагад мэдээлэх, хариуцлага хүлээнгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах
10.1.2	Хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслаанцаа, зөвлөгөө авах

**Эх сурвалж: Хог хаягдлын тухай хуулийн Шинэчилсэн найруулахаа 10.1 дугаар заалт**

**Хүснэгт 51. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг**

Хуулийн заалт	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын <b>ПРХ</b>	Зөрчиг гаргасан тохиолдолд хүлээндэх хариуцлага
10.2.1	Энгийн хог хаягдлаа ангилан ялгах	Тус хуулийн 43.1.3-д заасны дагуу хүнийг 30 000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 000 төгрөгөөр торгоно.
10.2.2	Шаардлагыг хангасан хогийн савтай байх	
10.2.3	Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдан цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах	
10.2.4	Хог хаягдлаа зориулаалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх	Тус хуулийн 43.1.3-д заасны дагуу хүнийг 30 000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 000 төгрөгөөр торгоно.
10.2.5	Үүссэн аюулгүй хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээнгэн ехэх	
10.2.6	Нийтийг хамарсан цэвэрэгээ, иргээдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох	
10.2.7	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;	Тус хуулийн 43.1.3-д заасны дагуу хүнийг 30 000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 000 төгрөгөөр торгоно.
10.2.8	Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохицой хаях дадал зурсныг хөвшүүлэх	
10.2.9	Эзэмшилийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх	Тус хуулийн 43.1.3-д заасны дагуу хүнийг 30 000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 000 төгрөгөөр торгоно.
10.2.10	50 метр хүртэлх нийтийн зээлбэр газрын хог хаягдаа, цас, месийг цэвэрлэх	
10.2.11	Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, услаж, буулзах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах	
10.2.12	Хог хаягдлын талаарх сургалтад хамрагдаж, мэддэгээ дээшлүүлэх	
10.2.13	Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд зэлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эруул мэнд, байгаль орчинд узүүлэх	

нөлөөллийг бууруулах	
<b>10.2.14</b>	Хог хаягдлын талаарх хувь тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах
<b>10.2.15</b>	Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх
<b>10.2.16</b>	Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдэгтийг эзэмшиүүлэх, дадал зурслыг хэвшиүүлэх
<b>10.2.17</b>	Үйл ажиллагаанаас үүсж хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдан цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг харинцах үүрэг бүхий нэгж, эскуд ажилтантай байх
<b>10.2.18</b>	Аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, икуулгүй ажиллагааг хангах

*Эх сурвалж: Хог хаягдлын тухай хуулийн Шинэчилсэн найруулга 10.2 дугаар заалт*

#### **Хүснэгт 52. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хориглох үйл ажиллагаа**

Хуулийн заалт	Хориглох үйл ажиллагаа	Хүлээлгэх хариуцлага
<b>10.3.1</b>	Хог хаягдлыг дэд бутцийн шугам хоолойд хаях	Тус хуулийн 43.1.4-д заасны дагуу хүнийг 50 000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 000 төгрөгөөр торгоно.
<b>10.3.2</b>	Нийтийн здэлбэр газар, ногоон бус, үерийн дадан сувагт хог хаягдан хаях	Тус хуулийн 43.1.5-д заасны дагуу хүнийг 50 000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 400 000 төгрөгөөр торгоно.
<b>10.3.3</b>	Хог хаягдлыг ил задгай шатаах	Тус хуулийн 43.1.5-д заасны дагуу хүнийг 50 000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 400 000 төгрөгөөр торгоно.
<b>10.3.4</b>	Гэрийн болон нам даралтын галлагаанд нийтгэг материалтай хог хаягдлыг шатаах	Тус хуулийн 43.1.6-д заасны дагуу хүнийг 50 000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 000 төгрөгөөр торгоно.
<b>10.3.5</b>	Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цээзэс бусад газарт хаях	Тус хуулийн 43.1.6-д заасны дагуу хүнийг 50 000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 000 төгрөгөөр торгоно.
<b>10.3.6</b>	Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах	Тус хуулийн 43.1.7-д заасны дагуу хуулийн этгээдийг 200 000 төгрөгөөр торгоно.
<b>10.3.7</b>	Нийтийн эзэмшийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдан үүсгэх	Тус хуулийн 43.1.8-д заасны дагуу хүнийг 50 000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500 000 төгрөгөөр торгоно.

*Эх сурвалж: Хог хаягдлын тухай хуулийн Шинэчилсэн найруулга 10.3 дугаар заалт*

#### **15.2.2. Хатуу хог хаягдлыг түр хадгалах сав байгуулж, ангилан ялгах менежментийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах зөвлөмж**

Хатуу хог хаягдлыг түр хураан хадгалах зориулалтын сав байрлуулаагүй нөхцөлд төслийн талбайн орчинд хог хаягдал тархах, салхиар зөөгдөх, хөрс бохирдох нөхцөл бүрдэх бөгөөд энэ нь олон талтай серөг нөлөөллийн эх үүсвэр болно.

Хатуу хаягдан ангилан ялгах, хадгалах түр цэгийн битүүмжийнг сайжруулах, зориулалтын дагуу хог хаягдлыг ангилан ялгах хэрэгтэй (Зураг 13-15).

- Хог хаягдал түр хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгах, тэмдэгжүүлсэн байна.
- Хатуу хог хаягдлыг түр хадгалах сав, хогийн бункерт ан цав гарсан эсэхийг байнга шалгаж, хэрэв ан цав гарсан тохиолдолд тухай бүрт нь бөглөж засаж байх.

- Хог хаягдлын цэгт ариутгал, халдвартгүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийшж ойр орчмыг тогтмол цэвэрлэж байх.
- Хог хаягдлыг ангилан ялгах талаар үйлдвэрийн ажилчдад сургалт зохион байгуулах.
- Хатуу хог хаягдлын түр цэгийн байршилыг сонгоходоо салхины нослох чиглэл, газрын хэвгий, ус хангамжийн эх үүсээрийн эрүүл ахуйн бүсийн зөвшөөрөгдөх зийхээ зөргийг харгылан байрлуулах шаардлагатай.



Зураг 76. Гадаа талбайд байрлуулах хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах хогийн сав, байрны загвар

#### 15.2.3. Ажилчдын кабинтай зөөврийн био ариун цэврийн байгууламж сууринуулах зөвлөмж

“Евростандарт” био зөөврийн ариун цэврийн байгууламжийг “Мөнхийн хүндлэл” ХХК оруулж ирж Монголын хэрэглэгчдэд нийлүүлж байна. Зам барилгын ажлын үед ажилчдын ариун цэврийн байгууламжийг байгаль орчинд ээлтэй, зөөврийн био жорлонг сонгож ашиглахыг зөвлөж байна. Тус био жорлонг “Мөнхийн хүндлэл” ХХК-иас шууд захиашан худалдах авах боломжтой бөгөөд үнийн хувьд 2.6-6.8 сая төгрөгийн хооронд байна. Тус төслийн ажшиг хүчиний хүчин чадал, хэрэгжих хугацаа зөргийг харгалзан 2.6 сая төгрөгний био жорлон сонгон авахыг зөвлөж байна.

Био жорлон нь жорлонгийн суултуур, бохир хадгалах сав, шал, кабин, хувцасны өлгүүр, цаас тогтоогчоос бүрдэнэ. Жорлонгийн сууриний мод тусгай уусмалд чанагдсан тул омхийрч ялгахгүй, хорхой, шавьж, огтоно, хулгана үүрлэхгүй. Гэрээ нэвтрэдэг дээвэртэй тул дотроо саруушсан. Био 00 байгаль экологи, хүн, амьтанд хоргуй хуванцар материалыар хийгдсэн бөгөөд өнгө нь наранд гандахгүй, тоос широо, борооны ус нэвтрэхгүй болно.



Зураг 77. “Евростандарт” био зөөврийн ариун цэврийн байгууламжийн харагдах байдал

### **Ашиглалтны заавар:**

- ✓ Бохир хадгалах саванд 250 мл био бодисыг 10 л устай хольж хийнэ (зууны аагим халуунд 350-400 мл био бодис хийнэ).
- ✓ Бие зассаны дараа ус, био бодис хийхгүй.

### **Техникийн үзүүлэлт:**

- ✓ Жин: 90 кг, Бохирын сав: 250 л
- ✓ Хэмжээ: 1,2 x 1,1 x 2,4 м

### **Бохир соруулах:**

- ✓ Бохир хадгалах сав дүүрмэгц бохирыг бохирын машинаар соруулж, холбогдох цэвэрлэгээ, ариутгалыг хийнэ.
- ✓ Био00-ийг био бодисоор цэнэглэнэ.

### **Анхидрах зүйлс:**

- ✓ Био00-ийг бохир задлагч бодисгүйгээр хэрэглэж болохгүй.
- ✓ Бохирын саванд ариун цэврийн хэрэглээл, элдэв хооп хүнс, хог хийж болохгүй.
- ✓ Зууны аагим халуунд био бодисын хэмжээг нэмж хэрэглэнэ.

**Үзэсгэлийн төгрөг:**

**Худалдаалж буй байгууллага:** “Мөнхийн хүслэн” ХХК

**Холбоо барих:** 9666-5225

**Хаяг:** 32-ын аюулгүйн тойргийн зүүн талд, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн гудамж 39, “Бурд” дэлгүүр, 2-р давхарт

**Эх сургалт:** <http://bio00.brand-in-mongolia.com/> “Мөнхийн хүслэн” ХХК-ийн албан ёсны цахим хуудас  
**Холбоо барих:** 94040070

### **15.3. Агаарын чанарт үзүүлж болзошгүй сорог илрээлжийнс үрдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж**

Хатуу хучилгтай зам барьж байгуулах ажлын үед үүсэх тоос, бохирдуулагч хийн ялгаралыг багасгах, орчныг бохирдуулахгүйн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Зам тавих үед түүний ойр орчмоор олон машин явж олон салаа зам гаргуулахгүйн тулд нэгдсэн нэг замаар явах иехцэлийг хангах. /Тогтоосон маршрутын дагуу түр зам хэрэглэх эсвэл хуучин замаар явах, хучилгтай зам дээр тээвэр хийх машинны хурдыг хязгаарлах, тэмдэг тэмдэгжүүлэлтийг хийх гэх мэт/.
- Замын барилга байгууламжийн ажлын үед газар шорооны ажлыг сайтар төлөвлөн, газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн өртөх байдлыг бууруулах, шаардлагагүй газрыг эвдрэлд оруулахаас аль болох зайнсхийж, агаарт тоосжинт үүсэхээс үрдчилан сэргийлэх.
- Түүхий эд, хөрс шороог ачиж буулах, тээврлэх ажлыг аль болох агаар тогтуун, салхи багатай үед гүйцэтгэж, тоосны тархалтыг багасгах.
- Тоос ихээр үүсгэдэг түүхий эд, материалыг тээврлэхдээ бүтээлгээ хэрэглэх, олон салаа зам гаргахгүй байх, нэгдсэн нэг замаар тээвэрээлт хийх иехцэлийг бурдуулэх.
- Барилгын материал, ялангуяа нарийн ширхэгтэй материалыг далд, бүхээгтэй ачааны машинаар зөөверлэх, тоос үүсэх, асгарахаас сэргийлэх.
- Шороон далангийн шороон материалыг аль болох түргэн хугацаанд тэгшилж хайрга, буталсан чулуун үеэр хучилт хийх.

- Ажигчдын түр суурин, суурьшлын бүс орчимд болон зам барилгын ажлын талбайд тоосжилт ихсэх, стандартад заасан хэмжээнээс дахь орчныг бохирдуулах нөхцөлд тоосжилтын эх үүсвэрүүдийг бууруулах, замыг услах.
- Хайрга олборлох явцад үүсэх тоосжилтын шууд нөлөөлөлдөр өртөх талбайд ус шуршигчээр тоос дараах арга хэмжээ авах, тоосжилтоос хамгаалах өөр бусад арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Усангийн шаардлагатай зам талбайн усанганд аль болох технологийн бохир усыг цэвэршигчүүлэн дахин ашиглах, усны нөөцийн хэмнэлтийн ашиглах бодлогыг баримтлах.
- Машин механизм, техник хэрэгслийн гарах бохирдуулагч бодис бүхий хий, утааг багасгах үүднээс зам барилгын талбайд ажилд хэрэглээгүй үедээ техник хэрэгслийг унтрааж байх.
- Замын барилга байгууламжийн ажилд хэрэглэж байгаа техник хэрэгслүүдийн утга Монгол улсын болон олон улсын холбогдох стандартад нийцсэн байна. /MNS.5013:2009. Бензин хөдөлгүүртэй авто машины утгыны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт, MNS 5014:2009. Дизель хөдөлгүүртэй авто машины утгыны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт/.
- Техникийн үзлэг оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж, бохирдуулагч бодис, хий их хэмжээгээр ялгарахаас урьдчилан сэргийлэх. Замын машин техникийн үйлчилгээг хийх үед тэжээл, шатаах, хий хувсаарилах механизмын системийн хяналтын болон тохигооны ажилд онцгой анхаарах шаардлагатай. Эдгээр арга хэмжээ нь шатахууны бүрэн шатах нөхцөлийг ханган, шатахуун зарцуулалтыг багасгаж, байгальд хаягдах бохирдуулагч бодисын хэмжээг эрс багасгана.
- Тоосжилт болон агаар бохирдуулагч хийн хэмжилтийг тогтмол хийж, тухайн орчны агаарын бохирдолтыг хянаж байх.
- Тоосжилттой орчинд ажиллаж буй ажилчдад тоосноос хамгаалах хэрэгсэл олгож, хэрэглүүлж хэвшигчүүлэх.

#### 15.4. Зам талбайн тоосжилтыг бууруулах зөвлөмжүүд

Тоосжилтыг багасгах менежмент, хянах стратегиуд нь хүний эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдэнэ. Манай улсад мөрдөж байгаа тоосжилтын стандарт (MNS 4585:98) нь тоос широоны бохирдлын найрлага нь хүний эрүүл мэндэд нөлөөлөхгүй байх хэмжээнд үндэслэгдсэн (ялангуяа PM10, PM2.5 хэмжээтэй). Мөн урт удаан хугацааны турш замаас боссон тоос замын хажуу дагуух ургамлыг дараах серог иөлөөтэй байдаг. ЗГБА-ын явцад агаар дахь тоосжилтын хэмжээ сerdийн үсийнхээс буюу суурь нөхцлийс нэмэгдэж болсонгүй тул урьдчилан сэргийлэх үүднээс газар широоны ажлын явцад тоосжилт бууруулах талаар доор дурдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. **Үүнд:**

- ✓ Замын барилгын ажлын явцад ашиглаадаа талбайгаас бусад газар зам жим гаргахгүй байх, тогтсон нэг маршрутын дагуу тээвэршэлт явуулах,
- ✓ Салхи багатай одер цагнийг үр бүтээлтэй ашиглах,
- ✓ Салхи ихтэй, широон шуургатай үед далангийн широоны ачилт зөвхөрлөлтийг зогсоох,
- ✓ Дагтаршаагүй замаар явах үедээ машин техникийн хурдыг хязгаарлах,
- ✓ Барилгын материал, элс, шавар зэргийг тохиromжтой газар байрлуулах, салхинд хийсч тоосжилт үүсгэхээс сэргийлэх арга хэмжээ авах,

- ✓ Зам барилгын ажлын дууссан газрыг тоосжилтоос сэргийлж ургамалжуулах, тухай бүрд нь ихөн сэргээх
- ✓ Тодорхой давтамжтайгаар агаарыг болон газрын гадаргыг тоос босгохгүй үүднээс чийгшүүлэх,
- ✓ Бетоны тоосыг үзэх аргаар бус соруулж цэвэрлэх,
- ✓ Тоос босгодог материалыг тээвэрлэхдээ ачааг хучиж байх,
- ✓ Зам үүрний барилгын ажлын зэрэгт газрын өртөх байдлыг аль болох хязгаарлан багасгах зэрэг болно.

#### Усалгаа:

Зам барилгын ажлын явцад агаар дахь тоосжилтын хэмжээ нэмэгдэх тул сэргийшэх үүднээс ажлын явцад тоосжилт бууруулах арга хэмжээ авч байх хэрэгтэй. Тоосжилтыг бууруулахад ийн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь бутлуурыг үйлдвэр болон бусад түр замыг байнга услах, хайрга дэвсэх, тээврийн хэрэглэлийн засвар үйлчилгээ, тохицуулгыг хийх, автомашини хөдөлгүүрээс гарах угааны хэмжээг стандарт шаардлагын хэмжээнд байгавал зохино. Тоосжилт бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн даруй бургэш хөтөлж байх.

Замын тоосжилтыг багасгах мөн ихөн сэргээлтийн үед зүлэг ногоог услах зорилгоор 8-10 тн багтаамжтай, зөөлөн усалгаа хийдэг, бороожуулагч шахуургын төхөөрөмж бүхий автоцистерн ашиглахыг зөвлөж байна.



Зураг 78. 16 тн-ны багтаамжтай тоосжилт дарах усалгааны автоцистерн

#### Дастмаг:

Магни хлоридийн суурьтай DustMag нь задгай шингэн хэлбэртэй байдаг ба шууд Хэрэгжэжд тохиромжтой юм. Үүнд ямар нэг холих болон онцгой бэлтгэл шаардлагдахгүй бөгөөд усашгааны машинд шууд хийн хэрэглэгдэнэ.

- Сул широн зам
- Сайжруулсан зам
- Тоос шороо ихтэй хотын төв болон дагуул зам зэрэгт ашиглана.

Тоосжилт бууруулагчийн үйлчилгээний хугацаа нь хайрганы төрөл, замын хөдөлгөөний байдал, цаг уур зэрэг гадны хүчин зүйлүүдээс шалтгаална. Уг бүтээгдэхүүний нэг онцлог таат нь хөдөлгөөн ихтэй, ачаалалтай замд ишүү удаан тогтдог байдал юм. Хэрэв тухайн замын хөдөлгөөн багатай байвал хөдөлгөөн ихтэй замаас үр дүн багатай байна. Уг бүтээгдэхүүн нь нэмэлт усны шаардлагагүйгээр хэрэглэснээс хойш 10-14 хоног тоосжилгүй орчинг бурдуулэх юм.

- Чийгийг жигд тархаана, чийгтэг байдлыг хадгалина
- Бүтээгдэхүүний цацсанаас хойш 3 сарын турш чийгтэг байдал хадгалацдана.
- Хөрс нягтаршуулагч – шороон замыг хатуу, гөлгөр болгоно

#### Энэхүү дастмагыг хэрэглэснээр:

- Их хэмжээний ус хэмнэнэ.
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй.
- Эдийн засгийн өртөг бага



Зураг 79. Дастмагыг ашиглах төрлүүд

#### 15.5. Газрын доорх усанд үзүүлж болзошгүй сорөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний товч зөвлөмж

Зам барих технологи ажиллагаанд ихээхэн хэмжээний ус ашиглах бөгөөд усны эх үүсвэр, түүний нөөц хэмжээг авч үзэх шаардлагатай. “Омнедэлгэр-Биндэр чиглэлийн 115 км хатуу хучилттай автозам”-ын төслийн технологийн хэрэгцээний усыг авто замын зурvas орчимд гүний худаг өрөмдөн хангахаар төлөвлөсөн байна. Иймд усны эх үүсвэрийн нөөц, горимд сорөг нөлөө үүсэхгүй байх, ажил эхэхийн ёмис хатуу хучилттай авто замын барилга байгууламжид хэрэглэх усны хэрэглээний хэмжээг нарийвчлан тооцож, эх үүсвэрийг тодорхойлох, харьялагдах орон нутгийн захиргааны саналыг авч, хууль журмын дагуу холбогдох төлбөрийг төлөх шаардлагатай.

Замын барилгын ажил, далаан байгуулах, орчны тоосжигтыг бууруулах зэрэгт газрын гүний ус ашигласнаар тухайн орчмын бага гүнд орших усны түвшин тодорхой хугацаанд доосшилж хэмжээ, нөөц баガсаж болзошгүй. Ахуйн хатуу, шингэн хаягдлаас гүний усанд бохирдол үүсэх магадлалтай. Энэ нөлөөлөл нь хүний үйл ажиллагаанаас шууд хамааралтай. Газрын гүнээс усыг хяналтуйгээр авч ашиглах, бохирдсон усыг ил задгай гадаргууд замбараагүй асгах нь газрын доорх усны чанарт сергээр нөлөөлне.

Зам барилгын ажлын үед гадаргын урсцын өөрчлөлт, газрын доорх болон гадаргын усны бохирдлоос сэргийтэх дараах арга хэмжээ авах хэрэгтэй. Үүнд:

- Зам барилгын ажилд хэрэглэх усны хэрэглээний хэмжээг нарийвчлан тооцож, эх үүсвэрийг тодорхойлох, газрын доорх усны нөөц, горимд сорөг нөлөө үзүүлэхээс сэргийтэх.
- Харьялагдах орон нутгийн захиргааны саналыг авч, холбогдох хууль журмын дагуу усны төлбөрийг төлөх.
- Зам барилгын ажлын явцад шаардлагдах усыг нутгийн иргэдийн унд ахуйд хэрэглээний болон малчдын худгийг ашиглах тохиолдолд орон нутаг, худгийг эзэмшиж байгаа малчдад мэдэгдэх, саналыг авах.
- Унд-ахуйн болон үйлдвэрийнд хэрэглэх усны шинжилгээг хийшгэх, унданд хэрэглэхийн ёмис чанарын шаардлага хангаж буй эсэхийг тодорхойлуулах.
- Замын ажилд зориулсан худгийн цооногийг өрөмдөх тохиолдолд тогтсон стандартыг мөрдөх. Цооногт тогтмол засвар үйлчилгээ хийх нь худгийг удаан хугацаанд ашиглах хийгээд орон нутгийн хөрсний усны нөөцийг хамгаалахад чухал ач холбогдолтой.
- Зам ангийн ажилчдад замын дагуух худаг, булгийн усыг бохирдуулахаас сэргийтэх, зөвхөн зөвшөөрөгдсэн цэгзэс ус авч байхыг онцгойлон анхааруулах.
- Үйн ажиллагаанаас гарах бохир усыг холбогдох стандартын шаардлагад хүртэл саармагжуулалт хийж зайлцуулах, тусгай бэлтгэсэн хөрсний шуултуур бүхий нухэнд асгах, саармагжуулах.

- Нүхэн жорлонгуудад ус үл нэвчүүлэх материалын доторлогогоо хийж ашиглах, үер усанд автхаарагүй газар байгуулах.
- Гадаргын усны урсгалын нэлэөгөөр хөрс, усыг бохирдуулах бодис урсахаас сэргийлж зам барилгын талбайн орчинд цэвэрлэгээний ажлыг тогтмол зохион байгуулах.
- Хөрсөн бүрхэвчийг бохирдуулахаас сэргийлэх. Хөрс бохирдсоноор гадаргын урсацар дамжин булаг, газрын доорх ус бохирдож болзошгүй.
- Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх.
- Хортой болон аюултай бодисын тээвэрлэлтэнд Монгол Улсын Химийн хорт бодисын тухай хуульд заасан шаардлагууд, зохих журмуудыг дагаж мөрдөх. Аюултай болон хортой бодис, материалыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны болон осол аваарын үед авах арга хэмжээний дарааллыг тогтоож, түүнийг мөрдөж ажиллах.
- Зам барилгын ажилд зайншгүй гарах усны болон элсний элэгдэл эвдрэлээс үүсэх серөг нэлэөлийг сайн тооцох инженерийн барилга байгууламжид сайгар тусгах.
- Ус өнгөрүүлэх байгууламжийг булаг шанд, малчдын гар худаг бүхий орчинос зайдуу барих.
- Зам хөндлөн огтолж буй сайруудад хавар цас, мөс хайлах, зун намар эрчимшил ихтэй хур бороо орох үед богино хугацаанд урсац үүсч хур борооны үер болж болзошгүй. Иймд шинэ зам барих явцад үерийн урсац өнгөрөөх гүүр, хоолойн тооцогт уур амьсгалын өөрчлөлт, гол мөрний гамшигт үзэгдлийн давтамж, хэмжээг тооцон нарийвчлан, үерийн ус чөлөөтэй нэвтрэх, замын доод хэсгийн голын урсцыг тэтгэж байх нөхцөлийг хангах тал дээр анхаарах.

#### 15.6. Ургамлан нэмрөгт үзүүлэх серөг нэлэөлийг бууруулах арга хэмжээний товч зөвлөмж

Зам антгийн түр суурин бий болсноор тухайн орчныд хүн, машин техник холхиж, ойр орчмын ургамлан нэмрөг ихээр талхлагдах бөгөөд замын ажлыг гүйцэтгэх явцад машин техник, хүний үйл ажиллагаагаар ойр орчим талхлагдаж, зүйлийн бурдлийн унаган төрх алдагдах болзошгүй. Замд ашиглагдах хайрга, элс шорооны овоолго, түр зуурын хуримтлаа үүсгэсэн тохиолдолд тухайн орчны ургамлан нэмрөг дарагдаж талхлагдана. Ургамлан нэмрөг хамгаалах арга хэмжээ нь хөрсөн бүрхэвчийг хамгаалиж, нөхөн сэргээж байгаа арга хэмжээтэй салшгүй холбоотой. Хатуу хучилттай авто зам барих ажлаас ургамлан нэмрөгт үзүүлэх серөг нэлэөлийг хамгийн бага байлгахад дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Зам болон карьеерын талбайн онгон хөрсийг хуулж овоолго үүсгэн техникийн нялөөнөнд өртсон талбайг нөхөн сэргээхэд ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагааг календарчилсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэн, ургамалжуулах арга хэмжээ авах.
- Зам барилгын ажлын явцад олон тооны машин техник ажиллах тул тэдгээрийн хөдөлгөөний чиглэл явах маршрутыг нарийн төлөвлөж, олон салаа зам үүсгэхгүй байхыг авхааруулах, түр зам гарган ашиглах.
- Замын барилгын ажлын үед хөдөлгөөнийг хязгаарлаж, маршрут тогтоон явуулах, маршрутын биш газраар машин техник нэвтрүүлэхгүй байх.
- Төслийн талбайд их хэмжээгээр техникийн тос тослох, шатах материал асгарч алдагдсан тохиолдолд бохирдсон хөрсийг тусгайлан хуулан авч саармагжуулах, цаг тухайд нь холбогдох байгууллагад мэдэгдэн арга хэмжээ авах.

- Зам тавигдах дууссаны дараагаар тухайн замын ойр орчимд үүссэн олон туслах замуудыг нөхөн сэргээх, ургамалтуулах үүдисэс машин техник явахыг хориглосон тэмдэг тэмдэглэгээ тавьж, шаардлагатай гэж үзвэл хөндлөн шуудуу ухаан зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Нөхөн сэргээлтийг хийхдээ өнгөн хөрсний хуулалтаар үүссэн овоолго болох ургамлын үр үндэс агуулсан хөрсийг дэвсэж дээрээс нь үр цацх шаардлагатай.
- Сөрөг ишшөөнийг бууруулахын тулд замыг барьж дууссаны дараа газрыг тэгшилэн нөхөн сэргээх, зүлэгжүүлэх шаардлагатай хэсгийг ялзмагт давхарга бүхий хурааж хадгалсан үржил шимт хөрсөөр хучиж өгнө. Хучилт хийсэн хэсэгт нөхөн сэргээлтийн олон наст болон модлог ургамлыг тариална. Нөхөн тариалах ажлыг мэргэжлийн байгууллага, мэргэжлийн орошоотойгоор зохион байгуулах нь зүйтэй.

Төслийн явцад газрын хөрсний өнгөн болон доорх үе давхартыг хог хаягдлаар бохирдуулах сөрөг нэлээллөөс сэргийлэх.

## БҮЛЭГ 16. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан агуулга бүтэцтэй байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь доорх үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна. Үүнд:

- Төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ);
- Төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүх л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс (ОХШХ) бүрдэнэ.

Байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон төслийн серег нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө, химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын (явцын) төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө, түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүний нөөц, байгаль орчны удирдлагын бүтэц зохион байгуулалтын схем, газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын төслийн хувьд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, уул уурхайн төслийн хувьд хаалтын зорилт, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө орно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийн болон үр дагаврын тархалтын хүрээнд нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн, үзүүлэлтүүдийг тодорхойлж, тухайн орчноос дээж, сорыц авах, хэмжилт хийх, түүнд дун шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, шинжилгээ хийх давтамж, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.

**16.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний ажил (урьдчилсан байдлаар тооцов.)**

**Хүснэгт 53. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал**

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт хугацааны зардал, мян.төг
1	Зам тавих үед түүний ойр орчмоор олон машин явж олон салаа зам гаргуулахгүйн тулд нэгдсэн нэг замаар явах нехцөлийг хангах. /Тогоосон маршрутын дагуу түр зам хэрэглэх эсвэл хуучин замаар явах, хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлах, тэмдэг тэмдэгжүүлэлтийг хийх гэх мэт/.	2,000,000
2	Тоос ихээр үүсгэдэг, нарийн ширхэгтэй түүхий эд, материалыг тээвэрлэхдээ бүтээлэг хэрэглэх	2,000,000
3	Тоосжилттой орчинд ажиллаж буй ажилчдад тоосноос хамгаалах хэрэгсэл олгож, хэрэглүүлж хэвшүүлэх	6,390,000
4	Техникийн үзлэг оношилгоо, засвар үйлчилгээг тогтмол хийж, бохирдуулагч бодис, хий их хэмжээгээр ялгарахаас урьдчилан сэргийлэх	2,000,000
5	Зам барилгын ажлын үед ялгарах тоосжилтыг багасгах, дарах зориулалтаар дастмаг, усалгаа хийх	30,000,000
6	Зам барилгын ажил, бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой үүсэх тоосны нөлөөллийг хянах, тоосны хэмжилт судалгаа хийх	2,000,000
<b>Дүн</b>		<b>44,390,000</b>

Тайлбар: Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал 44,390,000.0 төгрөг байна. Дээрх үнийн дун тогтсон үнэ биш бөгөөд тухайн үеийн хийгдэх ажил, бараа материалын үнэ ханиш зэргээс хамааран хэлбэлзэж болно.

**Хүснэгт 54. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал**

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт хугацааны зардал, мян.төг
1	Ахуйн хатуу хог хаягдал болон зам барилгын ажлын үед гарах хог хаягдлыг хадгалах зорилгоор стандартын дагуу хогийн цэг байгуулах, хашаажуулах, зориулалтын газар байршуулах	1,500,000
2	Зам байгуулалтын үед шингэн хог хаягдлын зориулалтын цэгийг байгуулж ашиглах, эко ариун цэврийн байгууламж	16,000,000
3	Машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулах, талбайг зориулалтын дагуу байгуулах	20,000,000
4	Замын бүтээн байгуулалтын ажлыг явуулах хязгаарлалтын бүсийг тогтоох, тэмдэгжүүлэх (Бат бэх тууз татах, тэмдэгжүүлэх)	1,300,000
5	Карьерт хүн, мал, ан амьтан унахаас сэргийлэх арга хэмжээ авах, хамгаалалт хийх	2,500,000
6	Үржил шимт хөрсний ашиглалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд шимт хөрсний хуулалт, хадгалалт, ашиглалтын талаар мэргэжлийн заавар, зөвлөгөө гаргаж таниуулан түүний биелэлтэд хяналт тавьж ажиллах	1,500,000
7	Байгаль орчинд гарч болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг бууруулж, байгаль орчныг хамгаалах зорилгоор ажилчдад зааварчилгаа өгөх сургалт явуулах	1,800,000
8	Хөрсний бохирдоос хамгаалах зорилгоор бүх ажилчдад үйлдвэрийн болон ахуйн хэрэглээний аюултай материал (химийн бодис, шатамхай хий, тэсрэх бодис, шатах, тослох материал)-тай харьцах асуудлаар цогц сургалт, зааварчилгаа явуулах	1,000,000
9	Барилгын ажлын талбай дахь хатуу хог хаягдлыг цуглувалж, зохих журмын дагуу зайлцуулж, устгалд оруулах	3,000,000

	<b>Дүн</b>	<b>47,100,000</b>
--	------------	-------------------

Тайлбар: Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний нийт зардал 37.1 сая төгрөг байна. Дээрх үнийн дун тогтсон үнэ биш бөгөөд тухайн үеийн хийгдэх ажил, бараа материалын үнэ ханш зэргээс хамааран хэлбэлзэж болно.

**Хүснэгт 55. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал**

Д/д	<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Нийт хугацааны зардал, төг</b>
1	Байгуулалтын явцад үүсч болзошгүй ундны усны эх <b>үүсвэрүүдийг хамгаалах үйл ажиллагаа явуулах</b>	7,000,000
2	Тоос дарах арга хэмжээнд байгалийн цэвэр усны нөөцийг ашиглахаас аль болох татгалзах, бусад аргаар орлуулах, задгай талбайгаас тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэх, усалгаа шаардлагатай зам талбайн усалгаанд аль болох технологийн бохир усиг цэвэршүүлэн дахин ашиглах, усны нөөцийн хэмнэлттэй ашиглах бодлогыг баримтлах	100,000,000
	<b>Дүн</b>	<b>107,000,000</b>

Тайлбар: Усан орчинг хамгаалах нийт зардал 107.0 сая төгрөг байна. Дээрх үнийн дун тогтсон үнэ биш бөгөөд тухайн үеийн хийгдэх ажил, бараа материалын үнэ ханш зэргээс хамааран хэлбэлзэж болно.

**Хүснэгт 56. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал**

Д/д	<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Нийт хугацааны зардал, төг</b>
1	Тухайн орчинд тохиолдох, экологийн ач холбогдол бүхий ховор, нэн ховор ургамлын зураг, тайлбарыг ажилчдад үзүүлж, таниулах сургалт зохион байгуулах	3,000,000
2	Машин, замын хөдөлгөөн нь ургамлын бүлгэмдлийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх тул тусгайлан замын сүлжээг урьдчилан тодорхойлж, зураг схемээр харуулан түүгээр явуулж хэвшүүлэх	1,000,000
3	Карьерийн нөхөн сэргээлтэд нутгийн эндемик ургамлыг таримжуулахад онцгойлон анхаарч, түүний үрийг цуглуулах ажлыг зохион байгуулах	150,000,000
4	Байгаль орчны хяналтын хүрээнд мэргэжлийн баг судлаачидтай хамтарч ажиллаж, зэрлэг ан амьтны гарц гарам байгуулах цэгүүдэд амьтдыг гармаар гарах нөхцлийг бүрдүүлэн тарималжуулах	50,000,000
	<b>Дүн</b>	<b>204,000,000</b>

Тайлбар: Хүснэгт 42. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний нийт зардал 204.0 сая төгрөг байна. Дээрх үнийн дун тогтсон үнэ биш бөгөөд тухайн үеийн хийгдэх ажил, бараа материалын үнэ ханш зэргээс хамааран хэлбэлзэж болно.

**Хүснэгт 57. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал**

Д/д	<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Нийт хугацааны зардал, мян.төг</b>
1	Ан амьтныг судлах, хамгаалах, хяналт тавих талаар сумдын удирдлага, нутгийн ард иргэд, амьтан судлаачидтай хамтран ажиллах	30,000,000
2	Замын трассын орчимд тохиолдох ховор, нэн ховор болон экологийн ач холбогдол бүхий амьтдын фото зураг, холбогдох мэдээллийг цуглуулж, мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авч, байгаль орчны менежментийн хетэлбөрийн төлөвлөгөөг танилцуулах үед ажилчдад танилцуулах, тэдгээрийг хамгаалах,	2,000,000

	тоо толгойг нэмэгдүүлэх арга хэмжээг орон нутгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	
3	Төлөвлөж буй авто замын трассын орчим дахь ховор, нэн ховор болон экологийн ач холбогдол бүхий амьтдын амьдрах орчин, зүйлийн бүрдэл, тоо толгой, шилжилт хөдөлгөөн, мөн авто замын ачаалал, гэрийн малын байршил болон нийгмийн судалгааны үр дүнд үндэслэн, шаардлагатай газруудад /MNS 6515:2015. Тал хээр, говь цөлийн бусийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтадад зориулсан гарц. Ерөнхий шаардлага/ стандартын дагуу зэрлэг амьтан болон мал чөлөөтэй нэвтрэх гарц, гармыг байгуулах, тэмдэгжүүлэх.	Замын бүтээн байгуулалтын зардалд тусгагдана.
4	Карьер болон барилга байгууламж барихаар төлөвлөж ухсан хоосон нүхэнд мал амьтан орж үхэхээс сэргийлж, хашаажуулах, тэмдэгжүүлэх	2,000,000
5	Ажилчдын суурингийн орчинд хогийн цэг дээр амьтан тэжээл хайж ирэх, орогнох, үүрлэх нөхцөл үүсгэхгүй байх, ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдлаас мал, амьтан хордохос сэргийлэх арга хэмжээ авах, хог хаягдлыг цаг тухай бүрт зайлцуулж байх	1,500,000
	<b>Дүн</b>	<b>35,500,000</b>

Тайлбар: Амьтан хамгаалах нийт зардал 235,500,000.0 сая төгрөг байна. Дээрх үнийн дүн тогтсон үнэ биш бөгөөд тухайн үеийн бараа материалын ханш болон хийгдэх ажлаас хамааран хэлбэлзэж болно.

#### Хүснэгт 58. Байгаль орчин хамгаалах ажлын зардлын задаргаа

Д/д	Зардлын нэр	Дүн, мян.төг
1	Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	44,390,000
2	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал	47,100,000
3	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал	107,000,000
4	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал	204,000,000
5	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зардал	35,500,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	27,500,000
	<b>Дүн</b>	<b>465,490,000</b>

Тайлбар: Төслийг хэрэгжүүлэгч нь тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 465,490,000 (дөрвөн зуун жаран таван сая дөрвөн зуун ерөн мянган) төгрөг ба үүнд 5 жилийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал багтсан болно.

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

“Өмнөдэлгэр-Биндэр чиглэлийн 115 км хатуу хучилттай автозам” төслийн талбайн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ судалгааны ажлын хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төлөвлөж буй замын трасс нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт сумдын нутаг дэвсгэрийг дайран өнгөрөх бөгөөд тус бүс нутаг нь цаг уур, уур амьсгалын мужлалтаар чийглэгдүү хүйтэвтэр зунтай бүсийн, хахир өвөлтэй мужид хамаарна. Судалгааны зурvas нутаг дэвсгэр нь байрлалаар дэлхийн бөмбөрцгийн хойт хагасын дундад өргөрөгт багтдаг учир эх газрын эрс тэс уур амьсгалтай байдаг. Судалгааны талбай нь Монгол орны авто замын уур амьсгалын бүсчлэлээр Ойт хээр (ПА)-ийн бүсийн Орхон-Сэлэнгийн ойт хээрийн хахир дэд бүсэд хамаарах бөгөөд олон жилийн цэвдэг чулуулаг ховор алаг цоог таржсан бүслүүрт байх ба улирлын хөлдөлт-гэсэлттэй, хүйтний овойлттой болон суумтгай, лёсс маягийн хурдас элбэг тохиолдох онцлогтой. Ойт хээртээ цасархаг, цас борооноос намаг шавар их үүсдэг, хахир хүйтэн жаварлаг хөрс чулуулаг нь гүн хөлддөг бүс юм.
- Төсөл хэрэгжих талбайд хийсэн агаарын чанарын хэмжилтийг “Мон Газар Экологи” ХХК-ийн мэргэжилтнүүд 2021 оны 11-р сарын 20 өдөр хийж гүйцэтгэв. Төлөвлөж буй замын трассын дагуу төсөл хэрэгжихээс өмнөх агаарын чанарын хэмжилт, судалгааг нийт 6 цэгт хийж, үр дүнг боловсруулав. Тухайн төслийн талбайн агаарын чанарын төлөв байдлыг тодорхойлоход тодорхой хугацааны давтамжтай олон удаагийн хэмжилт судалгааны үр дүн шаардлагатай байдаг бөгөөд тус төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажлын хээрийн судалгааны хүрээнд 2021.11.20 өдрийн 12:30-16:30 минутын үед цэг тус бүр дээр 1 удаагийн 10 минутын хугацаатай тоос, тоосонцор, дуу шуугианы хэмжилтийг хийв. Агаарын чанарын цэгүүдийн орчны нөхцөл нь өөр хоорондоо ойролцоо, ойр орчмын хөрс ургамал бүрхэвчгүй халцгайг эс тооцвол цэгүүдийн орчим ямар нэг агаар бохирдуулах эх үүсвэр байхгүй. Хээрийн судалгааны үеэр агаарын температур  $-11^{\circ}\text{C}$ - $(-16^{\circ}\text{C})$  хүйтэн, салхи 5-7 м/с ны хурдтай, цас орсон, цаг агаар тогтуун байсан тул шороон зам дагуу тоосжилт үүсэх нөхцөлгүй байсан. Агаар орчны чанарын хэмжилт хийж, үр дүнг боловсруулахдаа Монгол улсад мөрдөгдөж байгаа стандартад, аргачлал болон багажит шинжилгээний аргыг ашиглан агаар бохирдуулагчийг тодорхойлсон. Агаарын чанарын хэмжилтийг хийхдээ агаарын чанарын хяналт шинжилгээний хугацаат ажиглалтын горимоор хэмжилт хийн холбогдох стандартуудтай харьцуулах, агаарын чанарын индексээр үнэлэх зэрэг аргыг ашиглав. Замын трассын дагуу хийсэн агаарын чанарын хэмжилтийн дунгээр төслийн талбайд Монгол улсын агаарын чанарын стандарт болох MNS 4585:2016 стандартыг давсан агаар дахь бохирдуулагч бодис байхгүй, төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага гэж үзэж байна. Хэмжилтийн үр дунгээс харахад агаар дахь том ширхэглэгт тоосонцор 4.0-5.7 мкг/ $\text{m}^3$ -ийн хооронд, нарийн ширхэглэгт тоосонцор 2.9-4.1 мкг/ $\text{m}^3$ -ийн хооронд буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс хэд дахин бага үзүүлэлттэй байна. Замын трассын төгсгөл цэг буюу Хэнтий аймгийн Биндэр сумын төвд хийсэн хэмжилтийг шороон зам дээр хийсэн бөгөөд автомашины хөдөлгөөн ихтэй үед том ширхэглэгт тоосонцор 89.0-114.1 мкг/ $\text{m}^3$ -ийн хооронд, нарийн ширхэглэгт тоосонцор 60.5-76.8 мкг/ $\text{m}^3$ -ийн хооронд буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан, бага бохирдолтой байсан. Шороон замаас бусад цэгт хэвийн байна. Хэмжилт хийсэн бүх цэгүүдэд орчны дуу шуугианы төвшин хэвийн байна.

- Төсөл хэрэгжих талбай нь бүхэлдээ эзгүй хээр талд байрлах тул дуу чимээний нөлөөлөл бага байх төлөвтэй байна. Монгол улсын “MNS 4585:2016. “Агаарын чанарын стандарт. Техникийн шаардлага” стандартад зааснаар дуу шуугианы хэмжээ өдрийн цагаар (07-22 цаг) 50 дБа, шөнийн цагт (22-07 цаг) 45 дБа-аас илүүгүй байх ёстой байдаг. Орчны дуу шуугианы төвшин хэмжилт хийсэн бүх цэгүүдэд хэвийн байна.
- Төлөвлөж буй замын трасс нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр сумдын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн дайран өнгөрөх бөгөөд тус бус нутаг нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хэнтийн мужийн Хэнтийн зүүн тойротг хамарагдана. Төсөл хэрэгжих зурvas газар нь Монгол орны хөрсний ангилалаар уулын ойн, уулын хээрийн, тал хөндийн болон голын татмын хөрсний бүлэгт хамаарах уулын ойн нугархаг, уулын ойн ширэгт бараан хөрс, уулыг хархүрэн, уулын хүрэн, далд глейрхэг хар шороон хөрс болон аллювийн нутын хөрс тархсан байна. Тус замын трассын дагуу нийт 6 цэгт дээж авч хээрийн бичиглэл хийв. Хөрсний хими, физик шинж чанар болон хөрсөнд агуулагдах зарим хүнд металлын агууламжийг тодорхойлуулах зорилгоор дээжүүдийг “Грийн лаб” ХХК-ийн Хөрс судлалын лабораторид шинжлүүлэв. Хөрсний шинжилгээний үр дүн болон хээрийн бичиглэл зэрэгт тулгуурлан хөрсний хими физик шинж чанар, онцлог зэргийг бичив.
- Төлөвлөж буй замын трассын дагуу олон салаа шороон зам үүссэн бөгөөд гуу жалга, үер усны элэгдэлд орсон, эвдэрсэн, уул уурхайн үйл ажиллагаагаар үүссэн нух, ухаш байхгүй байна. Төсөл хэрэгжих зурvas газар нь Монгол орны хөрсний ангилалаар уулын ойн, уулын хээрийн, тал хөндийн болон голын татмын хөрсний бүлэгт хамаарах уулын ойн нугархаг, уулын ойн ширэгт бараан хөрс, уулыг хархүрэн, уулын хүрэн, далд глейрхэг хар шороон хөрс болон аллювийн нутын хөрс тархсан байна. Тус хөрсний хэвшинж бүрээс төлөөлүүлж 6 цэгт дээж авсан бөгөөд хөрсний лабораторийн задлан шинжилгээний үр дүнг эдгээрийн хими, физик шинж чанартай харьцуулахад хэвийн буюу шинж чанар өөрчлөгдөөгүй байна.
- Археологийн хайгуул судалгааны явцад замын трассын дагуу нийт 41 дурсгал илрүүлж бүртгэсэн байна. Замын трассын дагуу илрүүлэн бүртгэж баримтжуулсан нийт дурсгалууд нь хатуу хучилттай зам тавихаар төлөвлөж буй замын трассын голын шугамаас 0-154 м зайд байрлана.
- Замын трассын Хэнтий аймгийн Батширээт сумын нутгийг дайран өнгөрөх зурvas талбай нь Улсын тусгай хамгаалалттай газар нутаг болох *Биндэръя хан уулын Дурсгалт газартай давхцаж* байна. Хамгийн ойр орших улсын тусгай хамгаалалттай газар нутаг нь төслийн талбайгаас баруун хойш 54 км орчим алслагдах *Хан Хэнтийн Дархан цаазат газар*, зүүн хойш 50 км орчим зайд орших *Онон-Балжийн Байгалийн цогцолборт газар*, баруун урагш 76 км зайд *Хангай нурууны Дурсгалт газар* юм.
- Замын зурvas газар нь Хэнтийн аймгийн Өмнөдэлгэр сумын Төвийн 6-р баг, Хэнтий 3-р, Батширээт сумын Хурх 3-р баг болон Биндэр сумын Мандалхаан 2-р баг, Онон 5-р багуудын нутаг дэвсгэрийг дайран өнгөрнө. Тус төслийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хээрийн судалгааны үеэр замын трассын дагуу 33 малчдын өвөлжөө, намаржааны газартай тааралдаж, эдгээрийн газарзүйн солбилцолыг тэмдэглэж, фото зургаар баримтжуулав.
- Төлөвлөж буй авто замын зурvasын газар нь гадаргын усны сүлжээний хувьд Хойд мөсөн далайн ай савд хамаарах бөгөөд Онон, Хэрлэн голын сав газарт багтана.

Замын трасс нь Хурхын голын баруун хойд хэсгээр 50-9224 м-ийн алслагдан дайран өнгөрөх ба байнгын урсацтай Жаргалантын гол, Баян гол, Навчийн гол, түр урсацтай Зүүн зүртийн гол, Жаргалантын булаг, Чандмань гол, Тэнгэлийн гол, Бор булаг, Өглөгчийн гол зэрэг голууд урсана. Трассын дагуу Айраг нуур, Ар нуур, Холбоо нуур, Шар нуур, Биндэр нуур, Баян нуур, Булангын нуур, Цагаан нуур болон нэр нь тодорхойгүй 7 давс нуурууд байна. Баян булаг, Жаргалантын булаг, Баруун хогнийн булаг, Залаагийн булаг, Өгөөмөрийн булаг, Бор булаг, Чулуут булаг, Урт булаг, Талын булаг зэрэг 20 орчим булаг, шанд тааралдана. Замын трасс нь Хурх, Жаргалант голуудын уулзвар, Хурхын их хөндий, Хурх-Зүүнбаянголын уулзвар, Хурх-Баян голын уулзвар зэрэг өргөн хөндийн даган байрлаж байна.

Тус хатуу хучилттай зам барих төсөл нь Хэнгийн аймгийн Өмнөдэлгэр, Биндэр сум зэрэг суурин газруудыг хатуу хучилттай замтай холбосон хүн амын нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой төсөл юм.

Тус төслийн хүрээнд зам барилгын ажлын явцад хүрээлэн буй орчин, байгалийн хам бүрдэлд тодорхой хэмжээгээр нэлөөлөх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд үүний дотор хөрс, ургамлан бүрхэвч болон амьтны аймгийн төлөв байдалд бусад хам бүрдлээс илүүтэй сөрөг нэлөө узүүлж болзошгүй гэж үзэж байна. Иймд цаашдын үнэлгээгээр төслийн бүтээн байгуулалтын үед үүсэх байгаль орчинд нэлөөлөх эрсдэлийг бүрэн тооцох, замын хөдөлгөөнөөс тухайн нутгийн биологийн олон янз байдалд сөргөөр нэлөөлөх байдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөж, авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

“Өмнөдэлгэр-Биндэр чиглэлийн 115 км хатуу хучилттай автозам” төсөл нь техникийн хувьд хэрэгжих нөхцөл бүрдсэн, нийгэм, эдийн засгийн талаас ач холбогдол бүхий, байгаль орчинд сөрөг нэлөөлөл багатайгаар хэрэгжүүлж болох төсөл юм. Тус төслийг хэрэгжүүлэхдээ Монгол улсын холбогдох хууль, стандарт, эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллаж, байгалийн хам бүрдлүүдэд үзүүлж болзошгүй нэлөөллүүдийг анхааран үзэж, байгаль орчныг хамгаалах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж байх нь зүйтэй.

Төслийн зүгээс үйл ажиллагаагаа явуулж буй газар нутгийнхаа байгаль орчныг хамгаалах ажлыг орон нутгийн байгууллагууд, нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлэх нь илүү цогц, ач холбогдолтой арга хэмжээ болохыг анхаарч ажиллах нь зүйтэй.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дүгээр тушаалаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”. /1-р хэсэг. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийх аргачлал/
2. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2010 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А-2 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар”. 2010.
3. Инженер геодезийн урьдчилсан тайлан
4. Дэ Нэйче Консерванси (TNC), Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF), Зэрлэг Амьтдыг Хамгаалах Нийгэмлэг (WCS), Мерси Корпс., Экологийн бүс нутгийн үнэлгээний тайлан, Монгол орны өмнийн.govийн бүс нутагт хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь. 2013 он.
5. ШУА. Газарзүйн хүрээлэн. Монгол улсын үндэсний атлас. УБ. 2009.
6. Мягмарсүрэн Д., Энэбиш Д., Намхай А., Монгол улсын дархалсан газар нутгууд. УБ. 2007 он.
7. БОАЖЯ. Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2015-2016 он. УБ. 2017.
8. Нийгэм, эдийн засгийн хөгжилд байгалийн нөхцөл, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалzan үзэх нь. Олон улсын 3 дугаар бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. I боть. УБ. 2017.
9. Шагдар Ш. Монголын газарзүйн нэрийн толь бичиг. УБ. 2007 он.
10. Доржготов Д. Монгол орны хөрс. УБ. 2003.
11. Монгол орны цөлжилтийн атлас. УБ. 2013.
12. Монгол орны элс. Баасан Т. УБ. 2003 он.
13. БОНХЯ. Монгол улсын улаан ном. УБ. 2014.
14. Дугаржав Ч., бусад. Монгол орны ашигт ургамлын тархац нөөцийн атлас. УБ. 2014.
15. Ургамал М., Санжид Ж. Монгол орны гуурст ургамлын тархалтын өнөөгийн байдал. Судалгааны бүтээл.
16. Монгол орны бэлчээрийн түлхүүр зүйл ургамлын зурагт лавлах. УБ. 2015 он.
17. Батсайхан Б., Самьяа Р., Шар С., Кинг С.Р.Б., Монгол орны хөхтөн амьтад таних гарын авлага. УБ. 2010 он.
18. Монгол улсын үндэсний статистикийн хороо. Хэнтий аймаг Статистикийн товчоон. УБ. 2020.
19. Монгол улсын хуулиуд
20. Монгол улсын стандартууд
21. Байгаль орчны мэдээллийн сан.

# **ХАВСРАЛТ**



"GREEN LAB" LLC



### ХӨРС СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИ

Министерство Экономики и Развития Регионов  
Од-нр. №: Канцелярия №100/12 тоот  
Улан-Удэ, 727000, Монголия  
Телефон: +993 31 880000

Дээж ирсэн огноо: 2021.11.22-25

№ 21/4321

Шинжилгээнийгэж буй байгууллага, хувь хувь: "Мон Газар Экологи" ХХК

Холбоо барих дугаар: 70115720, 9905 5720

Дээж явсан газар: Хэнтий аймаг Омнөдэлгэр сумын нутаг "Омнөдэлгэр-Биндэр зам" төсөл

#### Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дээжийн нэр	Гүйн, см	Механик шархтуул, % шархгийн юмжээ, мм							
				≤0.25	0.25-0.5	0.5-0.9	0.9-1.5	1.5-0.005	0.005-0.001	0.001-0.0005	>0.01
1	21/6231	Хөрс-1	0-30	9.7	21.8	48.8	3.0	12.4	4.4	19.8	

#### Хөрсний хунд металыг

№	Лаб №	Дээжийн нэр	Гүйн, см	Хунд металыг мг/кг					
				Ni /Никель	Cd /Кадмий/	Pb /Хар тугалга/	Cu /Зөслөн/	Zn /Цинк/	Sr /Хром/
1	21/6231	Хөрс-1	0-10	34.5	-	1.4	15.8	81.4	7.9
		Шавранцар хөрсний зөвшөөрөгдхөд дээж хэмжээ		100.0	1.5	70.0	80.0	150.0	100.0
		Элсэнцэр хөрсний зөвшөөрөгдхөд дээж хэмжээ		60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0
		Элементүүдийн зөвшөөрөгдхөд дээж хэмжээ стандарт							/MNS 5850:2019/

Жичт: Шинжилгээний гарни нь зөвхөн тухайн ногийн эзжинд тэмдэгэш ба түүнтэй ошруулахыг хориглоно.

Шинжилгээ хийснэг арга стандарт:  
(MNS 6824:2020 MNS ISO 11466:2007 )

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН. Шинжээч  
Шинжээч: Т. Гэрэлтуяа  
С. Мягмардаш

ХЯНАСАН: Лабораторийн эрхийнч Гарнимог /MS с/





"GREEN LAB" LLC

**ХӨРС СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИ**

Монгол Улс, Улаанбаатар, Чингисийн дүүрэг  
№ 100, Ноготын бийрхчийн 10 дэвсүүр 02 тоо  
Утасны нийт: +976 11 388 5020  
Email: lab@greenlab.mn; greenlab.mn

Дээж ирсэн огноо: 2021.11.22-25

№ 21/4320

Шинжилгээний хийгэж буй байгууллага, хувь хувь: "Мон Газар Экологи" ХХК

Холбоо барих дугаар: 701 15720, 9905 5720

Дээж авсан газар: Хэнтий аймаг Омнөдэлгэр сумын кутаг "Омнөдэлгэр-Биндэр зам" төсөл

**Хөрсний химийн залган шинжилгээний дун**

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	pH	Давс., %	ЦДЧ	CO <sub>2</sub> , %	Язэмжгээ, %	Шингээгдсэн сууринд, мг-экв/100 гр			Шим тэжээлийн залган шинжилгээний дун	
									Ca+Mg	Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	21/6229	Хөрс-2	0-30	7.45	0.02	0.036	0.00	5.95	38.0	36.2	1.8	4.8	23
2	21/6230	Хөрс-3	0-30	7.80	0.02	0.034	0.00	6.01	30.1	27.8	2.3	4.6	23

**Хөрсний механик бүрэлдхүүн**

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширэгтүүд, % ширэгийн эмжээ, мм							
				1-25	26-50	51-60	61-70	71-80	81-90	91-95	<95
1	21/6229	Хөрс-2	0-30	35.8	40.5	1.3	9.0	5.4	8.0	22.5	
2	21/6230	Хөрс-3	0-30	47.6	24.4	1.3	18.5	4.3	3.8	26.7	

Жич: Шинжилгээний харин нь зөвхөн тухайн тогийн дээжийн хамаарах ба хувилан олшируулахыг хориглоно.

Шинжилгээний хийсэн арга стандарт:  
(MNS3310:1991, MNS 6824:2020 )

Шинжилгээний гүйцэтгэсэн: Шинжээч:  
Шинжээч:

Т. Гэрэлтуяа  
С. Мягмардаш

ХЯНАСАН:

Лабораторийн эрхийнч

Г. Ганчимэг /MS.c/



"GREEN LAB" LLC

**ХӨРС СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИ**

Монгол Улс, Улаанбаатар, Чингисийн дүүрэг  
Түүхийн 10 хороо, Ногойт 10 тал, №2-гоо  
Телефон: +976 9220 8895/8810  
Email: landownermn@gmail.com



**Дээрх ирээн ойноо:** 2021.11.22-25

**№ 21/4322**

**Шинжилгээний хийгдэж буй байгууллага, түүвр хувь:** "Мон Газар Экологи" ХХК

**Холбоо барих дугаар:** 70115720, 9905 5720

**Дээрх авсан газар:** Хэнтий аймаг Бийнээр сумын нутаг "Өмнөдэлгэр-Бийнээр зам" төсөл

**Хорсний хийгдэж буй шинжилгээний дун**

№	Лаб №	Дээжний иэр	Гүй см	рН	Давс, %	ЦДЧ	CO <sub>2</sub> , %	Язмаг %	Шинжилгээний суурин, мг-экв/100 гр			Шим тэжээлийн элемэнтүүд мг/100 гр	
									Ca+Mg	Ca	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	21/6232	Хорс-4	0-30	8.15	0.04	0.090	3.29	1.28	17.1	13.1	4.0	1.2	15
2	21/6233	Хорс-5	0-30	8.21	0.02	0.042	0.00	2.05	16.2	13.0	3.2	2.2	20

**Хорсийн механик бүрэлдэхүүн**

№	Лаб №	Дээжний иэр	Гүй, см	Механик ширхэгчүүд, % ширхэгийн эзэмсэг, мм							
				1-25	0.25-0.5	0.5-1	1-0.01	0.01-0.005	0.005-0.001	0.001-0.0001	>0.0001
1	21/6232	Хорс-4	0-30	47.6	24.4	5.3	14.5	4.3	3.8	22.7	
2	21/6233	Хорс-5	0-30	25.2	50.0	3.7	12.0	4.6	4.4	21.0	

Жич: Шинжилгээний харин нь зөвхөн тухайн ногийн хээжиний камаарах ба хувилан олшируулахыг хөриглөө.

**Шинжилгээний хийсэн арга стандарт:**  
(MNS3310:1991, MNS 6824:2020 )

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН: Шинжээч:  
Шинжээч:

*Т.Гэрэлтуяа  
С.Магмардаш*

ХЯНАСАН:

Лабораторийн эрх/эзга

*Т.Ганчимэг /MS.c/*



"GREEN LAB" LLC



**ХӨРС СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИ**

Монгол Улс, Улаанбаатар, Чингисийн ш. №10  
Телефон: +976 11 330 002  
Телефон: +976 995 5720  
Сайт: landowner.mn

Төхжирсан огноо: 2021.11.22-25

№ 21/4323

Шинжилгээ хийлгэж буй байгууллага, түүвр дунд: "Мон Газар.Экологи" ХХК

Холбоо барих дугаар: 70115720, 9905 5720

Төхж авсан газар: Хэнтий аймаг Бийндер сумын нутаг "Омнодэлгэр-Бийндер зам" төсөл

**Хөрсний механик бурулдэхүүн**

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, си	Механик шархтууд, % шархгийн эзмжээ, мм							
				≤0.25	0.25-0.05	0.05-0.01	>0.01	≤0.005	0.005-0.001	0.001-0.0005	>0.0005
1	21/6234	Хөрс-6	0-30	29.7	47.7	3.1	10.7	8.6	0.2	19.5	

**Хөрсний хүнд металы**

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель	Cd /Кадмий	Pb /Хар тугалга/	Cu /Зинк/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	21/6234	Хөрс-6	0-10	15.0	-	0.7	9.4	14.8	20.1
		Шавранцар хөрсний зөвшөөрөгдхөд дээд хэмжээ		100.0	1.5	70.0	80.0	150.0	100.0
		Элсэцэр хөрсний зөвшөөрөгдхөд дээд хэмжээ		60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0
		Элементүүдийн зөвшөөрөгдхөд эзээ эзмжээ стандарт							/MNS 5850:2019/

Жич: Шинжилгээний харшуу нь зөвхөн тухайн цээгийн дээжинд хамаарах ба хувилан олшируулжын  
коригцлон.

Шинжилгээ хийсэн арга стандарт:  
(MNS 6824:2020 MNS ISO 11466:2007 )

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭГЭСЭН: Шинжээч  
Шинжээч:

Т. Герэлтуяа  
С. Мягмардаан

ХЯНАСАН: Лабораторийн эрхэгч

Г. Ганчимэг /MS.c/



**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИ  
ХООЛ СУДЛАЛ, ШИМ ТЭЖЭЭЛИЙН ЛАБОРАТОРИ**

Хаяг: Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг, Энхтайваны хороо чөлөө-17.  
Утас: 979-11-452772

**СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС № 212**

Дээж ирүүлсэн байгууллага	Дээжийн нэр, хэмжээ	Дээжийн тодорхойлолт /шаардлагатай бол/	Дээж авсан огноо	Дээж ирүүлсэн огноо
"Мон газар экологи" ХХК	1.5 л	Полиэтилен саванд савласан худгийнус гэх	2021.11.20	2021.11.23

Шинжилгээ эхэлсэн огноо	Шинжилгээ дууссан огноо	Дүнгийн хуудас хэвлэсэн огноо
2021.11.23	2021.11.25	2021.11.29


№	Шинжилсэн үзүүлэлт, нэгж	Зөвшөөрөгдхөх хэмжээ	Шинжилгээний аргын стандарт	Шинжилгээний дүн
1	Усны орчин	6.5-8.5	MNS ISO 10523:2001	7.7
2	Цахилгаан дамжуулэх чанар мСм/сем	1.0	MNS ISO 7888:1999	0.408
3	Өнгө, градус	20.0	MNS ISO 7888:2000	20.0
4	Ерөнхий хатуулаг, мг·экв/л	7.0	MNS 6778:2019	1.9
5	Кальци, мг/л	100.0	MNS 1097:1970	25.8
6	Магни, мг/л	30.0	MNS 1097:1970	0.7
7	Хлорид, мг/л	350.0	MNS 4424:200	3.5
8	Сульфат, мг/л	500.0	MNS 6271:2011	8.0
9	Аммони, мг/л	1.5	MNS 1097:1970	0.2
10	Нитрат, мг/л	50.0	MNS ISO 7890:2001	0.03
11	Төмөр, мг/л	0.3	MNS 4430:2005	0.0
12	Нитрит, мг/л	1.0	MNS 6778:2019	0.002
13	Фтор, мг/л	0.7-1.5	MNS 6272:2011	0.2

Тайлбар: Өмнөговь аймгийн Өмнөдэлгэр сумын худгийн ус

Сорилт гүйцэтгэсэн:

/Д. Ганбилэг, химич/

Хянасан:



/П. Гантуяа, чанарын менеджер/

Баталгаажуулсан:

/Д. Хишигбуян, лабораторийн Эрхлэгч



**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИ  
ХООЛ СУДЛАЛ, ШИМ ТЭЖЭЭЛИЙН ЛАБОРАТОРИ**

Калг: Улаанбаатар хот: Баянзүрх дүүрг: Занданшын зүйн чөлөө-17  
Утас: 976-11-452774

**СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС № 216**

Дээж ирүүлсэн байгууллага	Дээжийн нэр, хэмжээ	Дээжийн тодорхойлолт /шаардлагатай бол/	Дээж авсан огноо	Дээж ирүүлсэн огноо
Мон газар экологи XXX	1.5 л	Полизтилен саванд савласан ундын ус гэх	2021.11.20	2021.11.23

Шинжилгээ эхэлсэн огноо	Шинжилгээ дууссан огноо	Дүнгийн хуудас хэвлэсэн огноо
2021.11.23	2021.11.25	2021.11.29

№	Шинжилсэн үзүүлэлт, наажж	Зөвшииргэдэх хэмжээ	Шинжилгээний аргын стандарт	Шинжилгээний дүн
1.	Усны орчин	6.5-8.5	MNS ISO 10523:2001	7.3
2.	Цахилгаан дамжуулах чанар, мСи/см	1.0	MNS ISO 7888:1999	0.248
3.	Өнгө, градус	20.0	MNS ISO 7888:2000	20.0
4.	Ерөнхий хатуулаг, мг-экв/л	7.0	MNS 6778:2019	1.1
5.	Кальци, мг/л	100.0	MNS 1097:1970	18.0
6.	Магни, мг/л	30.0	MNS 1097:1970	2.4
7.	Хлорид, мг/л	350.0	MNS 4424:200	3.1
8.	Сульфат, мг/л	500.0	MNS 6271:2011	4.9
9.	Аммони, мг/л	1.5	MNS 1097:1970	0.03
10.	Нитрат, мг/л	50.0	MNS ISO 7890:2001	0.0
11.	Темпер, мг/л	0.3	MNS 4430:2005	0.04
12.	Нитрит, мг/л	1.0	MNS 6779:2019	0.002
13.	Фтор, мг/л	0.7-1.5	MNS 6272:2011	0.2

Тайлбар: Хурхын голын үс

Сорилт гүйцэтгэсэн:

/Д. Ганбилэг, химич/

Хянасан:

/П. Гантуяа, чанарын менежер/

Баталгаажуулсан:

/Д. Хишигбүян, лабораторийн  
Эрхлэгч

Энэ шинжилгээний дүн нь зөвлөн хурозн алсан дээжинд хамварна.  
Шинжилгээний дүнг лабораторийн захишиорелтгүү түүхэрлэлээг хориглоно.



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИ  
ХООЛ СУДЛАЛ, ШИМ ТЭЖЭЭЛИЙН ЛАБОРАТОРИ

Хакт. Улан-Батор хот. Баянзүрх дүүрэг. Энхийнбайсаны яргын чадвад-17.  
Утас: 876-11-452774

СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС № 215

Дээж ирүүлсэн байгууллага	Дээжийн нэр, хэмжээ	Дээжийн тодорхойлолт /шаардлагатай бол/	Дээж авсан огноо	Дээж ирүүлсэн огноо
"Мон газар экология" ХХК	15 л	Полиизтилен саланд савласан гадаргын ус гэх	2021.11.20	2021.11.23

Шинжилгээ эхэлсэн огноо	Шинжилгээ дууссан огноо	Дунгийн хуудас хавлэсэн огноо
2021.11.23	2021.11.25	2021.11.29

No.	Шинжилсэн үзүүлэлт, нэгж	Зөвшөөрөгдхөн хэмжээ	Шинжилгээний аргын стандарт	Шинжилгээний дүн
1	Усны орчин	6.5-8.5	MNS ISO 10523:2001	8.1
2	Цахилгаан давхжуулах чанар, мСм/см	1.0	MNS ISO 7888:1999	0.224
3	Өнгө, градус	20.0	MNS ISO 7888:2000	25
4	Ервижийн хатуулагч, мг-экв/л	7.0	MNS 6778:2019	1.1
5	Кальций, мг/л	100.0	MNS 1097:1970	14.0
6	Магни, мг/л	30.0	MNS 1097:1970	4.2
7	Хлорид, мг/л	350.0	MNS 4424:200	3.1
8	Сульфат, мг/л	500.0	MNS 6271:2011	1.1
9	Аммони, мг/л	1.5	MNS 1097:1970	0.06
10	Нитрат, мг/л	50.0	MNS ISO 7890:2001	0.0
11	Темпер, мг/л	0.3	MNS 4430:2005	0.0
12	Нитрит, мг/л	1.0	MNS 6779:2019	0.003
13	Фтор, мг/л	0.7-1.5	MNS 6272:2011	0.0

## Союлт гүйцэтгэсэн:


/Д.Ганбилэг, химич/

## Хиасанъ


/П.Гантуяа, чанарын менежер/

### Баталгаажуулсан:

/Д.Хишигбуян, лабораторийн  
Эрхлэгч




Энэ цинийгүйн дун нь зөвхөн хугацн авсан дээжинд хамаарна. Цинийгүйн дунг лэвсөөгүйн зөвшөөрөлтүү гүйлбэрлэхэд хөглигүй




## ХЭНТИЙ АЙМГИЙН БИНДЭР, ӨМНӨДЭЛГЭР, БАТШИРЭЭТ СУМДЫН НУТГИЙГ ДАЙРАН ӨНГӨРӨХ "ӨМНӨДЭЛГЭР-БИНДЭР-115 КМ ХАТУУ ХҮЧИЛТТАЙ АВТОЗАМ БАЙГУУЛАХ" ЗУРВАС ГАЗРЫН БАЙРШЛЫН ЗУРАГ

Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн байгууллага болох  
"Мон Газар Экологи" ХХК-д боловсруулав.


1:450,000






Таних тэмдэг

— Төлөвлөж буй замын трасс



## ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗРУУД




№	Дурсгалын дугаар	Солбигол	Хэмжээ (см)	Дурсгалын төрөл
1	Дурсгал-01	48 32 58.6	110 33 44.6	400x500 см
2	Дурсгал-02	48 30 22.4	110 24 41.0	200x150 см
3	Дурсгал-03	48 28 59.2	110 23 06.6	350x350 см
4	Дурсгал-04	48 29 24.9	110 23 40.5	400x350 см
5	Дурсгал-05	48 29 24.6	110 23 40.6	500x500 см
6	Дурсгал-06	48 29 24.3	110 23 40.7	540x520 см
7	Дурсгал-07	48 29 24.1	110 23 40.9	500x500 см
8	Дурсгал-08	48 27 43.6	110 20 05.8	600x500 см
9	Дурсгал-09	48 27 43.8	110 20 06.2	300x250 см
10	Дурсгал-10	48 27 43.5	110 20 06.1	400x300 см
11	Дурсгал-11	48 24 55.5	110 17 38.6	Голч-1500 см Хүрээ-1800 см
12	Дурсгал-12	48 24 54.9	110 17 37.4	400x500 см
13	Дурсгал-13	48 24 54.7	110 17 37.4	450x500 см
14	Дурсгал-14	48 22 44.9	110 18 09.6	600x500 см
15	Дурсгал-15	48 22 44.7	110 18 09.0	200x300 см
16	Дурсгал-16	48 22 44.6	110 18 08.6	200x250 см
17	Дурсгал-17	48 22 45.0	110 18 08.8	Голч-800 см Хүрээ-1000 см
18	Дурсгал-18	48 22 45.3	110 18 09.3	250x150 см
19	Дурсгал-19	48 22 45.5	110 18 09.1	200x150 см
20	Дурсгал-20	48 22 45.5	110 18 09.0	200x300 см
21	Дурсгал-21	48 22 45.5	110 18 08.2	300x250 см
22	Дурсгал-22	48 22 45.2	110 18 08.6	250x200 см
23	Дурсгал-23	48 22 45.2	110 18 08.4	200x200 см
24	Дурсгал-24	48 22 45.0	110 18 08.2	400x300 см
25	Дурсгал-25	48 22 44.8	110 18 07.7	Голч-500 см Хүрээ-700x600 см
26	Дурсгал-26	48 22 28.2	110 17 30.7	200x250 см
27	Дурсгал-27	48 22 28.1	110 17 30.4	300x350 см
28	Дурсгал-28	48 22 28.0	110 17 28.9	I: 82x39x20 см II: 70x38x17 см III: 55x39x15 см
29	Дурсгал-29	48 22 13.9	110 16 39.1	Голч-1000 см Хүрээ-2000 см
30	Дурсгал-30	48 22 05.4	110 16 02.9	Голч-1000 см Хүрээ-2800 см
31	Дурсгал-31	48 22 03.1	110 15 45.6	500x600 см
32	Дурсгал-32	48 22 03.0	110 15 45.8	Хэзэй хашлагын булш
33	Дурсгал-33	48 09 33.8	110 00 48.4	Булш
34	Дурсгал-34	48 09 34.6	110 00 47.9	Голч-700 см, хүрээ-2100 см
35	Дурсгал-35	48 09 35.0	110 00 47.7	Хиргисүүр
36	Дурсгал-36	48 09 34.9	110 00 47.3	Чулуун байгууламж
37	Дурсгал-37	48 09 34.7	110 00 47.1	Булш
38	Дурсгал-38	48 07 11.7	109 54 04.8	Туурь
39	Дурсгал-39	48 07 02.7	109 53 56.2	Шороон байгууламж
40	Дурсгал-40	48 07 01.5	109 53 55.3	Туурь
41	Дурсгал-41	48 22 44.1	110 17 56.27	Чулуун зэвсэг

### Таних тэмдэг

- Замын трассын дагуу бүртгэгдсэн дурсгалууд
- Төлөвлөж буй зам
- ◎ Сумын төв
- Сумын хил

## УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ



## ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ

